



Хууль зүй, дотоод
хэргийн яам



“Шүүх, эрх зүйн
шинэчлэлт” төсөл

ЭКОНОМИКСИЙН ҮНДЭС

Гарын авлага

Боловсруулсан: Ц.Даваадорж
Г.Болормаа
С.Багтулга

Редактор: Ц. Даваадорж

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас
хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар
2007

DDC
330'023
Д-121

Экономиксийн үндэс
Гарын авлага

Хөтөлбөр боловсруулсан:

Зөвлөх: Ц.Даваадорж (*Эдийн засгийн ухааны доктор, Ph.D*)
Г.Болормаа (*Эдийн засгийн магистр*)

Гарын авлага боловсруулсан:

Зөвлөх: Ц.Даваадорж (*Эдийн засгийн ухааны доктор, Ph.D*)

Редактор: Ц.Даваадорж (*Эдийн засгийн ухааны доктор, Ph.D*)

Багийн гишүүд:

Ц.Даваадорж (*Эдийн засгийн ухааны доктор, Ph.D*)

Г.Болормаа (*Эдийн засгийн магистр*)

Б.Баттулга (*Эдийн засгийн магистр*)

Хэвлэлийн хэмжээ: 8.5 х.х

Номын хэмжээ: 70х100/16

Хэвлэсэн газар: “Содпресс” ХХК

ISBN: 978-99929-54-33-7



“ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад



Төслийн зохицуулагч
Д.ОЮУНЧИМЭГ

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа. Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм. Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж бүтээе, өөрийгөө боловсруулъя гэсэн эрмэлзэлтэй залуу багш нарыг баг болгон оролцуулсан юм. Энэ гарын авлагыг бүтээх явцад багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



Төслийн зөвлөх
У.ТУУЯ

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:


- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

БАГИЙН ТАНИЛЦУУЛГА



Цэнддаваагийн Даваадорж нь 1983 онд МУИС-ийн ЭЗФ-ын статистикийн ангийг, 1995 онд Японы Шигагийн Их сургуулийн магистрантур, 1998 онд Киотогийн Их сургуулийн докторантур суралцаж төгссөн. Одоо МУИС-ийн дэргэдэх Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн дэд захирал, ЭЗС-ийн Экономиксийн тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байна. Нийтдээ 15 ном бичиж, редакторласан. 20 орчим өгүүлэл нийтлүүлж, 10 орчим илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Судалгааны гол чиглэл нь макро эдийн засгийн тэнцвэржилт, газрын эдийн засаг, улс орны эдийн засгийн түүх болно.

И-мэйл: davaadorj@ses.edu.mn



Ганболдын Болормаа нь 1996-2000 онд Эдийн засгийн онолын бакалавр (Ecop), 2000-2002 онд Эдийн засгийн онолын магистр (Ecop) суралцаж төгссөн. Одоо МУИС, ЭЗС-ийн экономиксийн тэнхимийн багшаар ажиллаж байна. Судалгааны гол чиглэл нь эдийн засгийн бодёого, эдийн засгийн сэтгэлгээний түүх. Нийтдээ 3 ном бичилцэж, хэд хэдэн өгүүлэл тууригсан.

И-мэйл: bolor76@ses.edu.mn



ӨМНӨХ ҮГ

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд эрх зүйн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажил явагдсан билээ. Эрх зүйчдэд зайлшгүй шаардлагатай мэдээгийн дотор эдийн засгийн мэдлэг багтана. Энэ утгаараа экономиксийн хичээлийг заах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажил хийгдлээ. “Экономиксийн үндэс” хичээлийн хөтөлбөрийг МУИС-ийн ЭЗС-ийн Экономиксийн тэнхмийн эрхлэгч, доктор Ц.Даваадорж, багш Г.Болормаа нар 2005-2006 оны хичээлийн жилд боловсруулж, Отгонтэнгэр ИС болон МУИС-ийн Хууль зүйн сургууль дээр туршиж үзсэн болно. Ингээд туршилтаар гарсан үр дүнг оруулж, засварлан 2006-2007 оны хичээлийн жилд сайжруулсан хувилбарыг гаргалаа.

Энэ хөтөлбөрийн дагуу уг хичээлийг судлахад дөхөм болох үүднээс гарын авлагыг боловсруулав. Гарын авлагыг ашиглахдаа уг хичээлийн хөтөлбөртэй эхлээд танилцах нь зүйтэй.

Гарын авлага нь хөтөлбөрийн агуулгыг ойлгоход чиглэгдсэн бөгөөд ашиглахад хамгийн хялбар, мөн эх хэлээр гарсан нэмж унших материалыг сэдэв бүрт зааж өгснөөрөө онцлог болсон.

Оюутан энэ хичээлийн сэдэв бүрийг урьдчлан уншиж, ойлгоогүй зүйлээ хичээлийн явцад тайлбарлуулах, мөн өөрийгөө сорьж гарын авлагад байгаа хяналтын асуудлуудыг бөглөх, бодлогыг бодох боломжтой.

Монгол хэлээр гарсан сурах бичиг, гарын авлагыг зааж өгснөөрөө тухайн оюутны бие даан судлах боломжийг дээшлүүлж, цаг хэмнэх бололцоо олгож байгаа юм. Хичээл нь хөтөлбөрт тусгагдсан агуулга, дарааллаар явагдах бөгөөд оюутан гарын авлагатай эхлээд танилцсан гэсэн нөхцөлтэйгөөр заагдах учир цагийг илүү үр бүтээлтэй ашиглах боломж олгоно.

Гарын авлагыг ашиглаж байх явцад ойлгомжгүй, бүрхэг зүйл гарваас тухайн сэдвийн эцэст зааж өгсөн нэмэлт сурах бичиг, материалыг уншаад тодруулж болохоос гадна хичээлийн явцад багшаар тайлбарлуулах, нөхөдтэйгөө санал солилцох байдлаар ярилцаж ойлгож авах ч арга байдаг.

Нийгмийн амьдрал хөгжиж, онолын ойлголт ч баяжиж байдаг тул энэхүү гарын авлагыг ч сайжруулах, орхигдсон, дутуу зүйлийг нэмэх шаардлага гарах нь зүй ёсны асуудал билээ. Бид ч энэ шаардлагыг биелүүлэхэд бэлэн байна.

Ц.Даваадорж

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
БАГИЙН ТАНИЛЦУУЛГА	4
ӨМНӨХ ҮГ	5
“ЭКОНОМИКСИЙН ҮНДЭС” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР	
1. Экономиксийн үндэс хичээлийн танилцуулга	7
2. Экономиксийн үндэс хичээлийн хөтөлбөрийн агуулга	9
3. “Эдийн засгийн онолын үндэс” хичээлийн заах арга зүй	28
4. Эдийн засгийн онолын үндэс хичээлийн үнэлгээ	29
ЭКОНОМИКСИЙН ҮНДЭС ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	
I бүлэг. ЭДИЙН ЗАСГИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ТОЙМ	
1. Эдийн засаг гэж юу вэ?	33
2. Эдийн засгийн тогтолцоо	35
3. Микроэкономиксийн үндэс, зах зээлийн эдийн засаг	38
4. Бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөөний хэлбэрүүдийн ялгаа, онцлог	40
II бүлэг. ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ	
1. Хэрэглэгчийн сонголт ба эрэлт	43
2. Хэрэглэгчийн ба зах зээлийн эрэлт болон пүүсийн эрэлт, эрэлтийн мэдрэмж, түүний хэрэглээ	46
3. Нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэр	51
4. Нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэрийн хэлбэрүүд	55
III бүлэг: ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД	
1. Бизнесийн нэгжүүд ба өрх гэрүүд	59
2. Пүүсийн зардал, ашиг	61
3. Менежментийн тухай ойлголт	64
4. Маркетингийн тухай ойлголт	66
5. Хүчин зүйлсийн зах зээл: хөдөлмөр, капитал, газар	68
IV бүлэг. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, АСУУДЛУУД	
1. Үндэсний тооцооны систем	72
2. Монгол улсын эдийн засгийн өсөлт, түүнтэй холбоотой асуудлууд	74
3. Эдийн засгийн хөгжлийн ялгаа, хэрэглээ ба хадгаламж, хөрөнгийн оруулалт	76
4. Ажилгүйдэл ба инфляци	79
5. Монгол орны ажилгүйдэл ба инфляци, эдийн засгийн шилжилт	81
6. Сангийн бодлого, татвар	83
7. Татвар, түүний нийгэм эдийн засаг дахь нөлөөлөл	85
8. Эдийн засаг дахь орлогын дахин хуваарилалт, ядуурал, ядуурлыг бууруулах аргууд	88
9. Мөнгө, Мөнгөний бодлого	90
10. Мөнгө, санхүүгийн зах зээл	92
V бүлэг: ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА	
1. Гадаад худалдаа, гадаад худалдааны асуудлууд	94
2. Валютын ханш, валютын ханшны бодлого	96
3. Монгол улсын гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого, стратеги	97
VI бүлэг: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДЛУУД	
1. Глобалчлал, байгаль экологийн асуудлууд, тогтвортой хөгжлийн асуудлууд	99
2. Монгол улсын хүний хөгжил, түүнтэй холбоотой асуудлууд	101



“ЭКОНОМИКСИЙН ҮНДЭС ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

“Экономиксийн үндэс” хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр:	Экономиксийн үндэс
Индекс:	ECON100
Кредит:	3
Үзэх семестр:	намрын улирал
Залгамж холбоо:	ЕБС-ийн нийгмийн тухай мэдлэг, математик
Үнэлгээ:	Оюутан, нийт үнэлгээний 60 хувийг хичээлийн явцын идэвх, оролцоо, бие даалтын ажил, явцын шалгалт, шүүлгээр, харин үлдэх 40 хувийг улирлын шалгалтаар цуглуулна.

“Экономиксийн үндэс” хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага

Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж эхлээд, өмчийн олон хэлбэрт эдийн засгийн харилцаа бүхий нийгмийн байгууламжтай боллоо. Энэхүү нийгмийн байгууламж нь эдийн засгийн олон төрлийн харилцааг агуулж байгаа бөгөөд тэрхүү харилцаанд хүн бүр, байгууллага, нэгж бүр оролцдог. Эдийн засгийн эл харилцаанд оролцохдоо эдийн засгийн тодорхой мэдлэгтэй байх нь оролцогчдын үйл хөдлөл оновчтой болох, улмаар улс орны хөгжлийн хурдац дээшлэхэд чухал нөхцөл болох юм. Эдийн засгийн үйл хөдлөлийн мөн чанарыг ойлгох, улмаар уг харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтын харилцан хамаарлыг олж мэдэхэд энэ хичээл туслах болно.

Микро ба макро түвшний эдийн засгийн үйл хөдлөлийн хамаарал, мөн чанарыг мэдсэнээр уг харилцааны эрх зүйн зохицуулалтыг зөв, үр нөлөөтэй тогтоох, эдийн засгийн өсөлтөнд эрх зүйн зохицуулалтын үзүүлэх нөлөөг бодитой олж харах чадвар эзэмших учраас “Экономиксийн үндэс” хичээлийг зайлшгүй үзэх шаардлагатай.

“Экономиксийн үндэс” хичээлийн зорилго

Экономиксийн суурь мэдлэгтэй болж, эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалтын үндсэн мөн чанарыг тайлбарлах чадвар эзэмших болно. “Экономиксийн үндэс” хичээл нь эрх зүйн мэргэжилтэн болох оюутанд эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг бодитой, зөв, үр нөлөөтэй тогтоох эрмэлзлэл төлөвшүүлэхэд туслана.

“Экономиксийн үндэс” хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, танхимд үзэх цаг хуваарилалт

№	Бүлэг	Сэдвүүд	Хичээлийн хэлбэр	Цаг
1	Эдийн засгийн тухай ерөнхий тойм	1 Эдийн засаг гэж юу вэ?	лекц	2 цаг
		2 Эдийн засгийн тогтолцоо	семинар	2 цаг
		3 Микроэкономиксийн үндэс, зах зээлийн эдийн засаг	лекц	2 цаг
		4 Бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөөний хэлбэрүүдийн ялгаа, онцлог	семинар	2 цаг

2	Эрэлт ба нийлүүлэлт	1	Хэрэглэгчийн сонголт ба эрэлт	лекц	2 цаг
		2	Хэрэглэгчийн ба зах зээлийн эрэлт болон пүүсийн эрэлт, эрэлтийн мэдрэмж, түүний хэрэглээ	семинар	2 цаг
		3	Нийлүүлэлт, эдийн засгийн тэнцвэр	лекц	2 цаг
		4	Нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэрийн хэлбэрүүд	семинар	2 цаг
3	Эдийн засгийн харилцаанд оролцогч талууд	1	Бизнесийн нэгжүүд ба өрх гэрүүд	семинар	2 цаг
		2	Пүүс, пүүсийн зардал, ашиг	лекц семинар	2 цаг
		3	Менежментийн тухай ойлголт	лекц семинар	2 цаг
		4	Маркетингийн тухай ойлголт	лекц семинар	2 цаг
		5	Хүчин зүйлсийн зах зээл: хөдөлмөр, капиталын зах зээл	лекц семинар	2 цаг
4	Макро эдийн засгийн үзүүлэлт, асуудлууд	1	Үндэсний тооцооны систем	лекц	2 цаг
		2	Монгол улсын эдийн засгийн өсөлт, түүнтэй холбоотой асуудлууд	семинар	2 цаг
		3	Эдийн засгийн хөгжлийн ялгаа, хэрэглээ ба хадгаламж, хөрөнгө оруулалт	лекц	2 цаг
		4	Ажилгүйдэл ба инфляци	лекц	2 цаг
		5	Монгол орны ажилгүйдэл, инфляци, эдийн засгийн шилжилт	семинар	2 цаг
		6	Сангийн бодлого, татвар	лекц	2 цаг
		7	Татвар, нийгэм эдийн засаг дахь татварын нөлөөлөл	семинар	2 цаг
		8	Эдийн засаг дахь орлогын дахин хуваарилалт, ядуурал, ядуурлыг бууруулах аргууд	семинар	2 цаг
		9	Мөнгө, Мөнгөний бодлого	лекц	2 цаг
		10	Мөнгө, санхүүгийн зах зээл	семинар	2 цаг
5	Олон улсын худалдаа	1	Гадаад худалдаа, гадаад худалдааны асуудлууд	лекц	2 цаг
		2	Валютын ханш, валютын ханшны бодлого	семинар	2 цаг
		3	Монгол улсын гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого, стратеги	семинар	2 цаг
6	Эдийн засгийн хөгжил	1	Глобалчлал, байгаль экологийн асуудлууд. Тогтвортой хөгжлийн асуудлууд	лекц	2 цаг
		2	Монгол улсын хүний хөгжил, түүнтэй холбоотой асуудлууд	лекц	2 цаг
			Нийт цаг		64



2. “Экономиксийн үндэс” хичээлийн хөтөлбөрийн агуулга

I бүлэг: ЭДИЙН ЗАСГИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ТОЙМ

Бүлгийн зорилго: Эдийн засгийн тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийн харилцан хамаарлын талаар мэдлэгтэй болж, эдийн засгийн суурь ойлголтыг тайлбарлах чадвар эзэмшин, улс орныхоо эдийн засгийн нөхцөл байдлыг ойлгох эрмэлзлэлтэй болгоход оршино.

1 .Эдийн засаг гэж юу вэ?

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Экономиксийн гэж юу болох, экономиксийг судлах хэрэгцээ, шаардлага, эрх зүй болон экономиксийн уялдаа холбооны талаар мэдэж авах, эдийн засгийн үндсэн ухагдахуунуудыг ойлгож, томъёолох чадвартай болох эхний алхмыг тавих, улмаар эдийн засаг ба эрх зүйн холбоог гүнзгийрүүлэн судлах эрмэлзлэлтэй болоход чиглэнэ.



Нэр томъёо

- ▲ эдийн засаг
- ▲ нөөц, хүчин зүйлс
- ▲ хэрэгцээ
- ▲ зах зээл
- ▲ эдийн засгийн агент
- ▲ эдийн засгийн төөрөгдлүүд
- ▲ эрх зүй
- ▲ позитив эдийн засаг
- ▲ норматив эдийн засаг
- ▲ үйлдвэрлэлийн боломжийн хязгаар



Сэдвийн агуулга

- ▲ Эдийн засаг ба экономиксийн тухай
- ▲ Эдийн засгийн нөөц буюу үйлдвэрлэлийн хүчин зүйлс
- ▲ Эдийн засгийн үндсэн асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх
- ▲ Эдийн засагт үүсдэг төөрөгдлүүд, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт
- ▲ Үйлдвэрлэлийн боломж, үйлдвэрлэлийн боломжийн хязгаар

2. Эдийн засгийн тогтолцоо

Хичээлийн хэлбэр: Семинар

- ▲ **Сэдвийн зорилго:** Эдийн засгийн тогтолцоо, түүний хэлбэрийн талаар болон эдийн засаг дахь төрийн оролцооны талаар суурь мэдлэгтэй болж, улс орнуудын эдийн засгийн тогтолцоог таньж мэдэх, эдийн засаг дахь төрийн оролцооны эерэг, сөрөг талыг үнэлэх

чадвар эзэмшинэ. Эдийн засгийн тогтолцоо, төрийн оролцооноос хамаарч үүсэх гажуудлууд, төөрөгдлүүдийг ялгаж ойлгосноор оюутан өөрийн орны эдийн засгийн тогтолцооны мөн чанар, сайн, муу талыг тодорхойлох, төрийн эдийн засгийн үүрэг ролийг зөв үнэлж, эрх зүйн харилцааны зөв тогтолцоог ойлгох эрмэлзлэл төлөвшихөд туслана.



Нэр томъёо

- ▲ Уламжлалт эдийн засаг
- ▲ Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг
- ▲ Зах зээлийн эдийн засаг
- ▲ Холимог эдийн засаг
- ▲ Үйлдвэрлэгч
- ▲ Хэрэглэгч
- ▲ Хөндлөнгийн оролцоо
- ▲ Татвар
- ▲ Засгийн газар, төр
- ▲ Орлогын дахин хуваарилалт
- ▲ Татаас
- ▲ Эдийн засгийн эрх чөлөө



Сэдвийн агуулга

- ▲ Эдийн засгийн тогтолцоо
- ▲ Уламжлалт болон төвлөрсөн төлөвлөгөө тэдийн засгийн тогтолцооны сул ба давуу талууд
- ▲ Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, холимог эдийн засаг, тэдгээрийн ялгаа, сул ба давуу талууд
- ▲ Эдийн засгийн үйл ажиллагаанд төр оролцох шаардлага, Засгийн газар, түүний үүрэг
- ▲ Эдийн засгийн эрх чөлөө, төрийн оролцооны гажуудал (government failure)
- ▲ Эдийн засгийн тогтвортой байдал
- ▲ Татвар болон татаас олгогдох нөхцөл
- ▲ Тэгш байдал, орлогын дахин хуваарилалт
- ▲ Монголын эдийн засгийн тогтолцоо, түүхэн хандлага, эдийн засгийн онцлог

3. Микро экономиксийн үндэс, зах зээлийн эдийн засаг

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Зах зээлийн эдийн засгийн тогтолцооны мөн чанар, давуу болон сул талыг мэдэх, өрсөлдөөн, түүний хэлбэрүүд, өмч, өмчлөлийн талаар эдийн засгийн мэдлэгтэй болох, тухайн зах зээлийн шинжийг тодорхойлох, эдийн засгийн агентуудын зорилгыг тодорхойлох анхан шатны чадвартай болно.



Нэр томъёо

- ▲ өрсөлдөөн
- ▲ монополь
- ▲ монопольт өрсөлдөөн
- ▲ олигополь
- ▲ төрөлжилт
- ▲ баялаг
- ▲ хувийн өмч



Сэдвийн агуулга

- ▲ Зах зээл ба үнэ, төгс өрсөлдөөнт зах зээл
- ▲ Эдийн засгийн агентуудын зорилго, зорилгыг тодорхойлох хүчин зүйлс
- ▲ Хүчин зүйлсийн төрөлжилт
- ▲ Өмч, өмчийн хэлбэрүүд
- ▲ Өрсөлдөөн, өрсөлдөөний хэлбэрүүд,

4. Бүгээгдэхүүний зах зээлийн өрсөлдөөн, өрсөлдөөний хэлбэрүүдийн ялгаа, онцлог

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Зах зээлийн өрсөлдөөний шинж чанар, бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгч пүүс, салбаруудын ялгааны талаар мэдлэгтэй болж, тухайн зах зээл дээрх өрсөлдөөний явцад пүүс зардал, ашгаа тодорхойлох аргачлалыг мэдсэнээр түүнийг тооцох чадвар эзэмшинэ. Өрсөлдөөнтэй холбоотой үүсэх асуудлуудыг мэдэж, тэдгээрийг шийдвэрлэх аргуудтай танилцан, эрх зүйн зохицуулалтыг зөв тогтоох эрмэлзлэлтэй болоход туслана.



Нэр томъёо

- ▲ Зар сурталчилгаа
- ▲ Картель
- ▲ Лиценз (онцгой эрх)
- ▲ ОПЕК
- ▲ Хуйвалдаан
- ▲ Тэргүүлэгч
- ▲ Дагалдагч



Сэдвийн агуулга

- ▲ Цэвэр монополь, аргагүй монополь
- ▲ Монопольт өрсөлдөөн ба зар сурталчилгаа
- ▲ Үнийн ялгаварлал
- ▲ Нийгмийн нийт үр ашиг
- ▲ Олигополь, түүнтэй холбоотой үүсэх асуудлууд

I бүлэг: ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ

Бүлгийн зорилго: Зах зээлийнүйл явцийн гол механизм болох эрэлт, нийлүүлэлт, тэдгээрийн харилцан үйлчлэл, мөн зах зээлийн харилцаанд оролцогч талууд болох хэрэглэгч ба пүүсүүдийн үйл хөдлөл, тэдгээрт нөлөөлдөг бусад хүчин зүйлсийн талаар мэдлэгтэй болж, бараа бүтээгдэхүүний болон пүүс, салбарын эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох чадвар эзэмшин, зах зээлийн харилцааг зөвөөр ойлгох эрмэлзлэлтэй болно.

1. Хэрэглэгчийн сонголт ба эрэлт

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Хэрэглэгч, зах зээл дээр бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн худалдан авдаг, худалдан авах бүтээгдэхүүнийхээ хэмжээг яаж тодорхойлж болох талаар онолын мэдэүгтэй болж, өөрийнхөө болон гэр бүлийнхээ хэрэглээг тооцох чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ таашаал
- ▲ ханамж
- ▲ ахиу ханамж
- ▲ эрэлт
- ▲ эрэлтийн муруй
- ▲ эрэлтийн хууль



Сэдвийн агуулга

- ▲ Хэрэглэгчийн таашаал, ханамж
- ▲ Хэрэглэгчийн ахиу ханамж буурах хууль
- ▲ Бараа ба бүтээгдэхүүний тухай, орлуулдаг, хослуулдаг бүтээгдэхүүн
- ▲ Бүтээгдэхүүний, үйлчилгээний тоо хэмжээ
- ▲ Хэрэглэгчийн орлого ба худалдан авалт
- ▲ Хэрэглэгчийн эрэлт
- ▲ Эрэлтийн функц ба эрэлтийн муруй

2. Хэрэглэгчийн ба зах зээлийн эрэлт болон пүүсийн эрэлт, эрэлтийн мэдрэмж, түүний хэрэглээ

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Бараа, бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт ба пүүсийн эрэлтийг тодорхойлох, эрэлт болон үнийн хоорондын хамаарлаас тэдгээрийн шийдвэр гаргалтыг хэрхэн хийдэг, пүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд эрэлтийн хүчин зүйлсээ яаж өөрчлөх зэргийн талаар мэддэгтэй болж, эрэлт, эрэлтийн мэдрэмжийг тооцох чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Зах зээлийн эрэлт
- ▲ Пүүсийн эрэлт
- ▲ Мэдрэмж
- ▲ Чанар муутай буюу дорд бараа
- ▲ Хэвийн бараа
- ▲ Энгийн бараа
- ▲ Гиффен бараа



Сэдвийн агуулга

- ▲ Зах зээлийн ба пүүсийн эрэлт
- ▲ Эрэлтийн мэдрэмж, тэдгээрийн хэлбэрүүд
- ▲ Үнийн мэдрэмж ба пүүсийн орлого
- ▲ Бараа бүтээгдэхүүнийг мэдрэмжээр нь ангилах

3. Нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэр

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Зах зээлийн нэгэн оролцогч болох пүүс нь үйлдвэрлэлийнхээ хэмжээг хэрхэн тогтоодог талаар онолын мэдлэгтэй болох, зах зээлийн тэнцвэр яагаад тогтдогийг тайлбарлах чадвар эзэмшин, зах зээл дэх пүүсийн үйл хөдлөлийг зөв үнэлэх эрмэлзлэлтэй болно.



Нэр томъёо

- ▲ Пүүс
- ▲ ашиг
- ▲ нийлүүлэлт
- ▲ нийлүүлэлтийн хууль
- ▲ татвар
- ▲ татаас
- ▲ үнийн тааз
- ▲ үнийн шал



Сэдвийн агуулга

- ▲ Нийлүүлэлт, нийлүүлэлтийн хууль
- ▲ Нийлүүлэлтэд нөлөөлдөг хүчин зүйлс
- ▲ Зах зээлийн тэнцвэр: тэнцвэрт үнэ, тэнцвэрт хэмжээ
- ▲ Тэнцвэрийн өөрчлөлт
- ▲ Засгийн газар тэнцвэрт нөлөөлөх нь
- ▲ Татвар, татаас
- ▲ Үнийн тааз, үнийн шал

4. Нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэрийн хэлбэрүүд

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Пүүсийн болон зах зээлийн нийлүүлэлтийн, бараа бүтээгдэхүүний зах зээлийн тэнцвэрийн хэлбэрүүдийн талаар мэдээгтэй, олон тэнцвэр тогтох нөхцөл болон тэнцвэр тогтохгүй байх нөхцөлийг тайлбарлах чадвартай болж, эрэлт, нийлүүлэлт, тэдгээрийн тэнцвэрийг зөв үнэлэх эрмэлзлэлтэй болно.



Нэр томъёо

- ▲ Эрэлт ба нийлүүлэлтийн илүүдэл
- ▲ Эрэлт ба нийлүүлэлтийн хомсдол
- ▲ Хэрэглэгчийн хожоо
- ▲ Үйлдвэрлэгчийн хожоо
- ▲ Орлогын нөлөө
- ▲ Тоо хэмжээний нөлөө
- ▲ Хөдөлмөрийн хэмжээ



Сэдвийн агуулга

- ▲ Илүүдэл эрэлт, илүүдэл нийлүүлэлт, эрэлт ба нийлүүлэлтийн хомсдол
- ▲ Хэрэглэгчийн хожоо
- ▲ Үйлдвэрлэгчийн хожоо
- ▲ Орлогын нөлөө
- ▲ Тоо хэмжээний нөлөө
- ▲ Олон тэнцвэртэй зах зээл
- ▲ Зах зээлд тэнцвэр тогтохгүй байх нөхцөл
- ▲ Хөдөлмөрийн зах зээлийн жишээ
- ▲ Зах зээлийн гажуудал (market failure)

III бүлэг: ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Бүлгийн зорилго: Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүрэг, оролцогчдын харилцан хамаарлын талаар суурь мэдээгтэй болж, тэдгээрийн үйл хөдөөлтэй холбоотой асуудлуудыг эдийн засгийн үүднээс тайлбарлах чадвар эзэмшинэ. Эдийн засгийн харилцаанд оролцогчдын үйл хөдөөлийг зөв үнэлж, эрх зүйн зохицуулалтыг ойлгох эрмэлзлэл төрүүлэхэд чиглэнэ.

1. Бизнесийн нэгжүүд ба өрх гэрүүд

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Зах зээлийн эдийн засгийн харилцаанд оролцогчид, тэдгээр талуудын зорилго, үүрэг, хариуцаага, тэдгээрт учрах саад бэрхшээл болон давуу талуудын талаар онолын суурь мэдлэг эзэмшин, өрх гэр, бизнесийн нэгжүүдийн харилцааг тайлбарлах чадвартай болно.



Нэр томъёо

- ▲ Эдийн засгийн орчин
- ▲ Бизнесийн нэгж
- ▲ Өрх гэрүүд
- ▲ Үр өгөөж буурах хууль
- ▲ Хувь хүн
- ▲ орлого
- ▲ бүтээмж



Сэдвийн агуулга

- ▲ Эдийн засгийн орчин ба хураангуй загвар
- ▲ Бизнесийн нэгжүүд, тэдгээрийн зорилго
- ▲ Пүүсийн орлого, түүний тооцооны хэлбэрүүд: нийт, дундаж, ахиу
- ▲ Өрх гэрүүд
- ▲ Бүтээмж, үр өгөөж буурах хууль, уг хууль пүүсийн зорилготой хэрхэн уялддаг болох
- ▲ Үйлдвэрлэлийн хугацаа

2. Пүүсийн зардал, ашиг

Хичээлийн хэлбэр: Лекц, семинар

Сэдвийн зорилго: Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэгч пүүсүүдийн үйл ажиллагааны зардлууд, үйлдвэрлэлийн эдийн засгийн болон тооцооны ашиг, хэвийн ашиг зэргийн талаар үндсэн мэдлэгтэй болж, пүүсийн зардал, орлого, ашгийг тооцох чадвар эзэмшин, тооцоог үнэн зөв гаргах эрмэлзлэл төлөвшүүлнэ.



Нэр томъёо

- ▲ Зардал
- ▲ Тогтмол зардал
- ▲ Дундаж зардлууд
- ▲ Ахиу зардал
- ▲ Орлого
- ▲ Ашиг
- ▲ Эдийн засгийн ашиг
- ▲ Тооцооны ашиг



Сэдвийн агуулга

- ▲ Үйлдвэрлэлийн богино ба урт хугацаа
- ▲ Нийт зардал, хувьсах ба тогтмол зардал
- ▲ Пүүсийн богино ба урт хугацааны зардлууд: нийт зардал, дундаж ба ахиу зардал
- ▲ Пүүсийн ашиг: хэвийн ашиг, эдийн засгийн ба тооцооны ашиг
- ▲ Ашгийн тооцооллын хэлбэрүүд: нийт, дундаж, ахиу
- ▲ Ашиг хамгийн их байх нөхцөл

3. Менежментийн тухай ойлголт

Хичээлийн хэлбэр: Лекц, семинар

Сэдвийн зорилго: Менежментийн тухай үндсэн мэддэгтэй болж, пүүсийн үйл ажиллагааг амжилттай явуулахад шаарддагатай гол үзүүлэлтүүд, тэдгээрийн уялдаа холбоог тодорхойлох чадвартай болно.



Нэр томъёо

- ▲ Менежмент
- ▲ Зорилго
- ▲ Зорилт
- ▲ Зохион байгуулалт
- ▲ Төлөвлөлт
- ▲ Шийдвэр гаргалт
- ▲ Хяналт



Сэдвийн агуулга

- ▲ Хувь хүмүүсийн төлөвлөлтийн тухай
- ▲ Амжилтанд хүрсэн зарим нэг пүүс компаний түүхээс
- ▲ Менежментийн тухай ойлголт
- ▲ Менежмент гэж юу вэ?
- ▲ Менежментийн функц, тэдгээрийн уялдаа холбоо
- ▲ Менежер, түүний пүүст үзүүлэх нөлөө

4. Маркетингийн тухай ойлголт

Хичээлийн хэлбэр: Лекц, семинар

Сэдвийн зорилго: Маркетингийн талаар үндсэн мэддэгтэй болж, зөвхөн бизнесийн нэгжийн хувьд төдийгүй хувь хүмүүс, өрх гэрүүдийн шийдвэр гаргалтад маркетингийг хэрхэн ашиглах аргыг эзэмшин, тайлбарлах чадвартай болно.



Нэр томъёо

- ▲ Маркетинг
- ▲ Бүтээгдэхүүн
- ▲ Хугацаа
- ▲ Үйлдвэрлэлийн үе шат
- ▲ Бүтээгдэхүүний мөчлөг
- ▲ Идэвхжүүлэлт
- ▲ Хуваарилалт



Сэдвийн агуулга

- ▲ Сүлжээний бизнес ба маркетинг
- ▲ Маркетингийн тухай ойлголт
- ▲ Маркетингийн үүсэл, хөгжил, ерөнхий ойлголт
- ▲ Маркетингийн иж бүрдэл, тэдгээрийн уялдаа пүүст хэрхэн нөлөөлөх нь
- ▲ Маркетингийн удирдлагын гүйцэтгэх үүрэг

5. Хүчин зүйлсийн зах зээл: хөдөлмөр, капитал, газар

Хичээлийн хэлбэр: Лекц, семинар

Сэдвийн зорилго: Хүчин зүйлсийн зах зээл, тэдгээрийн үйл хөдлөл болон хүчин зүйлсийн зах зээлийн өрсөлдөөний хэлбэрүүд, тэдгээрийн онцлог, ялгааны талаар үндсэн мэдээгтэй болж, хүчин зүйлсийн зах зээлийн онцлог ялгаа, хүчин зүйлсийн эрэлт, нийлүүлэлт, үнэ тогтох үйл явцыг тайлбарлах чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Хүчин зүйлсийн зах зээл
- ▲ Уламжлагдсан эрэлт
- ▲ Хүчин зүйлсийн үнэ
- ▲ Цалин
- ▲ Үйлдвэрчний эвлэлийн нөлөө
- ▲ Рент буюу түрээс
- ▲ Хүү
- ▲ Хөдөлмөрийн зах зээл
- ▲ Хөрөнгийн зах зээл
- ▲ Газрын зах зээл
- ▲ Монополь ба Монопсони байдал



Сэдвийн агуулга

- ▲ Хүчин зүйлсийн зах зээл: Төгс өрсөлдөөнт хүчин зүйлсийн зах зээл
- ▲ Монопсони болон монополь байдал
- ▲ Хүчин зүйлсийн эрэлт ба нийлүүлэлт, уламжлагдсан эрэлт
- ▲ Бүтээгдэхүүн, нийт, дундаж ба ахиуц бүтээгдэхүүн
- ▲ Хүчин зүйлсийн үнэ тогтох нь
- ▲ Хөдөлмөрийн зах зээл, Үйлдвэрчний эвлэлийн үүрэг, оролцоо
- ▲ Капитал болон газрын зах зээл

IV бүлэг: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, АСУУДЛУУД

Бүлгийн зорилго: Улс орны хэмжээний эдийн засгийн байдал, өсөлт, хөгжил, эдийн засгийн бодлого, арга хэрэгслүүдийн талаар үндсэн мэдлэгтэй болж, ажилгүйдэл, инфляци, мөнгө зэрэг эдийн засгийн үзэгдлүүдийн мөн чанарыг ойлгон, тайлбарлах чадвар эзэмшин, улс орны хөгжлийн зөв хандлагыг тодорхойлох эрмэлзлэл, хандлагатай болоход оршино.

1. Үндэсний тооцооны систем

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Улс орны нийт эдийн засгийн байдлыг илтгэх үзүүлэлтүүдийн талаар мэдлэг эзэмшин, тэдгээрийг тооцох, үнэлэх чадвартай болж, эдийн засгийн бодит байдлыг зөв үнэлэх хандлага тогтоно.



Нэр томъёо

- ▲ Дотоодын нийт бүтээгдэхүүн
- ▲ Бодит өсөлт
- ▲ Нэрлэсэн өсөлт
- ▲ Инфляци
- ▲ Үндэсний нийт бүтээгдэхүүн
- ▲ Үнийн түвшин
- ▲ Хэрэглээний барааны үнийн индекс
- ▲ Дефлятор



Сэдвийн агуулга

- ▲ Үндэсний баялаг
- ▲ Нийт эдийн засгийг хэмжих нь: Дотоодын нийт бүтээгдэхүүн, бусад
- ▲ Эдийн засгийн өсөлт: нэрлэсэн ба бодит өсөлт
- ▲ Бодит өсөлтийг тодорхойлох
- ▲ Өсөлтийг дэмжих болон өсөлтийн эсрэг үзэл баримтлал
- ▲ Дотоодын нийт бүтээгдэхүүн ба инфляци
- ▲ Аж үйлдвэржилт

2. Монгол улсын эдийн засгийн өсөлт, түүтэй холбоотой асуудлууд

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Монгол улсын эдийн засгийн өсөлт, хөгжил, өнөөгийн байдлын талаар мэдлэгтэй болж, дэлхийн бусад орны эдийн засгаас ялгагдах ялгаа, эдийн засгийн бүтцийн онцлог зэргийг тодорхойлох чадвар эзэмшин, эх орныхоо хөгжилд санаа тавих эрмэлзлэлтэй болно.



Нэр томъёо

- ▲ Эдийн засгийн өсөлт
- ▲ Эдийн засгийн бүтэц
- ▲ Эдийн засгийн хараат байдал
- ▲ Амьжиргааны түвшин
- ▲ Аж үйлдвэржилт
- ▲ “Голланд өвчин”



Сэдвийн агуулга

- ▲ Монгол улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийн байдал
- ▲ Эдийн засгийн бүтэц, эдийн засгийн хараат байдал
- ▲ “Голланд өвчин”
- ▲ Хүн амын орлогын өөрчлөлт
- ▲ Хүн амын амьжиргааны түвшин, түүнтэй холбоотой асуудлууд

3. Эдийн засгийн хөгжлийн ялгаа, хэрэглээ ба хадгаламж, хөрөнгийн оруулалт

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Улс орнуудын эдийн засагт хэрэглээ, хадгаламж, хөрөнгө оруулалт, тэдгээрийн өөрчлөлт хэрхэн нөлөөлдөг талаар мэдлэгтэй болж, эдийн засгийн өсөлтийн ялгаа, онцлог, түүнтэй холбоотой үүсэх асуудлуудыг ойлгож, тайлбарлах чадвартай болоход чиглэнэ.



Нэр томъёо

- ▲ Хэрэглээ
- ▲ Дундаж ба ахиу хэрэглээ
- ▲ Хадгаламж
- ▲ Дундаж ба ахиу хадгаламж
- ▲ Нийт эрэлт
- ▲ Нийт нийлүүлэлт
- ▲ Хөрөнгө оруулалт
- ▲ Капиталын элэгдэл
- ▲ Зээлийн хүү
- ▲ Хөрөнгө оруулалтын ашгийн норм



Сэдвийн агуулга

- ▲ Хувийн орлого: Хэрэглээ, хадгаламж,
- ▲ Нийт эрэлт, нийт нийлүүлэлт
- ▲ Макро эдийн засаг дахь тэнцвэр
- ▲ Хөрөнгө оруулалт, капиталын элэгдэл
- ▲ Зээлийн хүү, хөрөнгө оруулалтын ашгийн норм
- ▲ Монгол улсын хэрэглээ, хадгаламжийн түвшин, түүний эдийн засаг дахь нөлөөлөл
- ▲ Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт
- ▲ Хөрөнгө оруулалтын бодлого

4. Ажилгүйдэл ба инфляци

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Эдийн засгийн тогтворгүй байдлын талаар онолын үндсэн мэдлэгтэй болох, энэхүү тогтворгүй байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг тодорхойлж, тайлбарлах чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Эдийн засгийн хэлбэлзэл
- ▲ Эдийн засгийн мөчлөг
- ▲ Мөчлөгийн үе шат
- ▲ Ажилгүйдлийн хэлбэрүүд
- ▲ Ажилгүйдлийн нийгмийн зардал
- ▲ Оукений хууль
- ▲ Инфляци
- ▲ Дефляци ба стагфляци
- ▲ Цэсний зардал
- ▲ гутлын улны зардал



Сэдвийн агуулга

- ▲ Эдийн засгийн хэлбэлзэл, эдийн засгийн мөчлөг
- ▲ Хэвийн өсөлтийн түвшин
- ▲ Дотоодын нийт бүтээгдэхүүний алдагдал
- ▲ Ажилгүйдэл, түүний хэлбэрүүд, шалтгаан, үр дагавар
- ▲ Инфляци, түүний шалтгаан үр дагаврууд
- ▲ Дефляци, стагфляци
- ▲ Ажилгүйдэл ба инфляцийн харилцан хамаарал

5. Монгол орны ажилгүйдэл ба инфляци, эдийн засгийн шилжилт

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Эдийн засгийн шилжилт, ажилгүйдэл, инфляцийн талаарх мэдлэгээ бататган, Монгол улсын хувьд ямар байдалтай байгаа, бусад улс орнуудынхаас ялгагдах ялгаа, онцлогийн талаар дүгнэх чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Шилжилтийн эдийн засаг
- ▲ Үнийн хөөрөгдөл
- ▲ Хэвийн ажилгүйдэл
- ▲ Сайн дурын ажилгүйдэл
- ▲ Эдийн засгийн шок
- ▲ Ажилгүйдлийн хэлбэрүүд
- ▲ Филлипсийн муруй
- ▲ Сайн дурын бус ажилгүйдэл
- ▲ Ядуурал
- ▲ Суурь үнэ



Сэдвийн агуулга

- ▲ Монголын эдийн засгийн тогтвортой байдал
- ▲ Шилжилтийн эдийн засаг, Монголын эдийн засгийн онцлог



- ▲ Хөдөлмөрийн зах зээлийн байдал, ажилгүйдлийн шалтгаан, үр дагаврууд
- ▲ Инфляци, манай орны инфляцийн онцлог, бодит байдал

6. Сангийн бодлого, татвар

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Эдийн засгийн тогтворжуулах бодлого, түүний нэг хэсэг болох сангийн бодлогын талаар мэдлэгтэй болж, улсын төсөв, татварын төрөл, хэлбэрүүд, татварын тогтолцоо, засгийн газрын худалдан авалт (засгийн газрын зардал) зэргийг тайлбарлах чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Хэрэглээ
- ▲ Нийт эрэлт
- ▲ Нийт нийлүүлэлт
- ▲ Лафферийн муруй
- ▲ Мөнгөний эмисс
- ▲ Татварын суурь
- ▲ Улсын төсөв
- ▲ Төсвийн алдагдал
- ▲ Шууд ба шууд бус татвар
- ▲ Прогрессив татвар
- ▲ Регрессив татвар
- ▲ Пропорциональ татвар



Сэдвийн агуулга

- ▲ Эдийн засгийн тогтворжуулах бодлого, сангийн бодлого
- ▲ Төсвийн орлого, татвар,
- ▲ Татварын систем, татварын бодлого, Лафферын муруй
- ▲ Төсвийн зардал,
- ▲ Төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлэх. Мөнгөний эмисс
- ▲ Төсвийн алдагдлыг багасгах

7. Татвар, түүний нийгэм эдийн засаг дахь нөлөөлөл

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Татварын ямар тогтолцоо нь хамгийн бага үр ашгийн алдагдалтайгаар дахин хуваарилалт хийдэг болон татвар ногдуулж байгаа хэлбэрийн талаар мэдлэг эзэмшин, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогоос хамаарч татварын ачаалал хэнд оногддог болох, хэрэглэгч эсвэл пүүсүүд ачааллыг илүү үүрснээр эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөөллийг тооцох чадвартай болно.



Нэр томъёо

- ▲ Татварын орлого
- ▲ Татварын ачаалал
- ▲ Хэрэглэгчийн хожоо
- ▲ Үйлдвэрлэгчийн хожоо
- ▲ Нийгмийн нийт алдагдал
- ▲ Засгийн газрын хожоо
- ▲ Засгийн газрын алдагдал
- ▲ Нийгмийн нийт хожоо



Сэдвийн агуулга

- ▲ Татварын тогтолцоонуудын үр ашигтай байдал,
- ▲ Татварын, эдийн засгийн болон нийгмийн үр дагаврууд
- ▲ Үйлдвэрлэгч, хэрэглэгч, нийгэмд үзүүлэх татварын нөлөөлөл
- ▲ Монгол улс дахь татварын шинэчлэл

8. Эдийн засаг дахь орлогын дахин хуваарилалт, ядуурал, ядуурлыг бууруулах аргууд

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Засгийн газрын гол үүрэг болох нийгмийн сайн сайхан байдлыг хангах, үүнтэй холбоотойгоор орлогын тэгш байдлыг бий болгохын тулд орлогын дахин хуваарилалтыг хэрхэн хийдэг талаар ерөнхий мэдлэгтэй болж, орлогын дахин хуваарилалтын эдийн засаг дахь ашиг, үр дагавар, ядуурал, түүнтэй холбоотойгоор үүсдэг асуудлуудын шалтгаан үр дагаваруудыг тодорхойлох чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Ядуурал
- ▲ Нийгмийн үр ашиг
- ▲ Жини коэффициент
- ▲ Тэтгэвэр
- ▲ Тэтгэмж
- ▲ Лоренцын муруй



Сэдвийн агуулга

- ▲ Нийгмийн сайн сайхан байдал
- ▲ Орлогыг дахин хуваарилалт
- ▲ Орлого хуваарилалтын тэгш байдал, Жини коэффициент, Лоренцын муруй
- ▲ Ядуурал, түүний хэлбэрүүд
- ▲ Орлогын ядуурал
- ▲ Чадавхийн ядуурал



- ▲ Ядуурлын түвшин
- ▲ Ядуурлын гүнзгийрэлт
- ▲ Ядуурах эмзэг байдал
- ▲ Ядууралтай тэмцэх аргууд

9. Мөнгө, Мөнгөний бодлого

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Мөнгө, мөнгөний бодлогын зорилго, мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар үндсэн мэдлэгтэй болж, мөнгөний бодлогын арга хэрэгслийг тодорхойлох чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Мөнгөний бодлого
- ▲ Мөнгөний агрегат
- ▲ Суурь мөнгө
- ▲ Бараг мөнгө
- ▲ Мөнгөний нийлүүлэлт,
- ▲ Мөнгөний эрэлт
- ▲ Нээлттэй захын үйл ажиллагаа
- ▲ Дискаунтын хүү
- ▲ Зайлшгүй байх нөөцийн норм
- ▲ Зөөлөн мөнгөний бодлого
- ▲ Хатуу мөнгөний бодлого



Сэдвийн агуулга

- ▲ Мөнгө, мөнгөний үүрэг,
- ▲ Мөнгөний эрэлт: арилжааны ба ашиг хонжооны
- ▲ Мөнгөний бодлого, мөнгөний бодлогын төрлүүд
- ▲ Мөнгөний агрегатууд, мөнгөний нийлүүлэлт
- ▲ Мөнгөний эрэлт ба нийлүүлэлтийн тэнцвэр
- ▲ Зээлийн хүү, тэнцвэрт зээлийн хүү
- ▲ Мөнгөний бодлогын арга хэрэгслүүд, шууд ба шууд бус арга хэрэгсэл

10. Мөнгө, санхүүгийн зах зээл

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Санхүүгийн тогтолцоо, санхүүгийн зах зээлийн талаар мэдлэгтэй болж, эдийн засаг дахь мөнгөний үүрэг, зохицуулалт, мөнгөний эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлж, тайлбарлах чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Мөнгө
- ▲ Арилжааны хэрэгсэл

- ▲ Өртгийн хэмжүүр
- ▲ Хадгаламжийн хэрэгсэл
- ▲ Банк
- ▲ Мөнгөний бодлого
- ▲ Үнэт цаас
- ▲ Зээлийн хүү



Сэдвийн агуулга

- ▲ Мөнгөний үүсэл, хөгжил
- ▲ Банк, банкны тогтолцоо
- ▲ Санхүүгийн хөрөнгүүд, үнэт цаас, түүний хэлбэрүүд
- ▲ Санхүүгийн хөрөнгийн зах зээл, түүний төрлүүд, тэдгээрийн ялгаа онцлог

V бүлэг: ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА

Бүлгийн зорилго: Улс орнуудын хооронд явагддаг гадаад худалдаа, эдийн засгийн бусад үйл ажиллагааны экономиксийн үндсэн мэдлэгийг эзэмшин, гадаад худалдаа, эдийн засгийн гадаад харилцааны ашиг, алдагдлыг тодорхойлох чадвар эзэмшин, улс орныхоо эдийн засгийн өсөлтөд үзүүлдэг нөлөө, үүнтэй холбоотой үүсэх асуудлуудыг ашигтайгаар хэрхэн, яаж шийдвэрлэх ёстой талаар сонирхох эрмэлзлэлтэй болоход чиглэнэ.

1. Гадаад худалдаа, гадаад худалдааны асуудлууд

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Гадаад худалдаа явагдах нөхцлийн талаар мэдлэгтэй болж, гадаад худалдааны ашиг, алдагдлыг тодорхойлох чадвартай болно. Гадаад худалдааны зөв бодлогыг ойлгох эрмэлзлэл төлөвшинө.



Нэр томъёо

- ▲ Гадаад худалдаа
- ▲ Туйлын давуу тал
- ▲ Харьцангуй давуу тал
- ▲ Валютын ханш
- ▲ Квот
- ▲ Дампинг
- ▲ Импорт
- ▲ Экспорт



Сэдвийн агуулга

- ▲ Гадаад худалдаа хийх шаардлага
- ▲ Гадаад худалдааны нөхцлүүд



- ▲ Гадаад худалдааны талаарх онолын үзэл баримтлалууд
- ▲ Гадаад худалдааны үр ашиг
- ▲ Гадаад худалдааны бодлогууд

2. Валютын ханш, валютын ханшны бодлого

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаанд хэрэглэгдэж буй мөнгөн тооцооны мөн чанар, валютын ханш, валютын ханшны системүүдийн тухай мэдлэгтэй болж, ханшны системүүдийн сул болон давуу талын тухай болон валютын ханшны бодлогуудын талаар өөрийн үнэлэлтийг өгөх чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Тогтмол ханшны тогтолцоо
- ▲ Бреттон Вуудсын систем
- ▲ Алтан Стандарт
- ▲ Хөвөгч ханшны тогтолцоо
- ▲ Валютын ханшны бодлого



Сэдвийн агуулга

- ▲ Валютын ханшны системүүд
- ▲ Валютын ханшны бодлого
- ▲ Валютын ханшны өөрчлөлт улс орны эдийн засагт нөлөөлөх нь

3. Монгол улсын гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого, стратеги

Хичээлийн хэлбэр: Семинар

Сэдвийн зорилго: Монгол улсын гадаад худалдаа, гадаад худалдааны бодлогын талаар зохих мэддэг эзэмшин, гадаад худалдааны байдлыг үнэлэх, гадаад худалдааг сайжруулах талаар өөрийн саналыг илэрхийлэх чадвартай болно.



Нэр томъёо

- ▲ Төлбөрийн тэнцэл
- ▲ Гадаад худалдааны баланс
- ▲ Төлбөрийн тэнцлийн алдагдал
- ▲ Чөлөөт худалдааны бүс
- ▲ Импортын татвар
- ▲ Онцгой албан татвар

- ▲ Монгол улсын гадаа худалдааны өнөөгийн байдал, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны баланс
- ▲ Монгол улсын гадаад худалдааны бодлого

VI бүлэг: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДЛУУД

Бүлгийн зорилго: Эдийн засгийн өсөлт, хөгжилтэй холбоотой орчин үеийн эдийн засгийн асуудлуудын талаар мэдлэгтэй болох, эдгээр үзүүлэлтүүд нь манай улсын хувьд ямар түвшинтэй байдгийг тодорхойлох чадвар эзэмшин, дэлхийн эдийн засагт гарч буй шинэчлэлт, өөрчлөлт, Монгол улсын байр суурийг тодорхойлох эрмэлзлэл төлөвшинө.

1. Глобалчлал, байгаль экологийн асуудлууд, тогтвортой хөгжлийн асуудлууд

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Хөгжлийн эдийн засгийн талаар үндсэн мэдлэгтэй болж, эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор байгаль экологид гарч буй өөрчлөлт, эдийн засаг, нийгэм, улс төрийн болон экологийн тэнцвэрт байдал зэргийн хоорондын хамаарлыг талаар үнэлэлт өгөх чадвар эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Глобалчлал буюу даяаршил
- ▲ Үндэстэн дамнасан корпораци
- ▲ Экологийн тэнцвэр
- ▲ Нөхөн сэргээгдэх нөөц
- ▲ Нөхөн сэргээгддэггүй нөөц
- ▲ Цөлжилт
- ▲ Агаарын бохирдол
- ▲ Тогтвортой хөгжил
- ▲ Эдийн засгийн тогтвортой өсөлт
- ▲ Улс төрийн тогтвортой байдал



Сэдвийн агуулга

- ▲ Глобалчлал, түүнтэй холбоотой асуудлууд
- ▲ Глобалчлалын талаарх эдийн засагчдийн үзэл баримтлал
- ▲ Үндэстэн дамнасан корпорацийн тухай ойлголт
- ▲ Экологийн тэнцвэрт байдал



2. Монгол улсын хүний хөгжил, түүнтэй холбоотой асуудлууд

Хичээлийн хэлбэр: Лекц

Сэдвийн зорилго: Монгол улсын хүний хөгжлийн үзүүлэлтүүд, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэг эзэмшин, дэлхийн бусад орнуудтай харьцуулахад ямар түвшинд байгааг тодорхойлох чадвартай болно.



Нэр томъёо

- ▲ Хөгжлийн эдийн засаг
- ▲ Орлого хуваарилалт
- ▲ Боловсрол
- ▲ Эрүүл мэнд
- ▲ Жендер (Хүйсийн ялгаварлал)
- ▲ Боловсролын түвшин
- ▲ Дундаж наслалт
- ▲ Нас баралт
- ▲ Албан бус боловсрол
- ▲ Академик сургалт
- ▲ Хүний хөгжлийн индекс
- ▲ Эрүүл мэндийн даатгал



Сэдвийн агуулга

- ▲ Монгол орны хүний хөгжлийн үзүүлэлтүүдийн түвшин, хүний хөгжлийн индекс
- ▲ Боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжил, эдийн засаг дахь үр өгөөж
- ▲ Манай орны хүн амын бичиг үсэгт тайлагдсан байдал, боловсролын түвшин, албан ба албан бус сургалтын хэлбэр, онцлогууд

3. “Эдийн засгийн онолын үндэс” хичээлийн заах арга зүй

Эдийн засгийн онолын үндэс хичээлийн заах арга зүйд тавигдах шаардлага

Эдийн засгийн онолын үндэс хичээлийн судлах зүйл, зорилго, зорилттой уялдан энэхүү хичээлийг заах арга зүйд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- ▲ Энэ хичээлийн ерөнхий зорилго, бүлэг, сэдэв тус бүрийн зорилгыг хангахуйц, тухайн сэдвийнхээ агуулгыг богино хугацаанд гаргаж ирэхээр сургалтын арга, хэлбэрийг сонгон хичээлээ явуулах,
- ▲ Оюутан бүр хичээлд жигд, идэвхитэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх,
- ▲ Хичээлийн агуулга нь онол, практикт нийцсэн байх
- ▲ Оюутны мэдлэг, чадварыг богино хугацаанд, бодитой үнэлэх шалгуурыг сэдэв болгонд тогтоох

Сургатын боломжит аргууд

Эдийн засгийн онолын үндэс хичээлийг төрөл бүрийн аргаар явуулж болно. Энд хэрэглэх боломжтой нилээд аргуудыг санал болгон тавьж байна. Мэдээж, тухайн сургуулийн нөхцөл байдал, хичээл зааж буй багшийн боломж, чадвараас хамаарч, тохиромжой аргаа сонгох нь зүйтэй юм.

1. Лекцийн хэлбэр нь мэдээлэл дамжуулах нэг суваг болон ашиглагддаг. Эдийн засгийн онолын үндэс хичээлийн ухагдахуунууд, тэдгээрийн харилцаа, холбоо, үндсэн ойлголтыг лекцийн хэлбэрээр өгч, ашиглах эх сурвалж, материалыг зааж өгөхөд лекцийн хэлбэр илүү үр дүнтэй байдаг. Мэдээллийн өөр сувгуудыг ашиглан, холбогдох материалыг олох боломжтой болсон орчин үед цээжээр бичүүлдэг аргаас бүрмөсөн татгалзаж, багш өөрийн цуглуулсан мэдээллээ хураангуй хэлбэрт оруулан, оюутнуудад тайлбарлан, нарийн төвөгтэй, гол асуудлууд дээр анхаарлыг хандуулах нь тэдний цагийг хэмнэх, мэдээлэл олж авах чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Лекцийн явцад тухайн сэдвийн талаарх зураг, бүдүүвч, бусад үзүүлэн таниулах материалыг өргөнөөр ашиглах, техник хэрэгслийг хэрэглэх нь богино хугацаанд их мэдээлэл дамжуулах, сэдвийн агуулгыг бүрэн гаргахад ач тустай. Лекцийн үед, зарим тохиолдолд тоглоомын хэлбэрээр явуулах боломжтой бөгөөд ихээхэн бэлтгэл, цаг хугацаа шаардана.
2. Семинарын хэлбэр нь оюутнуудад олсон мэдлэгээ бататгах, мэдлэгээ хэрэглэх чадвар эзэмшихэд илүү үр дүнтэй байдаг. Семинарын хэлбэрийг олон аргаар явуулах боломжтой. Тухайлбал, ярилцлагын арга, асуудал дэвшүүлж шийдвэрлэх, кейс ажиллах, тоглоомын арга, бодлого, дасгал ажиллах, эссэ, реферат бичих, загварчлал хийх г.м.

Тухайн сургууль, багш нь боломж нөхцөлдөө тулгуурлан хичээлийн аль хэсгийг, ямар аргаар явуулахаа шийдэх нь илүү үр нөлөөтэй.



4. Эдийн засгийн онолын үндэс хичээлийн үнэлгээ

1. Үнэлгээний зорилго

“Эдийн засгийн онолын үндэс” хичээлийн зорилгоо хэрхэн хангасан, оюутнууд энэ хичээлээр ямар мэдлэг авч, чадвар эзэмшсэнийг бодитойгоор тодорхойлоход үнэлгээний зорилго оршино.

Үнэлгээг дараах зүйлсэд ашиглана.

- ▲ Сургалтын үр дүнд хичээлийн зорилго хангагдсан эсэх, ямар түвшинд хангагдсан
- ▲ Багш хичээлийн агуулгыг бүрэн гаргаж, өгөх ёстой мэдлэгийг өгч чадсан эсэх
- ▲ Багшийн заах болон мэргэжлийн ур чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох
- ▲ Оюутан уг хичээлийг ямар түвшинд эзэмшсэн, давтан сурах шаардлагатай эсэх
- ▲ Оюутны сурч боловсрох эрмэлзлийг идэвхжүүлж чадаж буй эсэх

2. Үнэлгээний шалгуур

“Эдийн засгийн онолын үндэс” хичээлийн бүлэг бүрээр үнэлгээний хувийг тодорхойлж, бүлэг дотор үнэлгээний үлгэрчилсэн хувийг гаргах оролдлого хийлээ. Гэхдээ энэ хувь бол тухайн багшийн хувьд өөрчлөх боломжтой байх нь зохимжтой.

Үнэлгээний хувиуд (бүлгээр)

- ▲ I бүлэг -15%
- ▲ II бүлэг -20%
- ▲ III бүлэг - 20%
- ▲ IV бүлэг -25%
- ▲ V бүлэг -10%
- ▲ VI бүлэг -10%

I бүлгийг дүгнэх

Оюутны эзэмшвэл зохих мэдлэг чадварын түвшин:

1. Эдийн засгийн харилцаа, үүргийг тодорхойлж чаддаг,
2. Эдийн засгийн үндсэн асуудлууд нь эдийн засгийн тогтолцоо бүрт хэрхэн шийдвэрлэгддэгийг жишээгээр тайлбарладаг
3. Тогтолцоо бүрийн сул болон давуу талуудыг тодорхойлдог
4. Зах зээлийн өрсөлдөөний шинжээр нь салбаруудыг аль хэлбэрийн зах зээлд үйл ажиллагаагаа явуулж байгааг нь тодорхойлдог
5. Монополийн үед яагаад нийгмийн үр ашиг буурдагийг жишээгээр баяжуулж тайлбарладаг
 - 90%-ээс дээш хувийн үнэлгээ авахын тулд дээрх бүх асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 80-90 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3,4- дүгээр асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх

- 70-80 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3 эсвэл 1,3,4-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
- 60-70 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,3-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх

II бүлгийг дүгнэх

Оюутны эзэмшвэл зохих мэдлэг чадварын түвшин:

1. Эрэлт ба нийлүүлэлтэд нөлөөлдөг хүчин зүйлсийн нөлөөллийг жишээгээр болон графикаар тайлбарлаж чаддаг
2. Зах зээлийн тэнцвэр, тэнцвэр тогтох нөхцлийг тодорхойлдог
3. Тэнцвэрт нөлөөлдөг хүчин зүйлсийн нөлөөллийг тайлбарладаг
4. Эрэлтийн болон нийлүүлэлтийн мэдрэмжийг тооцоолж, эдийн засгийн утгыг нь тайлбарладаг
5. Орлого үнийн өөрчлөлтийн хамаарлыг харуулсан графикийг тайлбарлаж, дүгнэлтийг өгч чаддаг
 - 90%-ээс дээш хувийн үнэлгээ авахын тулд дээрх бүх асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 80-90 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3,4- дүгээр асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 70-80 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 60-70 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх

III бүлгийг дүгнэх

Оюутны эзэмшвэл зохих мэдлэг чадварын түвшин:

1. Эдийн засгийн агентуудын эрх үүргийг бүтээгдэхүүний болон хүчин зүйлсийн зах зээл бүр дээр тодорхойлдог,
2. Пүүсүүдийн шийдвэр гаргалтын үндэс, үйл ажиллагаа явуулах нөхцлийг графикаар дүрслэн харуулж, тайлбарлаж чаддаг байх
3. Засгийн газрын эдийн засаг дахь оролцоог онолын дагуу үнэлж дүгнэдэг байх
4. Үйлдвэрлэлийн хугацаанаас хамаарсан пүүсийн шийдвэр гаргалтын энгийн тооцооллыг жишээ бодёого дээр хийдэг, гарсан үр дүнг нь тайлбарладаг
 - 90%-ээс дээш хувийн үнэлгээ авахын тулд дээрх бүх асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 80-90 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,3,4- дүгээр асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 70-80 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,3-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 60-70 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх



IV бүлгийг дүгнэх

Оюутан эзэмшвэл зохих мэдлэг, чадварын түвшин:

1. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн тодорхойлолтыг гаргаж чаддаг, үзүүлэлтэд нөлөөлөх хүчин зүйлсийг тоочдог байх
2. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хоорондын харилцан хамаарлыг тодорхойлж, тэдгээрийг жишээгээр баяжуулан тайлбарладаг байх
3. Монголын эдийн засгийн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдлыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгдөг байх
4. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн тооцооллыг жишээ бодлого дээр хийдэг байх
5. Эдийн засгийн байдлыг харуулсан үзүүлэн, диаграмм, хүснэгтэн мэдээллийг ойлгож, эдийн засгийн нөхцөл байдлыг тайлбарладаг байх
6. Эдийн засаг дахь төрийн бодлогын үр дүнд өөрийн мэдлэгийн түвшинд тохируулан онолын үнэлгээ дүгнэлт хийдэг байх
 - 90%-ээс дээш хувийн үнэлгээ авахын тулд дээрх бүх асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 80-90 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3,4,5-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 70-80 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3,5-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 60-70 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх

V бүлгийг дүгнэх

Оюутан эзэмшвэл зохих мэдлэг, чадварын түвшин:

1. Туйлын болон харьцангуй давуу талын онолыг энгийн хийсвэр жишээгээр тайлбарлаж, худалдаа хийх нөхцөл болон худалдааны үр ашгийг нь тодорхойлж чаддаг байх
2. Улс орнуудын гадаад худалдаа хийх хэрэгцээ шаардлагыг мэддэг байх, гадаад худалдаанаас гарах үр дагаврыг тодорхойлж чаддаг байх
3. Монгол улсын гадаад худалдааны өнөөгийн байдлыг тоо баримтаар баяжуулан тайлбарлаж тодорхойлж чаддаг байх
4. Монгол улсын гадаад худалдааны бодлого, баримтлалыг онолын үүднээс тайлбарлаж чаддаг байх
5. Валютын ханшны талаарх ойлголт, валютын ханшны тогтолцоонууд, ханшинд нөлөөлдөг хүчин зүйлсийг мэддэг байх
6. Валютын ханшны бодлогын улс орны эдийн засаг дахь үр дагаврыг тайлбарладаг байх
 - 90%-ээс дээш хувийн үнэлгээ авахын тулд дээрх бүх асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 80-90 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 2,3,4,5,6-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 70-80 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 2,3,4,5-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 60-70 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 2,3,5-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх

VI бүлгийг дүгнэх

Оюутан эзэмшвэл зохих мэдлэг, чадварын түвшин:

1. Тогтвортой хөгжил гэж юуг хэлдэг, хүний хөгжил нь ямар үзүүлэлтүүдээр илэрхийлэгддэгийг мэддэг байх, манай улсын өнөөгийн түвшин ямар байгааг мэддэг байх
2. Яагаад тогтвортой хөгжлийн үзэл баримтлалуудыг авч үзэх шаардлагатай болсон, тогтвортой хөгжлийн үр дагаврыг хэрхэн тодорхойлох, тогтвортой хөгжүүлэхийн тулд төрийн зохицуулалт ямар байх ёстойг өөрийн үзэл бодлоороо тайлбарлах чадвартай байх
3. Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангахын тулд хууль эрх зүйн орчинг яаж өөрчлөх вэ гэдэгт үзсэн онолын мэдлэг болон өөрийн үзэл бодлоороо хариулах чадвартай байх
4. Хүний хөгжил нь эдийн засгийн хөгжилд ямар нөлөөлөл үзүүлдгийг бусад улс орнуудын болон өөрийн улс орны жишээн дээр харьцуулан тайлбарлаж чаддаг байх
 - 90%-ээс дээш хувийн үнэлгээ авахын тулд дээрх бүх асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 80-90 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2,3-дугаар эсвэл 1,2,4-дүгээр асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 70-80 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1,2-дугаар асуудлуудыг шийдвэрлэж чаддаг байх
 - 60-70 хувийн үнэлгээ авахын тулд дээрх 1-дүгээр асуудлыг шийдвэрлэж чаддаг байх



ЭКОНОМИКСИЙН ҮНДЭС ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

I бүлэг. ЭДИЙН ЗАСГИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ТОЙМ

Бүлгийн зорилго: Эдийн засгийн тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийн харилцан хамаарлын талаар мэдлэгтэй болж, эдийн засгийн суурь ойлголтыг тайлбарлах чадвар эзэмшин, улс орныхоо эдийн засгийн нөхцөл байдлыг ойлгох эрмэлзлэлтэй болгоход оршно.

1. Эдийн засаг гэж юу вэ?

- ▲ Эдийн засаг ба экономиксийн тухай
- ▲ Эдийн засгийн нөөц буюу үйлдвэрлэлийн хүчин зүйлс
- ▲ Эдийн засгийн үндсэн асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх
- ▲ Эдийн засагт үүсдэг төөрөгдлүүд, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт
- ▲ Үйлдвэрлэлийн боломж, үйлдвэрлэлийн боломжийн хязгаар

Эдийн засаг гэдэг нь эдийн засгийн харилцаанд оролцогч талуудын бүх үйл ажиллагааны нийлбэр цогц гэж үзэж болно. Үйлдвэрлэх, солилцох, хэрэглэх, хуваарилах зэрэгтэй холбогдсон харилцааны нийлбэр гэж тодорхойлдог.

Харин экономика бол эдийн засгийн харилцааг судалдаг, эдийн засгийн хомс нөөцөөр хязгааргүй хэрэгцээг хэрхэн хангах талаар гаргаж буй шийдвэрийн талаар судалгаа явуулдаг нийгмийн шинжлэх ухааны нэгэн салбар юм. Экономиксийг янз бүрээр тодорхойлж болдог. Энэ бол хүн төрөлхтний хязгаарлагдмал боломжуудаас сонголт хийх нөхцөл байдлыг судлах судалгааны арга, эдийн засаг дахь учир шалтгаан ба үр дүнгүүдийн харилцаа холбооны талаарх илэрхийллүүдийн олонлог, сонголтын тухай ухаан гэх мэтээр янз янзаар тодорхойлсон нь бий. Экономиксийг судалгааных нь хамрах хүрээгээр микроэкономика ба макроэкономика гэж ангилдаг бол явуулж буй арга байдлаар нь позитив ба норматив экономика гэж ангилан үздэг. Микроэкономика нь эдийн засгийн харилцаанд оролцогч агент (буюу тал) тус бүр шийдвэрээ хэрхэн, яаж гаргадаг, ямар үр дүнд хүрэхийг судалдаг. Харин макроэкономика нь улс орон, олон улсын хэмжээнд судалгаагаа явуулдаг. Позитив экономика гэдэг нь ямар нэгэн үзэгдлийн өөрчлөлт бусад үзэгдэлд яаж нөлөөлөхийг шинжилнэ. Жишээлбэл, мөнгөний нийлүүлэлт 1 хувь өсөхөд инфляцийн түвшин яаж өөрчлөгдөхийг судлана гэсэн үг. Норматив экономика бол "Ямар байх ёстой вэ?" гэсэн асуултанд хариулахад чиглэнэ. Жишээлбэл, манай орны ажилгүйдлийн түвшин хэд байх ёстой? Хүүхдийн мөнгө их байх ёстой юу? гэх мэт. Норматив экономика нь субъектив шинжтэй.

Экономиксийн судалгааны олон арга байдаг. Математик, статистик, эконометрикийн олон арга ашигладаг. Хийсвэрлэх, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, загварчлах, индукци ба дедукци зэрэг шинжлэх ухааны олон аргыг хэрэглэж судалгаагаа явуулдаг.

Хэн ч байсан, ямар нэгэн үйл ажиллагаа явуулахын тулд өөрийнхөө хүч, хөдөлмөрийг зарцуулдаг. Түүнчлэн тодорхой багаж хэрэгсэл, түүхий эд материалыг хэрэглэж байдаг. Ийнхүү явуулж буй үйл ажиллагаандаа хэрэглэж буй багаж хэрэгсэл, мөнгө, хөрөнгө зэргийг эдийн засгийн нөөц гэж нэрлэдэг. Маш олон төрлийн

нөөцийг нэрлэж болох бөгөөд экономикст ерөнхийд нь 4 төрөлд хуваан үздэг юм. Нэгд, хөдөлмөрийн нөөц: энд хүний ажиллах ур чадвар, мэдлэг боловсрол, дадлага туршлагыг багтаадаг. Хоёрт, капиталын нөөц: энд багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгө, түүхий эд материал гэх мэт урьд нь хүний хөдөлмөрөөр бий болсон нөөцүүдийг авч үздэг. Гуравт, газрын нөөц: энэ бол хүний хөдөлмөрөөр бий болоогүй, байгалийн зүйлс юм. Тухайлбал, газрын хөрс, агаар, гол мөрний ус, салхи, түүхий нефть, байгалийн хий гэх мэт зүйлсийг хэлж болно. Эцэст нь, удирдах ур чадварын нөөц: уг нь энэ бол хөдөлмөрийн нөөцийн нэг юм. Сүүлийн үед үйлдвэрлэлийн үр ашиг нь удирдаж буй хүмүүсийн ур чадвар, мэдлэг мэргэжлээс, олж авсан мэдээллээ боловсруулж, оновчтой шийдвэр гаргахаас ихээхэн хамаардаг болж ирсэн.

Эдгээр нөөцүүдийг заримдаа үйлдвэрлэлийн хүчин зүйлс ч гэж нэрлэдэг. Эдгээр нөөц буюу хүчин зүйлс маань ховор, хомс гэж тооцогддог. Хүмүүсийн хэрэгцээтэй харьцуулах замаар үүнийг хялбархан ойлгож болно. Иймд нөөцүүдийг аль болох хамгийн үр ашигтай ашиглах хэрэгтэй. Нийгмийн хэмжээгээр нөөцүүдийг үр ашигтай ашиглах шийдвэр нь эдийн засгийн үндсэн асуудлуудаар тодрон гардаг. Эдийн засгийн үндсэн 3 асуудал байдаг. Юу хийх вэ? Яаж хийх вэ? Хэнд зориулж хийх вэ? гэсэн 3 асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаагаар нь эдийн засгийн тогтолцоог ялган үздэг юм. Уламжлалт тогтолцоо, зах зээлийн тогтолцоо, төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоо гэсэн эдийн засгийн 3 янзын тогтолцоо байдаг.

Зах зээлийн эдийн засгийн үзэгдлүүд нь өөрийн мөн чанар, илэрч байгаа байдлаараа зөрүүтэй байх нь элбэг. Дан ганц зах зээлийг бүрэн шүтэх нь учир дутагдалтай бөгөөд зах зээл өөрөө тийм ч төгс байж чадахгүй гэж үздэг. Дараах 4 зүйлээс шалтгаалан зах зээл маань гажуудал буюу төөрөгдөл үүсгэдэг. Нийтийн бараа, гадаад нөлөө, зах зээлийн хүч, тэгш байдал гэсэн 4 шалтгаан бол дан зах зээлийн харьцаагаар зохицуулагдахгүй, алдагдах тохиолдол үүсдэг байна. Энэхүү төөрөгдөлийг засах, эдийн засгийн үзэгдлүүдийн мөн чанарыг гүйцэд илрүүлэхэд засгийн газрын оролцоо шаарддагатай болно. Засгийн газрын оролцоо нь шууд эдийн засгийн ажиллагаанд оролцохоос илүү орчинг бүрдүүлэхэд чиглэх нь чухал байдаг. Тодруулбал, хууль эрх зүйг боловсруулан гаргаж, эдийн засгийн агентуудын үйл ажиллагааг чөлөөтэй явуулах орчинг бүрдүүлэх учиртай. Ингэхээр эрх зүй бол эдийн засгийн үйл ажиллагааны хөгжлөөс урган гарсан зайлшгүй нэг нөхцөл мөн.

Нөөц хязгаартай учраас түүнийг ашиглан үйлдвэрлэн гаргах бүтээгдэхүүний хэмжээ мөн хязгаардагдмал. Нөөцүүдийг ашиглан хийж болох бүтээгдэхүүнүүдийн дээд хослолыг үйлдвэрлэлийн боломжийн хязгаар гэж нэрлэдэг. Үйлдвэрлэлийн боломжийн хязгаараас илүү гарч үйлдвэрлэл явуулах боломжгүй, харин түүнээс доогуур түвшинд үйлдвэрлэл явуулах боломжтой боловч эдийн засгийн хувьд үр ашиг багатай байдаг.



Хяналтын асуулт

- ▲ Эдийн засгийн судалгааны ямар аргуудыг мэдэх вэ? Жишээгээр тайлбарла.
- ▲ Экономикс гэж юу вэ?
- ▲ Та бүхний хувьд эдийн засгийн үндсэн асуудлууд ямар хэлбэртэйгээр тавигдаж болох вэ? Жишээгээр тайлбарла
- ▲ Мөнгө яагаад эдийн засгийн анхдагч нөөц биш вэ?
- ▲ Манай орны хувьд элбэг болон ховор нөөцүүд нь юу байж болох вэ?
- ▲ Эдийн засгийн төөрөгдлүүдийн ялгаа, онцлогууд нь юу вэ?
- ▲ Эдийн засгийн эрх чөлөө нь улс төрийн эрх чөлөөтэй хэрхэн холбогдож болох вэ?
- ▲ Эдийн засгийн харилцааг зохицуулж буй хуулиудыг нэрлэж, яаж зохицуулж байгааг тайлбарлана уу?
- ▲ Зах зээлийн болон төрийн зохицуулалтын гажуудлын ялгааг жишээгээр тайлбарла.



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 1-16 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 3-13 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 3-51 тал
4. А.Бакей, Р.Оросоо, “Эдийн засгийн ухаан”, 1998, УБ, 7-14 тал
5. Р.Амаржаргал, Ж.Батхуяг, Д.Батжаргал, “Эдийн засгийн ухаан”, 2000, УБ., 1-19 тал

2. Эдийн засгайн тогтолцоо

- ▲ Эдийн засгийн тогтолцоо
- ▲ Уламжлалт болон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны сул ба давуу талууд
- ▲ Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, холимог эдийн засаг, тэдгээрийн ялгаа, сул ба давуу талууд
- ▲ Эдийн засгийн үйл ажиллагаанд төр оролцох шаардлага, Засгийн газар, түүний үүрэг
- ▲ Эдийн засгийн эрх чөлөө, төрийн оролцооны гажуудал (government failure)
- ▲ Эдийн засгийн тогтвортой байдал
- ▲ Татвар болон татаас олгогдох нөхцөл
- ▲ Тэгш байдал, орлогын дахин хуваарилалт
- ▲ Монголын эдийн засгийн тогтолцоо, түүхэн хандлага, эдийн засгийн онцлог

Эдийн засгийн үндсэн асуудлуудыг шийдвэрлэх нь ямар ч нийгмийн гол зорилго болон тавигддаг. Эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаагаар нь уламжлалт, зах зээлийн, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо гэж ангилан үздэг юм.

Хүснэгт 1. Эдийн засгийн үндсэн асуудлыг шийдвэрлэх

Эдийн засгийн тогтолцоо	Юуг?	Яаж?	Хэнд?
Уламжлалт	Олон жилийн тогтсон уламжлалт аргаар шийдвэрлэдэг	Уламжлагдсан арга, технологиор үйлдвэрлэдэг	Нийтээрээ тэгш хуваарилдаг
Зах зээлийн	Зах зээл дээрх харилцааны явцад шийдвэр гаргадаг	Хамгийн хямд зардлаар үйлдвэрлэх	Өөрийн оруулсан хувь хэмжээгээр шударгаар хуваарилах
Төвлөрсөн төлөвлөгөөт	Ямар нэр төрлийн бүтээгдэхүүнийг, хэдий хэмжээгээр хийхийг төвлөрсөн байгууллагаас тогтоодог	Ямар техник, технологи ашиглах, хөдөлмөрийн бүтээмж ямар түвшинд байхыг ч төвлөрсөн журмаар шийднэ	Хэнд, хэдийн хэмжээний цалин хөлс олгохыг улсын төвлөрсөн байгууллага тогтооно

Ийнхүү шийдвэр гаргах явдал тогтолцоо бүрт харилцан адилгүй байх бөгөөд эдгээр хэлбэрийг хооронд нь харьцуулан үзэж давуу болон сул талуудыг мэдэх нь чухал юм. Ингэж мэдсэнээр аль болох давуу талуудыг бэхжүүлж, сул талыг арилгах замаар нийгмийн хөгжлийн дээд шатанд дэвших боломжтой болно.

Хүснэгт 2. Эдийн засгийн тогтолцооны сул ба давуу тал

Эдийн засгийн тогтолцоо	Давуу тал	Сул тал
Уламжлалт	Зардал багагай, хүнд суртал, шат дамжлага байхгүй	Техник, технологийн дэвшил маш удаан, эдийн засгийн хөгжил зогсонги
Зах зээлийн	Хүн бүр хуулийн хүрээнд хүссэн үйлдвэрлэлээ эрхлэх боломжтой Хувийн өмч дээрээ тулгуурладаг Хэрэглэгчдийн эрэлт, хүсэлтийг удирддага болгодог	Нийгмийн үйлдвэрлэлд оролцож чадахгүй байгаа хүн амын хэсэгт хатуу ханддаг. Өөрөөр хэлбэл, нийгмийн халамжийн үйлчилгээ сул байдаг.



Төвлөрсөн төлөвлөгөөт	хүн амын амьдралын нийгмийн баталгаа сайн, боловсрол, эрүүл мэндийн хөгжил харьцангуй амжилттай явагдсан	Үйлдвэр, аж ахуйн газрын бие даасан байдал туйлын хязгаарлагдмал, нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах санаачлага гаргахад түлхэц муутай
-----------------------	--	---

Эдгээр тогтолцоо нь орчин үед цэврээрээ оршин байхгүй болжээ. Аль нэгнийх нь давуу талыг шингээсэн холимог тогтолцоо бол орчин үеийн эдийн засгийн хэв шинж болсон. Эдийн засагт төрийн оролцоо бий болсноор эдийн засгийн хөгжилд нөлөөлөх болов. Төрийн оролцоо ихэдвэл тухайн эдийн засгийн өсөлт удааширч, харин багадвал байгаль, нийгмийн сөрөг үзэгдлүүд нэмэгдэх төлөв гардаг. Дараах хэдэн шаардлагаар төрийн оролцоо бий болдог байна. Үүнд:

- ▲ Хүн амын нийгмийн хамгааллыг бий болгох
- ▲ Байгалийн, хүрээлэн байгаа орчныг хамгаалах
- ▲ Шударга ёсыг сахиулах, хүн бүрт адил боломж, нөхцлийг бүрдүүлэх
- ▲ Гадаад харилцааг зохицуулах
- ▲ Нийгмийн бараа, үйлчилгээгээр хүн амыг хангах
- ▲ Хүн амын эрүүл амьдрах орчинг бүрдүүлэх, хортой нөлөөллөөс хамгаалах
- ▲ Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах

зэрэг шаардлагаар төрийн оролцоо зайлшгүй байдаг байна. Төрийн гол үүргийг эдийн засгийн тогтвортой байдал, тэгш байдал, орлогын дахин хуваарилалттай холбон үзэж болно. Энэ зорилгоор төрөөс татварын хувь хэмжээг тогтоож, зарим тохиолдолд татаас өгөх зэргээр эдийн засгийн бодлогуудыг боловсруулан хэрэгжүүлдэг байна. Энэ хичээл дээр төрийн эдийн засгийн үүргийг дэлгэрэнгүй ярилцаж, дор бүрнээ гаргасан дүгнэлтээ нэгтгэх болно.

Гэхдээ төрийн оролцоо хамгийн байх бага байх тусам эдийн засгийн үр өгөөж өндөр байдаг төдийгүй эдийн засгийн шударга байдал тогтдог. Харин төрийн оролцоо нэмэгдэх тусам элдэв гажуудал үүсэх нөхцөл бүрдэж, нөөцийн үр ашиггүй хуваарилалт нэмэгдэн, эдийн засгийн өсөлтийг сааруулдаг. Бүр тодруулбал, төрийн оролцоо нэмэгдсэнээр нийт эдийн засаг дахь гарц буурдаг. Яагаад гэдгийг жишээ гарган тайлбарлацгаая.

Монгол орон 1990 оноос эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж эхэлсэн. Дан ганц улсын өмч давамгайлсан тогтцоос өмчийн олон хэлбэрт тогтолцоонд шилжсэнээр эдийн засгийн нөөцийг үр ашигтай хуваарилах, хувь хүний санаачлагыг өрнүүлэх нөхцөл бүрдэж эхэлсэн. Жил бүрийн статистик мэдээллээс харвал манай орны шилжилтийн үйл явц нилээд хурдацтай явагдаж байна. 2005 оны байдлаар үйлдвэрлэлийн нийт хэмжээ 1990 оны өмнөх түвшинд хүрч, 1 хүнд ногдох Дотоодын Нийт Бүтээгдэхүүний хэмжээ 1000 орчим америк доллар болжээ.



Хяналтын асуулт

- ▲ Ямар шалгуур ашиглан эдийн засгийн тогтолцоог ангилдаг вэ?
- ▲ Эдийн засгийн тогтолцоо бүрийн давуу тал нь юу вэ?
- ▲ Эдийн засгийн тогтолцоо бүрийн сул тал нь юу вэ?
- ▲ Эдийн засгийн үйл ажиллагаанд төр ямар үүргүүдтэй оролцдог вэ?
- ▲ 1990 оноос өмнөх болон дараах үеийн Монголын эдийн засгийн тогтолцооны ялгааг тодорхойлно уу?
- ▲ Манай улс эдийн засгийн ямар тогтолцоотой вэ? Яагаад?
- ▲ Эдийн засгийн тогтвортой орчинг бүрдүүлэх гэдгийг хэрхэн ойлгох вэ?
- ▲ Эдийн засгийн тусгаар тогтнолыг хангахад төрийн үүрэг юунд орших вэ?
- ▲ Нийгмийн халамж, төрийн үйлчилгээний тухай юу ойлгож, мэддэг вэ?
- ▲ Та, хэрэглэгч болохын хувьд эдийн засгийн онолыг яаж ашиглах вэ?
- ▲ Хуульч хүний хувьд эдийн засгийн онол танд ямар ашиг тустай гэж ойлгож байна? Жишээгээр тайлбарла.
- ▲ Өнөөгийн манай улсын засгийн газрын эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцооны түвшинг та юу гэж үнэлж байна вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 16-23 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 15-24 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 53 - 73-р тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, “Эдийн засгийн ухаан”, 2000, 17-18 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006

3. Микроэкономиксийн үндэс, зах зээлийн эдийн засаг

- ▲ Зах зээл ба үнэ, төгс өрсөлдөөнт зах зээл
- ▲ Эдийн засгийн агентуудын зорилго, зорилгыг тодорхойлох хүчин зүйлс
- ▲ Хүчин зүйлсийн төрөлжилт
- ▲ Өмч, өмчийн хэлбэрүүд
- ▲ Өрсөлдөөн, өрсөлдөөний хэлбэрүүд,

Зах зээлийн эдийн засаг бол эдийн засгийн үйл ажиллагааны бүх шийдвэр зах зээл дээр гардаг тогтолцоог хэлдэг. Зах зээл бол худалдагч, худалдан авагчдын харилцаа явагддаг талбар гэж тодорхойлдог. Маш олон худалдан авагч, мөн маш олон худалдагчтай зах зээлийг чөлөөт буюу төгс өрсөлдөөнт зах зээл гэнэ. Төгс өрсөлдөөнтэй байх нь тодорхой бараа, үйлчилгээний хувьд үнийн ноёрхол тогтоохоос сэргийлэх нөхцөл болдог. Зах зээлийн үнээр баримжаалж, худалдагч болон худалдан авагчид шийдвэрээ гаргана.

Зах зээлд хэн оролодог вэ? Монголын зах зээлд 2,5 сая хэрэглэгч, 48 мянган аж ахуйн нэгж, хэдэн зуун төрийн байгууллага, мөн түүнчлэн олон арван мянган гадаадын байгууллага, хувь хүмүүс оролцож байна. Эдгээр оролцогч бүр өөрийн



зорилготой. Хэрэглэгчид өөрийн орлогонд тохируулж хэрэгцээгээ аль болох ихээр хангах, аж ахуйн нэгжүүд болохоор ашгаа хамгийн их байлгах, харин төрийн хувьд нийтийн хэрэгцээг аль болох дээд зэргээр хангахад зорилгоо чиглүүлдэг.

Зах зээлд оролцох хамгийн гол үндэс бол оролцогч бүр өөрийн гэсэн зүйлтэй, өөрөөр хэлбэл өмчтэй байх ёстой. Энд өмчийн эдийн засгийн агуулгыг тодотгоё. Хэрэглэгчийн хувьд янз бүрийн зүйлийг өмчилж болох боловч, экономикст хөдөлмөрийн хүчин зүйлийг илүү авч үздэг. Яагаад гэвэл, хэрэглэгч нарт байдаг хэзээ ч салдаггүй өмч бол хөдөлмөр нь юм. Хөдөлмөр гэдэгт хүний биеийн болон оюуны чадавхийг багтаана. Харин аж ахуйн нэгжийн хувьд эдийн засгийн нөөцүүд буюу үйлдвэрлэлийн хүчин зүйлүүдийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг өмчилж байдаг. Харин төрийн хувьд эдгээр харилцааг зохицуулахаар гаргаж буй хууль, эрх зүйн актууд нь өмч нь болдог. Үүний зэрэгцээ төр өөрөө хэрэглэгч, үйлдвэрлэгч байдаг шинжтэй.

Энд зах зээлийн энгийн загварыг тайлбарлая.

Зах зээлийн оролцогчдийг бид хэрэглэгч ба үйлдвэрлэгч байдаг гэж хялбарчлан үзье. Харин зах зээлийн хувьд бүтээгдэхүүний ба хүчин зүйлийн гэсэн 2 төрөлтэйгөөр төсөөлье. Ингэвэл хэрэглэгч маань хүчин зүйлийн зах зээл дээр өөрийн өмчлөлд байгаа хөдөлмөрөө зарж, борлуулах эрхтэй. Энэ хөдөлмөрийг аж ахуйн нэгж худалдан авч, бусад хүчин зүйлстэй хослуулан ашиглаж, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн гаргана. Бэлэн бүтээгдэхүүнээ бүтээгдэхүүний зах зээл дээр борлуулж, орлого олох болно.

Эндээс харвал хэрэглэгч нь хүчин зүйлийн зах зээлд худалдагч болж, бүтээгдэхүүний зах зээл дээр худалдан авагчийн байр сууринд байна. Харин аж ахуйн нэгжийн хувьд хүчин зүйлсийн зах зээл дээр худалдан авагч болж, бүтээгдэхүүний зах зээл дээр худалдагч болох нээ.

Энэ 2 талын харилцан үйлчлэлээр зах зээлийн үнэ тогтож, тэнцвэрт тоо хэмжээ тодорхойлогдоно.

Зах зээлийн хувьд худалдагч, худалдан авагчийн тооноос хамааран өрсөлдөөний хэлбэр нь тогтдог. Олон тооны худалдагч, худалдан авагчтай бол төгс өрсөлдөөний зах зээл гэж нэрлэнэ. Оролцогчдын тоо ийм их байх тул зах зээлийн үнэд оролцогчид нөлөөлөх боломжгүй байдаг. Харин оролцогчдын тоо цөөн байвал төгс бус өрсөлдөөнт зах зээл гэж нэрлэдэг. Цөөн тооны, заримдаа бүр ганцхан худалдагч, эсвэл худалдан авагчтай зах зээл нь зах зээлийн үнэд нөлөөлөх боломж, чадвартай байдаг. Дотор нь монополий, монопольт өрсөлдөөн, олигополь зах зээл гэж хуваан үздэг юм. Тэдгээрийн талаар дараагийн хичээлд илүү тодорхой авч үзнэ.



Хяналтын асуулт

- ▲ Өмч гэж юуг хэлдэг вэ? Өмчийн эдийн засгийн агуулга, эрх зүйн агуулга хоёр тохирдог уу? Тайлбарла.
- ▲ Үнэ зах зээлд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
- ▲ Зах зээлийн өрсөлдөөний ямар хэлбэрийг мэдэх вэ? Жишээгээр тайлбарла.
- ▲ Зах зээлийн эдийн засагт ямар, ямар сул тал үүсч болох вэ? Яагаад?
- ▲ Зах зээлийн өрсөлдөөнийг хэрхэн тодорхойлох вэ?
- ▲ Амьдрал дээр цэвэр зах зээл маш ховор байтал эдийн засагчид түүнийг судалгаанд яагаад их ашигладаг вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Балтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 24-33 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 24-52 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 73 - 103-р тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, “Эдийн засгийн ухаан”, 2000, 19-35 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2006
6. А. Бакей, Р. Оросоо, “Эдийн засгийн ухаан”, 1998, УБ, 17-29 тал

4. Бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөөний хэлбэрүүдийн ялгаа, онцлог

- ▲ Цэвэр монополь, аргагүй монополь
- ▲ Монопольт өрсөлдөөн ба зар сурталчилгаа
- ▲ Үнийн ялгаварлал
- ▲ Нийгмийн нийт үр ашиг
- ▲ Олигополь, түүнтэй холбоотой үүсэх асуудлууд

Энэ хичээлээр бид зах зээлийн хэлбэрүүдийн ялгаа, оршин байх нөхцөл, гарах үр дагавар, энэ талаарх төрийн бодлогын талаар ярилцъя.

Зах зээлийн бүтцийг тодорхойлохдоо дараах шинжүүдийг ашигладаг.

- Худалдагчийн буюу аж ахуйн нэгжийн тоо, хэмжээ
- Худалдан авагчийн тоо
- Үнэд нөлөөлөх чадвар
- Бүтээгдэхүүний шинж чанар
- Зах зээлд орох, зах зээлээс гарах боломж
- Мэдээллээр хангагдсан байдал
- Үнийн бус өрсөлдөөн



Шинж	Төгс өрсөлдөөнт	Төгс бус өрсөлдөөнт		
		монополь	Монопольт өрсөлдөөн	Олигополь
1	Маш олон	Нэг	Олон тооны	Цөөн тооны
2	Маш олон			
3	Нөлөөлөхгүй	Нөлөөлнө	Нөлөөлөх боломжтой	Нөлөөлөх боломжтой
4	Нэг ижил бүтээгдэхүүн	Орлуулах боломж багатай бүтээгдэхүүн	Ижил төрлийн	Ижил төрлийн боловч ялгаатай бүтээгдэхүүн
5	Ижил төрлийн боловч ялгаатай бүтээгдэхүүн	Нэвтрэх боломж маш бага	Харьцангуй хялбар	Нэвтрэхэд хэцүү
6	Мэдээлэл төгс	Төгс бус	Төгс бус	Төгс бус
7	Багатай	Хүчтэй	Хүчтэй	Машхүчтэй

Зах зээлийн шинжүүдийг дэлгэрүүлэн жишээ авч семинарын хичээлээр тайлбарлах болно.

Төгс өрсөлдөөний зах зээл нь “үл үзэгдэх гар”-ын зохицуулалтаар явагдах бөгөөд хамгийн үр ашигтай хуваарилалтыг бий болгодог гэж үздэг. Гэхдээ бодит амьдрал дээр цэвэр зах зээл гэж байдаггүй. Ихэнхидээ холимог шинжтэй зах зээл оршин байна. Монополийг бас ангилж үздэг: хаалттай, нээлттэй, аргагүй, үнийн ялгаварлал бүхий монополь.

Үнийн ялгаварлалыг төгс ба хэсэгчилсэн гэж хуваана. Төгс ялгаварлал гэдэг нь хэрэглэгч нэг бүрт ялгаатай үнээр үйлчлэхийг хэлэх ба харин хэрэглэгчдийг пшнж чанараар нь хэсэгчлэн хувааж, хэсэг бүрт ялгаварт үнээр худаалж буй бол сегментчилсэн үнийн ялгаварлал болно.

Монопольт өрсөлдөөний үед өөр хоорондоо үл ялиг ялгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг учир үнийн бус өрсөлдөөн маш хүчтэй байдаг. Зар сурталчилгааны хүчээр борлуулалтаа өсгөж, ашгаа нэмэгдүүлэх нь монопольт өрсөлдөөний үед ихээхэн гардаг.

Олигополь зах зээл нь бусад хэлбэртэй харьцуулахад өрсөлдөөнийг шударга бус болгох хандлага илэрдэг. Хуйвалдах, үнийн манлайлал тогтоох, зардал дээрээ нэмэх замаар үнэ тогтоох зэрэг үйлдлүүд ажиглагддаг байна.

Нэг улсын дотор үйл ажиллагаагаа явуулж буй, тухайн улсын иргэний өмчлөлийн аж ахуйн газрыг үндэстний компани гэдэг. Харин үндэстэн дамнасан корпораци гэдэг нь улс орны ялгаатай байдалд тохируулан олон улс орныг хамарсан бизнесийн үйл ажиллагаа явуулагч байгууллагыг хэлж болох юм. Нөгөө талаас хоёр буюу түүнээс дээш орнуудад аж үйлдвэр, газар тариалан, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад хяналтын хөрөнгийг эзэмшдэг аж ахуйн нэгжийг үндэстэн дамнасан корпораци гэнэ.



Хяналтын асуулт

- ▲ Үндэстний корпораци ба үндэстэн дамнасан корпораци гэж юуг хэлдэг вэ?
- ▲ Нийгмийн нийт үр ашиг эдийн засгийн ямар, ямар агентуудын үр ашгаар тодорхойлогддог вэ?
- ▲ Пүүсүүд ямар зорилгоор үнийн ялгаварлал тогтоодог вэ?
- ▲ Дэлхийн автомашины зах зээл нь ямар хэлбэрийн зах зээл вэ? Яагаад?
- ▲ Манай улсад тамхи үйлдвэрлэгч цор ганц компани байдаг. Энэ нь цэвэр монополийг төлөөлөх үү? Тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
- ▲ Монгол улсад, өрсөлдөөний ямар хэлбэр нь хамгийн элбэг вэ? Яагаад?
- ▲ Үнэлгээ-дүгнэлтийн
- ▲ Яагаад монополийн эсрэг хууль гаргах шаардлагатай байдаг вэ? Эдийн засгийн шалтгааныг тайлбарла.
- ▲ Нефть экспортлогч улсуудын холбоо нь дэлхийн нефтийн зах зээлийг зохицуулахад яаж оролцох вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 52-66 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 217-274 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 70-71 тал
4. Р. Амаржаргал, Ж Батхуяг, Д. Батжаргал, “Эдийн засгийн ухаан”, 2000, 61-65 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
6. А. Бакей, Р. Оросоо, “Эдийн засгийн ухаан”, 1998, УБ, 54-107 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005
8. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай Монгол улсын хууль. УБ. 2000




II бүлэг. ЭРЭЛТ БА НИЙЛҮҮЛЭЛТ

Бүлгийн зорилго: Зах зээлийн үйл явцийн гол механизм болох эрэлт, нийлүүлэлт, тэдгээрийн харилцан үйлчлэл, мөн зах зээлийн харилцаанд оролцогч талууд болох хэрэглэгч ба пүүсүүдийн үйл хөдлөл, тэдгээрт нөлөөлдөг бусад хүчин зүйлсийн талаар мэдлэгтэй болж, бараа бүтээгдэхүүний болон пүүс, салбарын эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох чадвар эзэмшин, зах зээлийн харилцааг зөвөөр ойлгох эрмэлзлэлтэй болно.

1. Хэрэглэгчийн сонголт ба эрэлт

- Хэрэглэгчийн таашаал, ханамж
- Хэрэглэгчийн ахиу ханамж буурах хууль
- Бараа ба бүтээгдэхүүний тухай, орлуулдаг, хослуулдаг бүтээгдэхүүн
- Бүтээгдэхүүний, үйлчилгээний тоо хэмжээ
- Хэрэглэгчийн орлого ба худалдан авалт
- Хэрэглэгчийн эрэлт

Эрэлт гэдэг нь худалдан авагчийн худалдан авахыг хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээг хэлнэ. Хүмүүсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтад зарцуулах орлого, бүтээгдэхүүнээс авах таашаал, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн талаарх таамаглал гэх мэт олон хүчин зүйлс хүмүүсийн худалдан авалтад нөлөөлдөг боловч зах зээлийн харилцаанд үнэ хамгийн чухал хүчин зүйл тул эрэлтийн функцийг үнээс хамаарсан хэлбэрээр тодорхойлно. Энэ тохиолдолд үнээс бусад хүчин зүйлс тогтмол гэсэн нөхцлийг тавина. Хулан чихрэнд дуртай. Түүний хамгийн дуртай чихэр нь үнэгүй бол өдөрт 14 ширхгийг авч иднэ. Тэгвэл энэ тоо хэмжээ нь үнэ тэгтэй тэнцэх үеийн эрэлт болно. Чихрийн үнэ 50 бол 7-г худалдан авна. Харин 70 болбол 5-ийг худалдан авна. Гэтэл энэ чихэр 140 болбол Хулан үүний оронд өөр чихэр худалдан авахыг хүсэх тул худалдан авахыг хүссэн хэмжээ нь 0 болно. Энэ хамаарлыг харуулсан муруй дараах хэлбэртэй байх ба үүнийг эрэлтийн муруй гэнэ.



Зураг 2.1. Эрэлтийн муруй

Эрэлтийн муруй нь шугаман хэлбэртэй үед налалт нь тогтмол ба эрэлтийн өөрчлөлтийг үнийн өөрчлөлтөд харьцуулсан харьцаа нь энэ хэмжээг илэрхийлнэ. $\Delta Q / \Delta P = -2/20 = -0.1$ байна.

Эндээс харахад үнэ болон эрэлтийн хэмжээ нь урвуу хамааралтай байгаа нь харагдаж байна. Бүтээгдэхүүний зах зээлийн эрэлтийн хувьд энэ чанар ямагт биелэгддэг бөгөөд үүнийг эрэлтийн хууль гэж нэрлэдэг. Харин үнээс бусад эрэлтэд нөлөөлдөг хүчин зүйлс нь эрэлтийн муруйг өөрчилдөг. Жишээ нь, Хуланд өвөө нь 150 төгрөг бэлэглэсэн гэвэл түүний орлого өсөх ба чихрийн үнэ 50 байхад 3 ширхгийг нэмж худалдан авах боломжтой болох буюу эрэлтийн хэмжээ нь 10 болно. Энэ тохиолдолд эрэлтийн муруй баруун гар тийш шилжинэ. Эрэлтийн муруйг шилжилт хийлгэдэг эдгээр хүчин зүйлсийг үнийн бус хүчин зүйлс гэх ба үүнд дараах хүчин зүйлс ордог.

Худалдан авагчийн орлого

Орлого нь эрэлтэд хоёр талт нөлөөлөлтэй. Дээрх жишээн дээр Хуланд өвөө нь мөнгө бэлэглэхэд эрэлт нь өсч байсан. Ийм барааг хэвийн бараа гэнэ. Гэтэл энэ чихэр Хулангийн хамгийн дуртай чихэр биш бол өвөө нь мөнгө өгснөөр Хулан өөр чихрэнд орлогоо зарцуулж болно. Энэ тохиолдолд бидний эрэлтийг нь тодорхойлж буй барааны эрэлт нь буурна. Ийм барааг чанар муутай буюу дорд бараа гэнэ.

Бусад барааны үнэ

Зарим нэг барааны үнэ нөгөөгийнхөө эрэлтэд нөлөөлдөг. Ихэвчлэн орлуулдаг, эсвэл, хосолдог шинж чанартай бүтээгдэхүүнүүдийн үнэ, эрэлт нь хамааралтай байдаг.

Үнийн таамаглал

Эдийн засгийн байдал, өөрчлөлтөөс хамаарч худалдан авагчид барааны үнэ хэрхэн өөрчлөгдөхийг урьдаас таамагладаг. Хэрвээ үнэ өснө гэж үзвэл эрэлт өснө, эсрэг тохиолдолд эрэлт буурна.

Хэрэглэгчийн таашаал, ханамж

Бүтээгдэхүүн худалдан авагчид хэр таалагдаж байгааг илэрхийлдэг үзүүлэлтийг хэрэглэгчийн таашаал гэнэ. Таашаалыг хэмжиж илэрхийлдэг үзүүлэлтийг ханамж гэж нэрлэдэг. Бүтээгдэхүүн хэрэглэгчид их таалагдах тусам эрэлт нь өсч, эсрэг тохиолдолд эрэлт нь буурна. Гэвч хэрэглэгч анхны хэрэглээг дараачийнхаас ямагт илүү үздэг. Өөрөөр хэлбэл дараа дараачийн бүтээгдэхүүнийг хэрэглэхэд нэмэгдэж буй ханамж буурдаг. Жишээ нь, би ханамжийг тоон утгаар хэмжигддэг гэж таамагл ая. Би огт мөнгөгүй байснаа 1000 болсон ба энэ үеийн ханамж 100 байсан. Дараа нь би нэмж 1000-тэй болоход миний нийт ханамж 180 болсон болсон гэвэл ханамж 80-аар өссөн ба анхны нэмэгдсэн ханамжаас бага байна. Хэрэглэгчийн бүтээгдэхүүний хэрэглээнээс нэмэгдэж байгаа ханамжийг ахиу ханамж гэх ба ихэнх бүтээгдэхүүний хувьд ахиу ханамж буурдаг. Үүнийг ахиу ханамж буурах хууль гэнэ.

Хэрэглэгчийн тоо

Бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн тоо өсвөл эрэлт нь өснө.



Хяналтын асуулт

- ▲ Ханамж ба таашаал гэж юуг хэлдэг вэ? Ямар, ямар шинж чанартай вэ?
- ▲ Эрэлтийн хууль гэж юу вэ? Эрэлтийн хууль нь ямар оролцогчийн үйл хөдлөлөөр тайлбарлагддаг вэ?
- ▲ Эрэлтэд нөлөөлдөг хүчин зүйлсийг нэрлэж нөлөөллийг нь тайлбарла.
- ▲ Агуулга үнэлгээний
- ▲ Яагаад хэрэглэгчийн ханамжийг тодорхойлох шаардаагатай болдог вэ?
- ▲ Хэрэглэгч аль бүтээгдэхүүнийг худалдан авахаа ямар хүчин зүйлд тулгуурлан шийддэг вэ? Хэрэглэгчийн сонголтод өөр ямар хүчин зүйлс нөлөөлж болох вэ?
- ▲ Ахиу ханамж буурахгүй байх тохиолдол байх уу?
- ▲ Эрэлтийн муруйн эдийн засгийн утгыг тайлбарла



Дасгал

Өгөгдөл

Зах зээлийн талаарх дараах мэдээлэл өгөгджээ.

- а. Уг бараа нь дорд бараа юу?, хэвийн бараа юу?
- б. Уг бараа нь Гиффен бараа юу?, энгийн бараа юу?

Үнийн түвшин	Эрэлтийн хэмжээ	Орлогын хэмжээ
100	1000	100000
110	1010	98000
120	1020	96000
130	1030	96000

Бодолт:

- а. Хэрэглэгчийн орлогоос хамааруулж хэвийн бараа юу?, эсвэл дорд бараа юу? гэдгийг тодорхойлдог тул бид уг хүснэгтийн 2 болон 3 дахь баганыг ашиглана. Эндээс харахад орлогын түвшин 100000 байхад эрэлтийн хэмжээ нь 1000 байсан ба орлого нь 98000 болж буурахад эрэлт нь 1010 болж өссөн байна. Энэ мэтчилэн орлогын бага түвшинд харгалзах эрэлтийн хэмжээ өндөр байгаа нь орлого болон эрэлт нь урвуу хамааралтай байгааг илэрхийлж байгаа ба уг бараа нь дорд бараа болж байна.
- б. Үнийн түвшний өөрчлөлтөөс эрэлт нь хэрхэн өөрчлөгдөж байгаагаар нь Гиффен болон энгийн барааны аль нь болохыг тодорхойлдог. Тэгвэл уг асуудалд хариулт өгөхийн тулд бид хүснэгтийн 1 ба 2-р баганы өгөгдлийг ашиглана. Эндээс харахад үнийн түвшин 100 үеийн эрэлт нь 1000 байгаа ба үнийн түвшин 110 болж нэмэгдэхэд эрэлт нь 1010 болж өөрчлөгдсөн байна. Үнэ болон эрэлт нь шууд хамааралтай байгаа тул уг бараа нь Гиффен бараа болно.

Бодлого

1. Талхны эрэлтийн функц нь $Q=100-10P+0.5Y+0.8P_B$ гэж өгөгджээ. Энд P нь талхны үнэ, Y нь хэрэглэгчийн орлого, P_B нь цөцгийн тосны үнэ бол
 - Талхны эрэлтийн муруйг байгуул.
 - Талх нь Гиффен бараа юу, энгийн бараа юу?
 - Талх нь хэвийн бараа юу, дорд бараа юу?
 - Талх болон цөцгийн тос нь орлуулдаг бараа юу, хосолдог бараа юу?
2. Нэгэн шинэ бүтээгдэхүүний эрэлтийн функц нь $Q=100-10P+1.8A$ гэж өгөгджээ. Энд P нь бүтээгдэхүүний үнэ, A нь зар сурталчилгааны зардал бол уг барааг сурталчлах нь ашигтай юу? Яагаад?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 24-33 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 27-34 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 72-78 тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000,
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006
6. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 20-24 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005

2. Хэрэглэгчийн ба зах зээлийн эрэлт болон пүүсийн эрэлт, эрэлтийн мэдрэмж, түүний хэрэглээ

- ▲ Зах зээлийн ба пүүсийн эрэлт
- ▲ Эрэлтийн мэдрэмж, тэдгээрийн хэлбэрүүд
- ▲ Үнийн мэдрэмж ба пүүсийн орлого
- ▲ Бараа бүтээгдэхүүнийг мэдрэмжээр нь ангилах

Бид өмнөх хэсэгт эрэлтийн талаарх ерөнхий ойлголтыг авсан билээ. Эрэлтийг хэсэгчилсэн болон нийлбэр хэлбэрээр тодорхойлж болдог. Тухайлбал, судлаач Монголын бензиний зах зээлийн үнээс хамаараад эрэлт нь яаж өөрчлөгдөж байна гэдгийг тодорхойлохыг хүсч байгаа бол Монголын зах зээл дээрээс бензин худалдан авагчдын эрэлтүүдийн нийлбэр буюу зах зээлийн эрэлтийг авч үзнэ. Харин зөвхөн манай өрхийн хувьд сүүний үнэ өөрчлөгдөхөд худалдан авах боломж яаж өөрчлөгдөхийг тодорхойлох бол энэ нь хэрэглэгчийн эрэлт болно. Үүний адил бизнес эрхлэгч зах зээлд гаргаж буй бүтээгдэхүүний эрэлтээ судалж болно. Энэ нь пүүсийн эрэлт болно. Зах зээлийн эрэлт нь хэрэглэгчид эсвэл пүүсүүдийн эрэлтүүдийн нийлбэр буюу хэсэгчилсэн эрэлтүүдийн нийлбэр байна.

Бид эрэлтийг яагаад авч үздэг вэ? Үүний нэг зорилго нь үнэ болон эрэлтэд нөлөөлдөг хүчин зүйлсийн хамаарлын хүчийг тодорхойлох юм. Өрсөлдөгч пүүсүүдийн нэг нь бүтээгдэхүүний үнээ буулгахад нөгөө нь үнээ буулгах уу? Хэрвээ тийм ч хүчтэй өрсөлдөгч биш бол магадгүй үнээ хэвээр байлгах нь үр ашигтай. Харин гол өрсөлдөгч нь мөн бол зах зээлээ алдахгүйн тулд, алдагдлаа багасгахын тулд үнээ өөрчлөхөөс



өөр аргагүй. Тэгвэл үнийн хувьд гол өрсөлдөгч үү гэдгийг мэдэхийн тулд нөгөө пүүсийн үнийн өөрчлөлтийг өөрийн бүтээгдэхүүний борлуулалт хэр мэдэрч байгааг тодорхойлох шаардлагатай болно. Энэхүү хүчин зүйлсийн хамаарлын хүчийг тодорхойлдог үзүүлэлтийг **эрэлтийн мэдрэмж** гэнэ.

$$E_D = \frac{\Delta Q\%}{\Delta P\%} \quad \begin{array}{l} E_D \text{ эрэлтийн мэдрэмж} \\ \Delta Q \text{ бүтээгдэхүүний тоо хэмжээний өөрчлөлт} \\ \Delta P \text{ бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт} \end{array}$$

Мэдрэмжийг дараах хоёр аргаар тооцдог.

$$E_D = \frac{\Delta Q\%}{\Delta P\%} \cdot \frac{P_1 + P_2}{Q_1 + Q_2} \quad (\text{интервалан буюу дунджийн})$$

$$E_D = \frac{\Delta Q}{\Delta P} \cdot \frac{P}{Q} \quad (\text{цэгэн})$$

$$\begin{array}{ll} Q_1 & \text{бүтээгдэхүүний эхний үеийн тоо хэмжээ} \\ Q_2 & \text{бүтээгдэхүүний сүүлийн үеийн тоо хэмжээ} \\ P_1 & \text{бүтээгдэхүүний эхний үеийн хэмжээ} \\ P_2 & \text{бүтээгдэхүүний сүүлийн үеийн хэмжээ} \end{array}$$

Ихэнх тохиолдолд дараах гурван мэдрэмжийг тооцдог.

- үнийн мэдрэмж: Үнэ нэг хувиар өөрчлөгдөхөд эрэлтийн хэмжээ нь хэдэн хувиар өөрчлөгдөхийг харуулдаг үзүүлэлт. Эрэлтийн өөрчлөлт нь үнийн өөрчлөлтөөс их бол уг барааны мэдрэмж сайн байна, бага бол мэдрэмж муу байна гэсэн үг.

$$E_D = \frac{\Delta Q\%}{\Delta P\%} = \frac{\Delta Q}{\Delta P} \cdot \frac{P}{Q}$$

Эрэлтийн муруй нь шугаман хэлбэртэй үед муруйн цэг бүр дэх мэдрэмжүүд ялгаатай байх ба үнийн түвшин буурах тусам мэдрэмж нь сайжирдаг. Энэ хамаарлын хүчээс шалтгаалж пүүсүүд үнээ өөрчлөх замаар орлогоо нэмэгдүүлэх боломжтой болдог.

- Үнээс хамаарсан эрэлтийн мэдрэмжийн утга нь нэгээс их байвал мэдрэмж сайтай гэх ба энэ тохиолдолд бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт нь эрэлтийн өөрчлөлтөөс бага байдаг. Пүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд үнээ бууруулах нь үр дүнтэй байдаг.
| $\Delta P\%$ | = 1% байхад | $\Delta Q\%$ | > 1 байна гэсэн үг.
- Үнээс хамаарсан эрэлтийн мэдрэмж нь нэгээс бага бол мэдрэмж муутай гэх ба энэ тохиолдолд бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт нь эрэлтийн өөрчлөлтөөс их байдаг. Пүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд үнээ өсгөх нь үр дүнтэй байдаг.
| $\Delta P\%$ | = 1% байхад | $\Delta Q\%$ | < 1 байна гэсэн үг.

- Үнээс хамаарсан эрэлтийн мэдрэмж нь нэгтэй тэнцүү бол нэгж мэдрэмжтэй гэх ба энэ тохиолдолд үнийн өөрчлөлт эрэлтийн өөрчлөлт хоёр нь тэнцүү байна. Пүүс үнээ яаж ч өөрчилсөн орлогын өөрчлөлт бий болохгүй.

$|\Delta P\%| = 1\%$ байхад $|\Delta Q\%| = 1$ байна гэсэн үг.

- **орлогын мэдрэмж:** Худалдан авагчийн орлого нэг хувиар өөрчлөгдөхөд эрэлт нь хэдэн хувиар өөрчлөгдөж байгааг харуулдаг үзүүлэлт. Мэдрэмжийн утга сөрөг бол уг бараа нь чанар муу, эерэг бол хэвийн бараа байна.

$$E_R = \frac{\Delta Q\%}{\Delta P\%} = \frac{\Delta Q}{\Delta R} \cdot \frac{R}{Q}$$

Q бүтээгдэхүүний тоо
 R хэрэглэгчийн тоо
 E_R орлогын мэдрэмж
 ΔQ бүтээгдэхүүний тооны өөрчлөлт
 ΔR орлогын өөрчлөлт

- **солбисон мэдрэмж:** Бусад барааны үнэ нэг хувиар өөрчлөгдөхөд эрэлтийн хэмжээ хэдэн хувиар өөрчлөгдөхийг харуулдаг үзүүлэлт. Жишээ нь, В барааны үнэ нэг хувиар өөрчлөгдөхөд А барааны эрэлтийн хэмжээ хэдэн хувиар өөрчлөгдөхийг дараах томъёогоор тооцно.

$$E_{AB} = \frac{\Delta Q_A\%}{\Delta P_B\%} = \frac{\Delta Q_A}{\Delta P_B} \cdot \frac{P_B}{Q_A}$$

E_{AB} солбисон мэдрэмж
 ΔQ_A А бүтээгдэхүүний тооны өөрчлөлт
 ΔP_B А бүтээгдэхүүний үнэ
 P_B В бүтээгдэхүүний үнэ

Мэдрэмжийн утга эерэг бол уг хоёр бараа орлуулдаг, сөрөг бол хосолдог бараа байна.



Хяналтын асуулт

- ▲ Зах зээлд олон тооны, ижил пүүсүүд үйл ажиллагаагаа явуулдаг бол зах зээлийн эрэлтийг хэрхэн тодорхойлох вэ?
- ▲ Пүүсийн болон хэрэглэгчийн эрэлтийн ялгаа нь юунд байдаг вэ?
- ▲ Агуулга үнэлгээний
- ▲ Хэрэглэгчийн хувьд дорд болон Гиффен бараа нь зах зээлийн хувьд энэ чанараа хадгалах уу? Тайлбарла
- ▲ Пүүсийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн нь мэдрэмж сайтай бол пүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд үнээ яаж өөрчлөх ёстой вэ? Тайлбарла.
- ▲ Үнэлгээ-дүгнэлтийн
- ▲ Пүүсийн эрэлтийн зар сурталчилгааны зардлаас хамаарах мэдрэмжийн утга юуг илэрхийлж болох вэ, жишээгээр тайлбарла.



Дасгал

Өгөгдөл

Зах зээлийн талаарх дараах мэдээлэл өгөгдөв. Хүснэгтийг нөх.

№	Үнэ	1 пүүс	2 пүүс	3 пүүс	4 пүүс	5 пүүс	Зах зээлийн эргэлт
1	10	2400	2500	2400	2300	2400	
2	9	2500	2600	2600	2500	2800	
3	8	2600	2700	2800	2700	3200	
4	7	2700	2800	3000	2900	3600	
5	6	2800	2900	3200	3100	4000	
6	5	2900	3000	3400	3300	4400	
7	4	3000	3100	3600	3500	4800	

1. Зах зээл дэх үнийн түвшин 10-9 болж буурах үеийн пүүс бүрийн дундаж мэдрэмж хэд вэ?
2. 5-р пүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд үнийн ямар түвшин хүртэл үнээ буулгах вэ?

Бодолт:

Зах зээлийн эрэлт гэдэг нь үнийн түвшин бүрт харгалзах пүүсүүдийн эрэлтийн нийлбэр. Жишээ нь, үнэ 10 байх үеийн зах зээлийн эрэлт $Q=2400+2500+2400+2300+2400=12000$ болно.

Тэгвэл дараах хэлбэртэй болно.

№	Үнэ	1 пүүс	2 пүүс	3 пүүс	4 пүүс	5 пүүс	Зах зээлийн эргэлт
1	10	2400	2500	2400	2300	2400	
2	9	2500	2600	2600	2500	2800	
3	8	2600	2700	2800	2700	3200	
4	7	2700	2800	3000	2900	3600	
5	6	2800	2900	3200	3100	4000	
6	5	2900	3000	3400	3300	4400	
7	4	3000	3100	3600	3500	4800	

1. Зах зээл дэх үнийн түвшин 10-9 болж буурах үеийн пүүс бүрийн дундаж мэдрэмж хэд вэ? Энд эрэлтийн утга нь дискрет хэлбэрээр өгөгдсөн тул интервалан мэдрэмжийн томъёогоор тооцоолно. Жишээ нь эхний пүүсийн мэдрэмжийг тооцъё.

$$E_D = \frac{\Delta Q}{\Delta P} \cdot \frac{P_1 + P_2}{Q_1 + Q_2} = \frac{2500 - 2400}{9 - 10} \cdot \frac{9 + 10}{2500 + 2400} = \frac{19}{49}$$

1 пүүс	2 пүүс	3 пүүс	4 пүүс	5 пүүс
2400	2500	2400	2300	2400
19/49	19/51	19/25	19/24	19/13

2. 5-р пүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд үнийн ямар түвшин хүртэл үнээ буулгах вэ? Пүүс орлогоо нэмэгдүүлэхийн тулд үнийн мэдрэмж сайтай хэсэгт үнээ буулгадаг. Үүнийг харахын тулд 1-р пүүсийн үнийн дундаж мэдрэмжүүдийг өмнөх аргаараа тооцъё.

Дээрх бодолтоос харахад зах зээлийн үнийн түвшин 7-8-ын хооронд нэгж мэдрэмжтэй байгаа ба үнийн түвшин үүнээс доош буурахад пүүсийн орлого өсөхгүй эсрэгээрээ буурах тул уг түвшин хүртэл үнийг буулгана.

№	Үнэ	5 пүүс	Мэдрэмж
1	10	2400	
2	9	2800	19/13
3	8	3200	17/15
4	7	3600	15/17
5	6	4000	13/19
6	5	4400	11/21
7	4	4800	9/23

Бодлогууд

- Зах зээлийн үнэ 1500 байхад пүүсийн эрэлт нь 10000 байдаг ба үнэ нь 500-аар буурахад эрэлт нь 15000 болсон бол дундаж мэдрэмжийг ол. Пүүсийн орлого яаж өөрчлөгдөх вэ?
- Хэрэглэгчийн орлого 40000-аас 50000 болж нэмэгдэхэд эрэлт нь 20000-аас 18000 болж өөрчлөгдсөн бол орлогоос хамаарах дундаж мэдрэмжийг ол. Мэдрэмжийн утгаас уг барааг ямар бараа болохыг тодорхойл.
- Зах зээл дэх пүүсүүд төгс өрсөлддөг ба уг зах зээлд 1000 пүүс үйл ажиллагаагаа явуулдаг. Зах зээлийн эрэлтийн функц нь $Q=500000-12P$ бол үнэ 1000 үеийн нэг пүүсийн эрэлтийн тоо хэмжээг ол.
- А барааны үнэ 1500-2000 болж өсөхөд Б барааны эрэлт 10000-7500 болж буурсан бол Б барааны солбисон мэдрэмжийг ол. Уг хоёр бараа нь орлуулдаг бараа юу эсвэл хосолдог бараа юу.
- Эрэлтийн функц $Q_d=8-P$ гэж өгөгджээ. Үнэ 6Т байх үеийн үнээс хамаарсан эрэлтийн мэдрэмжийг ол.




Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 34-41 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 115-136 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 95-105 тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 35-48 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
6. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 34-43 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005

3. Нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэр

- ▲ Нийлүүлэлт, нийлүүлэлтийн хууль
- ▲ Нийлүүлэлтэд нөлөөлдөг хүчин зүйлс
- ▲ Зах зээлийн тэнцвэр: тэнцвэрт үнэ, тэнцвэрт хэмжээ
- ▲ Тэнцвэрийн өөрчлөлт
- ▲ Засгийн газар тэнцвэрт нөлөөлөх нь
- ▲ Татвар, татаас
- ▲ Үнийн тааз, үнийн шал


Үйлдвэрлэгчийн зах зээлд худалдахад бэлэн байгаа бүтээгдэхүүний хэмжээг нийлүүлэлт гэнэ. Бүтээгдэхүүний үнэ өндөр бол пүүс зах зээлд их хэмжээний бүтээгдэхүүн нийлүүлэхийг хүсэх ба үнэ бага бол нийлүүлэлтийн хэмжээ багасна. Жишээ нь, алтны дэлхийн зах зээлийн үнэ өсвөл манай улсын алт олборлож нийлүүлэгч компаниудын олборлолт өссөнөөр экспортын хэмжээ өсч гадаад худалдааны баланс сайжирдаг. Мөн хүнсний ногоо тариалагчид аль болохоор ногоогоо зоорилж өвөл, хаварт хүнсний ногооны үнэ өсөхөд гаргаж худалдах сонирхолтой байдаг нь үүнтэй холбоотой. Энэ бүх жишээнээс харахад үнэ болон нийлүүлэлт нь шууд хамааралтай байна. Энэ хамаарлыг харуулсан функцыг **нийлүүлэлтийн функц** гэнэ.



Зураг 2.2. Нийлүүлэлтийн муруй
 Нийлүүлэлтийн муруй нь ятарч үед үнэтэйгээ шууд хамааралтай байдаг. Бид нийлүүлэлтийн муруйг шугаман хэлбэртэйгээр тодорхойлбол налалт нь $\Delta Q / \Delta P = d$ байна.

Зах зээлийн тэнцвэр гэдэг нь тодорхой нэг үнийн түвшинд эрэлт нь нийлүүлэлттэйгээ тэнцэх буюу үнийн нэгтүвшинд хүмүүсийн худалдан авахыг хүссэн бүтээгдэхүүний хэмжээ нь пүүсүүдийн үйлдвэрлэхэд бэлэн байгаа бүтээгдэхүүний хэмжээтэй тэнцэхийг хэлнэ. Энэ нь эрэлтийн муруй нийлүүлэлтийн муруйн огтолцдоор тодорхойлогддог. Энэ үеийн үнийг тэнцвэрт үнэ, үүнд харгалзах эрэлт нийлүүлэлтийн хэмжээг тэнцвэрийн хэмжээ гэж нэрлэдэг. Зах зээлийн тэнцвэр нь эрэлт болон нийлүүлэлтэд нөлөөлдөг хүчин зүйлс өөрчлөгдөхөд өөрчлөгддөг. Тухайлбал хүмүүсийн орлого нэмэгдэхэд эрэлт өсөх буюу эрэлтийн муруй баруун гар тийш шилжсэнээр зах зээл дэх тэнцвэрт үнэ, тэнцвэрийн хэмжээ 2-уулаа өснө. Засгийн газар зах зээлийн тэнцвэрт 2 янзаар нөлөөлдөг.

1. Үнийн доод болон дээд түвшнийг тогтоож өгөх замаар
2. Пүүсүүдэд татвар оногдуулах, татаас олгох замаар



Зураг 2.2. Зах зээлийн тэнцвэр

Зургаас харахад P_1 үнэ нь үнийн шал буюу доод түвшин болно. Учир нь Засгийн Газраас энэ үнээс доогуур худалдах эрхгүйгээр тогтоож өгдөг. Энэ үед эрэлт нь Q_1^D байхад нийлүүлэлт нь Q_1^S болж, пүүсүүд хүмүүсийн худалдан авалтаас $Q_1^S - Q_1^D$ хэмжээгээр илүү бүтээгдэхүүнийг пүүсүүд үйлдвэрлэсэн байна гэсэн үг. Илүү гарсан үйлдвэрлэлийг илүүдэл гэж нэрлэдэг.

Үнийн P_2 түвшнийг үнийн тааз буюу үнийн дээд хязгаар гэнэ. Энэ үнээс өндөр үнээр борлуулахыг хориглосон нөхцөлтэйгээр Засгийн Газраас тогтоож өгдөг. P_2 үнийн түвшинд зах зээлийн эрэлт нь нийлүүлэлтээсээ $Q_2^D - Q_2^S$ -оор давсан ба үүнийг хомсдол гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл дээрх хэмжээний хэрэгцээтэй бараа зах зээлд үйлдвэрлэгдээгүй, дутагдалтай байна гэсэн үг.

Засгийн Газраас татвар (татаас өгсөн) оноосон үед нийлүүлэлт буурснаар (өссөнөөр) зах зээлийн тэнцвэр өөрчлөгддөг. Тухайлбал, татвар оноосон үед нийлүүлэлт буурснаар зах зээлийн тэнцвэрт хэмжээ буурч тэнцвэрт үнэ өсдөг. Учир нь пүүсүүд бүтээгдэхүүнийг өмнөхөөс илүү зардлаар үйлдвэрлэх тул нийлүүлэлт багасдаг. Харин энэ тохиолдолд үнийн өсөлт нь пүүсүүдийн орлого биш Засгийн Газрын орлого болох тул пүүсүүд татварын ачаалал үүрдэг. Гэвч энэ хүү татварыг пүүс дангаараа төлдөггүй. Тодорхой хэсэг нь хэрэглэгчдийн татварын ачаалал болдог. Энэхүү ачааллыг хэн нь илүү үүрч байгаа нь эрэлт нийлүүлэлтийн муруйн налалтаас хамаарна. Хэрвээ эрэлтийн муруйн налалт нь нийлүүлэлтийн муруйн налалтаас их бол татварын ачааллыг үйлдвэрлэгч илүү үүрдэг. Харин нийлүүлэлтийн муруйн налалт нь эрэлтийн муруйн налалтаас их бол хэрэглэгч ачааллыг илүү үүрдэг.



Хяналтын асуулт

- ▲ Пүүсүүд үйлдвэрлэх бүтээгдэхүүнийхээ хэмжээг ямар хүчин зүйлээс хамааруулж тогтоодог вэ? Тайлбарла
- ▲ Татвар оноосноор тэнцвэрт үнэ, хэмжээ яаж өөрчлөгдөх вэ?
- ▲ Хэрвээ та үнэ өснө гэж бодож байгаа бол зах зээлийн тэнцвэр яаж өөрчлөгдөх вэ?
- ▲ Бүтээгдэхүүний хомсдол үүссэн үед үнийн түвшин, тэнцвэрт үнээс өндөр байдгийг хэрэглэгч болон пүүсийн үйл хөдлөлтэй холбон тайлбарла.



Дасгал

Өгөгдөл

Зах зээлийн талаарх дараах мэдээлэл өгөгджээ. Энэ зах зээлд 100 ижил пүүс үйл ажиллагаагаа явуулдаг.

№	Үнэ	Пүүсийн эрэлт	Зах зээлийн нийлүүлэлт
1	1000	550	30000
2	1200	500	32000
3	1400	450	35000
4	1600	400	36500
5	1800	380	38000
6	2000	350	40000
7	2200	330	41000
8	2400	320	41800
9	2600	310	50200
10	2800	300	55000

- a. Зах зээлийн тэнцвэрт үнийг ол!
- b. Үнийн ямар түвшинд зах зээлийн хомсдол 3500 байх вэ?
- c. Үнийн ямар түвшинд зах зээлийн илүүдэл 8000 байх вэ?
- d. Засгийн газраас үнийг 2000-аар тогтоож өгсөн бол илүүдэл хомсдолын аль нь хэдээр бий болох вэ?

Бодолт

- a. Зах зээлийн тэнцвэрийг тодорхойлохын тулд эхлээд зах зээлийн эрэлтийг тодорхойлох шаардлагатай. Зах зээлийн эрэлт нь пүүс тус бүрийн эрэлтүүдийн нийлбэр тул дараах хүснэгтийн сүүлчийн баганаар илэрхийлэгдэнэ. Эндээс харахад үнийн түвшин 1800 байхад эрэлт нийлүүлэлт нь тэнцүү байгаа тул энэ үнэ нь зах зээлийн тэнцвэрт үнэ болно.

№	Үнэ	Пүүсийн эрэлт	Зах зээлийн нийлүүлэлт	Зах зээлийн эрэлт
1	1000	550	30000	55000
2	1200	500	32000	50000
3	1400	450	35000	45000
4	1600	400	36500	40000
5	1800	380	38000	38000
6	2000	350	40000	35000
7	2200	330	41000	33000
8	2400	320	41800	32000
9	2600	310	50200	31000
10	2800	300	55000	30000

- Хомсдолын хэмжээ 3500 байна гэдэг нь зах зээлийн эрэлт нь нийлүүлэлтээсээ ийм хэмжээгээр их байна гэсэн үг. Тэгвэл хүснэгтээс харахад үнийн түвшин 1600 байхад эрэлт нь 40000, нийлүүлэлт нь 36500 байгаа буюу хомсдол 3500-аар үүссэн байна.
- Үнийн түвшин 2200 байхад нийлүүлэлт нь 41000, эрэлт нь 33000 буюу илүүдэл 8000-аар үүсч байна.
- Үнийн түвшин 2000 байх үеийн нийлүүлэлт нь 40000, эрэлт нь 35000 буюу нийлүүлэлт нь эрэлтээсээ 5000-аар давж байгаа тул ийм хэмжээний илүүдэл бий болж байна гэж үзэж болно.

Бодлогууд

- Зах зээлийн талаарх дараах мэдээлэл өгөгджээ. Тэнцвэрт үнэ болон хэмжээг ол. Үнийн түвшин 120 байхад эдийн засагт илүүдэл ба хомсдолыг аль нь хэдээр бий болох вэ?

Үнийн түвшин	Эрэлтийн хэмжээ	Нийлүүлэлтийн хэмжээ
100	5000	5000
110	4500	5100
120	4000	5200
130	3500	5300

- Барааны эрэлтийн функц нь $Q_D = 25 - 2P$, нийлүүлэлтийн функц нь $Q_S = -10 + P$ бол зах зээлийн тэнцвэрт үнэ болон хэмжээг ол.




Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 28-31 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 53-114 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 82-90 тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 19-28 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006
6. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 31-34 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005

4. Нийлүүлэлт, зах зээлийн тэнцвэрийн хэлбэрүүд

- ▲ Илүүдэл эрэлт, илүүдэл нийлүүлэлт, эрэлт ба нийлүүлэлтийн хомсдол
- ▲ Хэрэглэгчийн хожоо
- ▲ Үйлдвэрлэгчийн хожоо
- ▲ Орлогын нөлөө
- ▲ Тоо хэмжээний нөлөө
- ▲ Олон тэнцвэртэй зах зээл
- ▲ Зах зээлд тэнцвэр тогтохгүй байх нөхцөл
- ▲ Хөдөлмөрийн зах зээлийн жишээ
- ▲ Зах зээлийн гажуудал (market failure)



Зураг 2.4. Хэрэглэгч ба үйлдвэрлэгчийн хожоо

Зарим хэрэглэгчид бүтээгдэхүүнийг зах зээлд тогтсон үнээс өндөр үнээр худалдан авахад бэлэн байдаг. Энэ үед хэрэглэгч үнийн зөрүүнээс хожоо олдог. Үүнийг хэрэглэгчийн хожоо гэдэг.


$$S_{P_{EP^*}} = \frac{1}{2} = (P_1 - P^*)Q^*$$

Үүний адилаар нүүсүүд өөрсдийн худалдах үнээс дээгүүр үнээр бүтээгдэхүүнийг худалдсанаар бий болох хожоог үйлдвэрлэгчийн хожоо гэнэ.

$$S_{P_{EP^*}} = \frac{1}{2} = (P^* - P_2)Q^*$$



Бараа бүтээгдэхүүний зах зээлийн онцлогоос хамаараад зах зээлд тэнцвэр тогтох нь ялгаатай байж болно. Зарим бүтээгдэхүүний зах зээлд цор ганц тэнцвэр тогтдог бол зарим нь олон тэнцвэртэй, зарим нь огт тэнцвэргүй байж болно. Тэгвэл дараах зарим нэг онцгой тохиолдлуудыг авч үзье.

Хөдөлмөрийн зах зээл





Зураг 2.5. Тэнцвэр нэгээс илүү тэнцвэрт тохиолдол

Хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөрийн тоо хэмжээ нь ажлын цагаар хэмжигдэж байгаа тохиолдолд хөдөлмөрийн хөлснөөс хамаарч орлуулалтын болон орлогын нөлөөлөл үүсдэг ба үүнээс хамаарч хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр хоёр цэгээр тодорхойлогддог.



2.6. Тэнцвэр нь шулууны бүх цэгүүд

Дээрх хоёр тохиолдолд эрэлт болон нийлүүлэлтийн муруйнууд хугарснаас огтолцол нь нэг цэгээр бус цэгийн олонлог болох шулуунаар илэрхийлэгдэж байна. Энэ тохиолдолд зах зээлийн тэнцвэр нь шулууны бүх цэгүүд болно.



Зураг 2.7. Тэнцвэргүй байх тохиолдол

Хүмүүсийн худалдан авах боломжит доод үнэ пүүсийн үйлдвэрлэлийн боломжит доод зардлаас бага, хүмүүсийн худалдан авалтын хамгийн их хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний зах зээлд үйлдвэрлэгдэх хамгийн бага хэмжээнд хүрэхгүй байх тохиолдолд зах зээлд тэнцвэр тогтох боломжгүй болдог.



Хяналтын асуулт

- ▲ Хэрэглэгч болон үйлдвэрлэгчийн хожоо гэж юу вэ?
- ▲ Цалингийн өөрчлөлтөөс үүсэх орлогын болон тоо хэмжээний нөлөөллийн ялгааг тайлбарла.
- ▲ Зах зээлийн гажуудал юунаас үүсч болох вэ?
- ▲ Бүтээгдэхүүний үнэ өссөнөөр хэрэглэгч ба үйлдвэрлэгчийн хожоо яаж өөрчлөгдөх вэ? Графикаар харуулж тайлбарла.
- ▲ Бүтээгдэхүүний үнэ зах зээлийн тэнцвэрт үнээс өндөр тогтсон бол зах зээлд борлуулалтын хэмжээ яаж өөрчлөгдөх вэ?
- ▲ Хөдөлмөрийн зах зээлд, хөдөлмөрийн хэмжээг ажлын цагаар илэрхийлэх үед яагаад хоёр тэнцвэр тогтдог вэ?



Дасгал

Өгөгдөл:

А барааны зах зээлийн эрэлтийн функц, нийлүүлэлтийн функц нь ба зах зээлд тэнцвэрт үнэ тогтсон бол хэрэглэгчийн хожоог ол.

Бодолт:

Зах зээлийн тэнцвэрт үнэ нь эрэлт ба нийлүүлэлтийн харилцан тэнцвэрээр тогтдог. Тэгвэл дараах нөхцөл биелэгдэх ёстой.

$$Q_D = Q_S \Rightarrow 100 - 2p = -20 + p$$

$$p = 40, Q^* = 20$$

Хэрэглэгчдийн уг бүтээгдэхүүнийг худалдан авахад бэлэн байгаа хамгийн өндөр үнэ нь дараах нөхцлөөр тодорхойлогдоно.

$$Q_D = 0 \Rightarrow 100 - 2p = 0 \Rightarrow p_D = 50$$

Эндээс хэрэглэгчийн хожоог олбол

$$S_{P_D EP^*} = \frac{1}{2} (P_D - P^*) Q^* \Rightarrow \frac{1}{2} (50 - 40) 20 = 100$$

Бодлого

1. А барааны зах зээлийн эрэлтийн функц, нийлүүлэлтийн функц нь ба зах зээлд тэнцвэрт үнэ тогтсон бол үйлдвэрлэгчийн хожоог ол. Засгийн газраас үнийн таазыг гэж тогтоосон бол үйлдвэрлэгчийн хожоо яаж өөрчлөгдөх вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 29-30 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 53-114 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 82-90 тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 19-28 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
6. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 31-34 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005



III бүлэг: ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Бүлгийн зорилго: Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүрэг, оролцогчдын харилцан хамаарлын талаар суурь мэдлэгтэй болж, тэдгээрийн үйл хөдлөлтэй холбоотой асуудлуудыг эдийн засгийн үүднээс тайлбарлах чадвар эзэмшинэ. Эдийн засгийн харилцаанд оролцогчдын үйл хөдлөлийг зөв үнэлж, эрх зүйн зохицуулалтыг ойлгох эрмэлзлэл төрүүлэхэд чиглэнэ.

1. Бизнесийн нэгжүүд ба өрх гэрүүд

- ▲ Эдийн засгийн орчил ба хураангуй загвар
- ▲ Бизнесийн нэгжүүд, тэдгээрийн зорилго
- ▲ Пүүсийн орлого, түүний тооцооны хэлбэрүүд: нийт, дундаж, ахиу
- ▲ Өрх гэрүүд
- ▲ Бүтээмж, үр өгөөж буурах хууль, уг хууль пүүсийн зорилготой хэрхэн уялддаг болох
- ▲ Үйлдвэрлэлийн хугацаа

Өмнөх хичээлээр эдийн засгийн орчлын тухай цухас дурдсан. Эдийн засгийн харилцаанд оролцогч талуудаас хэрэглэгч буюу өрх гэр, худалдагч буюу пүүсийн тухай дэлгэрүүлэн танилцацгаая.

Аж ахуйн нэгжийн зохион байгуулалт нь тэдний үйл ажиллагаанд нөлөөлж байдаг тохиолдол олон гардаг. Үйлдвэрлэлийн явцад гарч болох янз бүрийн эрсдлийг хариуцах, санхүүгийн асуудал шийдвэрлэх зэрэг нь зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч харилцан адилгүй байна. Бизнесийн зохион байгуулалтын дараах хэлбэрүүд оршин байдаг.

- Нэг хүний аж ахуй
- Хоршоо буюу нөхөрлөл
- Компани
- Корпораци

Нэг хүний аж ахуй нь хамгийн энгийн хэлбэр юм. Давуу тал нь үүсгэн байгуулахад хялбар, эзэн нь бүх үйл ажиллагааг шууд удирдана, хүнд суртлаас ангид байдагт оршино. Харин дутагдалтай тал нь зах зээл дээрх хүч нь сул, яландахад амархан, үйлдвэрлэлээ үргэлжлүүлэх боломж таш хязгаарлагдмал.

Нөхөрлөл буюу хоршоо нь хэд хэдэн хүн харилцан тохиролцож, гэрээ байгуулсаны үндсэн дээр өөрсдийн өмчийг нэгтгэж, үйлдвэрлэл явуулж буй зохион байгуулалтын хэлбэр юм. Давуу тал нь үүсгэн, зохион байгуулахад хялбар, удирдлагын бүтцийг төрөлжүүлэн, дагнах боломжтой, санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтойд оршино. Сул тал нь хувь нийлүүлэгчдийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлалтай, санхүүгийн хувьд хязгаарлагдмал шинжтэй.

Компани нь өндөр түвшний зохион байгуулалттай хэлбэр юм.

Харин манай улсын хувьд нөхөрлөл, хоршоо, компани гэсэн хэлбэрүүдээр хуульчлан заасан бөгөөд дотроо хэд хэдэн хэлбэрээр зохион байгуулагдаж болдог.

Бизнесийн нэгжүүдийн эцсийн зорилго бол ашгаа хамгийн их байлгах явдал гэж тодорхойлдог. Ашгаа их байлгахын тулд борлуулалтаа өсгөж, орлогоо нэмэгдүүлэх хэрэгтэй. Орлогыг нь нийт, дундаж, ахиу гэсэн хэлбэрүүдээр тооцно. Нийт орлогыг нийт борлуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ тоог борлуулсан үнээр нь үржүүлж тодорхойлдог.

Харин дундаж орлого нь борлуулсан нэгж бүтээгдэхүүн үйлчилгээнээс хэдий хэрийн орлого олж байгааг харуулдаг бөгөөд нийт орлогоо бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ тоонд харьцуулж тооцно.

Ахиу орлого нь нэмж борлуулж буй бүтээгдэхүүний нэгжээс олж буй нэмэгдэл орлого юм. Нийт орлогынхоо өөрчлөлтийг бүтээгдэхүүнийхээ өөрчлөлтөд харьцуулж тодорхойлдог.



Хяналтын асуулт

- ▲ Нэг хүний эзэмшлийн үйлдвэр болон корпорацийн давуу, сул талууд нь юу вэ?
- ▲ Өрх гэрүүдийн гол зорилго юу вэ?
- ▲ Үйлдвэрлэлийн урт ба богино хугацааны ялгаа нь юунд орших вэ?
- ▲ Бизнесийн нэгжүүдийн ямар хэлбэр нь нийгэмд хамгийн өндөр үр ашгийг авчрах боломжтой вэ?
- ▲ Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үр өгөөж яагаад буурдаг вэ? Жишээгээр тайлбарла.
- ▲ Зах зээлийн үйл ажиллагаанд засгийн газар оролцдог үеийн эдийн засгийн орчлыг тайлбарла.
- ▲ Нийт бүтээгдэхүүн хамгийн их үед ахиу бүтээгдэхүүн тэгтэй тэнцэнэ гэдгийг батал.



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 42-46 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 191-193 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 119-131 тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 48-61 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006
6. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 54-63 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005
8. Нөхөрлөлийн тухай Монгол улсын хууль, 1995
9. Хоршооны тухай Монгол улсын хууль, 1998
10. Компанийн тухай Монгол улсын хууль, 1999



2. Пүүсийн зардал, ашиг

- ▲ Үйлдвэрлэлийн богино ба урт хугацаа
- ▲ Нийт зардал, хувьсах ба тогтмол зардал
- ▲ Пүүсийн богино ба урт хугацааны зардлууд: нийт зардал, дундаж ба ахиуц зардал
- ▲ Пүүсийн ашиг: хэвийн ашиг, эдийн засгийн ба тооцооны ашиг
- ▲ Ашгийн тооцооллын хэлбэрүүд: нийт, дундаж, ахиу
- ▲ Ашиг хамгийн их байх нөхцөл

Бизнесийн нэгжийн гол зорилго нь **ашиг** байдаг. Эдийн засагчид ба нягтлан бодогчид уг ойлголтыг өөрөөр тайлбарладаг. Эдийн засагчдын тодорхойлдог ашиг нь нийт орлогоос эдийн засгийн зардлыг хассан ялгавар ($\pi = TR - TC$) бол нягтлан бодогчдын хувьд ашиг гэсэн ойлголт нь нийт орлогоос зөвхөн гадаад зардлыг хассан ялгавар байдаг.

Эдийн засгийн зардал нь өөрт хэрэгтэй нөөцөө өөр боломжит үйлдвэрлэлийн ашиглалтаас татан өөрийн болгоход зориулан төлж байгаа **төлбөр** юм. Уг зардлыг **гадаад буюу дотоод** гэж ангилна. Тодруулбал пүүсийн гадаад зардал гэдэгт бусдын эзэмшиж байгаа нөөцийг хэрэглэсний төлөө төлөх хөдөлмөрийн үйлчилгээ, түүхий эд, түлш, тээвэрлэлтийн зардлууд багтах бол дотоод зардалд өөрийн эзэмшиж буй нөөцийн алдагдсан боломжийн зардал ордог. Түүнчлэн **хэвийн ашиг** гэсэн ойлголт байх бөгөөд энэ нь **зардлын хэсэг** болдог. Учир нь хэвийн ашиг гэдэг нь тухайн үйлдвэрлэл эрхлэгчийг бизнесийн тэр салбарт тогтоон барихад шаарддагатай мөнгөн хэмжээг хэлдэг бөгөөд төдий хэмжээний мөнгийг тухайн бизнесээс олж чадахгүй бол бизнес эрхлэгч тэр бизнесийг орхин өөр ашигтай байж болох үйл ажиллагаа эрхлэх болно. Тиймээс хэвийн ашгийг бизнес эрхлэлтийн зардал гэж үздэг.

Үйлдвэрлэлийн зардлыг авч үзэж байхад тайлбарлах ёстой өөр нэг ойлголт бол үйлдвэрлэлийн хугацаа байдаг. Учир нь үйлдвэрлэлийн хугацаанаас хамаарч үйлдвэрлэлийн зардал өөр өөр гардаг юм. **Богино хугацаанд** үйлдвэрийн газрын хүчин чадал буюу үйлдвэрийн барилгын хэмжээ, машин тоног төхөөрөмжийн хэмжээ болон бусад капитал тогтмол байдаг. Пүүс хөдөлмөр, түүхий эд болон үйлдвэрийн газрын бусад нөөцүүдээ өөрчлөх замаар үйлдвэрлэлийн хэмжээгээ өөрчилдөг. Иймд богино хугацааны зардлын нэг хэсэг нь тогтмол байдаг бол үлдсэн хэсэг нь хувьсах хэлбэрээр илэрхийлэгддэг.

$TC=FC+VC$, FC *тогтмол зардал*, VC - *хувьсах зардал*, TC -*нийт зардал*

Харин урт хугацаанд пүүс өөрийн бүх нөөцийн хэмжээгээ тэр дундаа үйлдвэрийн газрын хүчин чадлыг ч өөрчилдөг. Салбарын үүднээс авч үзвэл урт хугацаанд пүүсүүд салбарт шинээр орж ирэх болон орхин гарах боломжтой байдаг байна. Иймд нийт зардал нь зөвхөн хувьсах зардлаар л илэрхийлэгдэнэ.

Пүүсүүдийн хувьд нийт зардлыг тооцохоос гадна бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үр ашгийг тооцохын тулд нэгжид оногдох дараах хэлбэрийн зардлуудыг тооцдог.

$$ATC = \frac{TC}{Q} = AFC + AVC$$

ATC – *дундаж нийт зардал*

TC – *нийт зардал*

Q – *бүтээгдэхүүн тоо хэмжээ*

$$AVC = \frac{VC}{Q}$$

AVC – *дундаж хувьсах*

VC – *хувьсах зардал*

AFC – *дундаж тогтмол зардал*

$$AFC = \frac{FC}{Q}$$

FC - тогтмол зардал

$$MC = \frac{\Delta TC}{\Delta Q}$$

MC - ахиу зардал

ΔQ – бүтээгдэхүүний тооны өөрчлөлт

ΔTC – бүтээгдэхүүний тооны өөрчлөлт

Ахиу зардал гэдэг нь үйлдвэрлэлийн хэмжээг нэгжээр нэмэгдүүлэхэд гарч буй нэмэгдэл нийт зардлыг хэлдэг.

Нийт орлого гэдэг нь бүтээгдэхүүний хэмжээг нэгж бүтээгдэхүүн борлуулсан үнээр үржүүлсэн үржвэр байдаг ба пүүсийн хувьд нэгж бүтээгдэхүүн нэмж борлуулснаар нэмэгдэх орлогыг тооцох нь чухал ба энэ үзүүлэлтийг ахиу орлого гэж нэрлэдэг.

$$MR = \frac{\Delta TR}{\Delta Q}$$

MR - ахиу орлого

ΔQ – бүтээгдэхүүний тооны өөрчлөлт

ΔTR - нийт орлогын өөрчлөлт

Пүүс ашгаа хамгийн их байлгах бүтээгдэхүүний хэмжээгээ бүтээгдэхүүн нэмж борлуулснаар бий болох нэмэгдэл орлого нь нэгж бүтээгдэхүүн нэмж үйлдвэрлэснээр бий болох ахиу зардалтай тэнцүү байх нөхцлөөр сонгодог.

$$MR = MC$$



Хяналтын асуулт

- ▲ Хэвийн ашгийг яаж тодорхойлох вэ?
- ▲ Тооцооны болон эдийн засгийн ашгийн ялгаа нь юу вэ?
- ▲ Урт ба богино хугацааны нийт зардлын ялгаа нь юу вэ?
- ▲ Яагаад ахиу орлого, ахиу зардалтай тэнцүү ($MR=MC$) үед пүүсийн ашиг хамгийн их, эсвэл пүүсийн алдагдал хамгийн бага байдаг вэ?
- ▲ Ахиу орлого нь ахиу зардлаас бага бол пүүсийн үйл хөдлөл яаж хийгдэх вэ?
- ▲ Өрсөлдөөний хэлбэрээс пүүсийн ашиг хэрхэн хамаардаг вэ?
- ▲ Пүүсийн урт ба богино хугацааны дундаж зардлуудын хамаарлыг тодорхойл.
- ▲ Пүүсийн зардлуудын графикаас пүүсийн ашигт үйл ажиллагаа болон үр өгөөжийн байдлыг тодорхойлж болох уу? тайлбарла.



Дасгал

Өгөгдөл:

Пүүсийн зардлын функц $TC=100+10Q-2.5Q^2+0.5Q^3$ гэж өгөгдсөн бол 10 бүтээгдэхүүн үйлдвэрлэх үеийн дундаж, ахиу зардлыг ол!

Бодолт:

Дундаж зардал гэдэг нь нийт зардлыг бүтээгдэхүүний тоонд харьцуулсан харьцаа буюу нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлд оногдох нийт зардлын дундаж хэмжээ тул дараах томъёогоор тооцно.

$$AC = TC/Q = (100+10Q-2.5Q^2+0.5Q^3)/Q$$

$$AC-100/Q+10-2.5Q+0.5Q^2 \Rightarrow AC(10)=10+10-25+50=45$$

Ахиу зардал гэдэг нь нэгж бүтээгдэхүүн нэмж үйлдвэрлэхэд гарах нэмэгдэл зардал ба зардлын функц нь тасралтгүй хэлбэрээр өгөгдсөн үед зардлын функцээс бүтээгдэхүүний хэмжээгээр авсан уламжлал байна.

$$MC=\Delta TC/\Delta Q = \Delta(100+10Q-2.5Q^2+0.5Q^3)/\Delta Q$$

$$MC=10-5Q+1.5Q^2 \Rightarrow MC(10)=10-50 + 150 = 110$$

Бодлого

1. Баяраа жижиг шавар эдлэлийн пүүс ажиллуулдаг. Тэрээр сардаа 12000 төгрөгөөр нэг туслах хөлсөлж ажиллуулдаг ба дэлгүүрийнхээ түрээсний хөлсөнд сард 5000 төгрөг төлнө. Мөн эд хэрэглэлдээ сард 20000 төгрөг зарцуулдаг байна. Тэрээр өөрийн бизнестээ 40000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд хэрвээ өөрөөр ашигласан бол энэ нь сар бүр түүнд 4000 төгрөг авчрах байсан. Түүний өрсөлдөгч нь сард 15000 төгрөгөөр өөрийнх нь төлөө ажиллахыг санал болгосон байжээ. Баяраа өөрийн үйлдвэрлэл эрхлэх ур чадвараа сарын 3000 төгрөг хэмээн үнэлдэг. Түүний пүүсийн сарын сарын нийт орлого 72000 төгрөг бол Баяраагийн пүүсийн нягтлан бодох бүртгэлийн болон эдийн засгийн ашгийг тооц.
2. Дараах өөрчлөлтүүдийн аль нь урт ба богино хугацаанд хамаарах вэ?
 - Шинэ зоогийн газар барих
 - Мобиком корпораци 200 шинэ ажилчин хөлслөн ажилуулах
 - Фермер тариаландаа хэрэглэх бордооныхоо хэмжээг ихэсгэх
 - Говь үйлдвэр гурван ээлжээр ажиллах
3. Пүүс 60\$-ын тогтмол зардалтай. Хувьсах зардал нь дараах хүснэгтээр өгөгдсөн бол хүснэгтийг гүйцээгээд муруйнуудыг зурж харилцан хамаарлыг нь тайлбарлана уу.

Q	TFC	TVC	TC	AFC	AVC	ATC	MC
0	\$	\$0	\$	\$	\$	\$	\$
1		45					
2		85					
3		120					
4		150					
5		175					
6		225					
7		270					
8		325					
9		390					
10		465					



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 46-50 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 195-216 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 261-285 тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 48-61 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006
6. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 63-78 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005

3. Менежментийн тухай ойлголт

- ▲ Хувь хүмүүсийн төлөвлөлтийн тухай
- ▲ Амжилтанд хүрсэн зарим нэг пүүс компаний түүхээс
- ▲ Менежментийн тухай ойлголт
- ▲ Менежмент гэж юу вэ?
- ▲ Менежментийн функц, тэдгээрийн уялдаа холбоо
- ▲ Менежер, түүний пүүст үзүүлэх нөлөө

Аливаа шинжлэх ухаан бүр өөрийн судлах зүйл, судалгааны арга, үндсэн зарчмуудтай байдгийн нэгэн адилаар менежментийн ухаан нь байгууллага, түүнийг үр ашигтай байлгахын тулд менежер юу хийх ёстой вэ? гэсэн үндсэн асуудлыг судалдаг.

Байгууллага гэдэг нь өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд үйл ажиллагаагаа ухамсартайгаар зохицуулж байгаа бүлэг хүмүүс юм. /Ч. Бернард/ Байгууллагыг амжилттай удирдахын тулд эн тэргүүнд түүний үйл ажиллагааг тодорхойлогч хүчин зүйлсийг тооцож, анхааралдаа авч ажиллах хэрэгтэй.



Эдгээр нь:

- a. байгууллагын нөөц: материал түүхий эд, тоног төхөөрөмж, барилга байшин зэрэг биет нөөц, мөнгө үнэт цаас, хувьцаа зэрэг санхүүгийн нөөц, байгууллагад ашиглагдах гадаад ба дотоод мэдээллийн нөөц, менежер ажилчид зэрэг *хүний нөөц*
- b. гадаад орчин: хэрэглэгч, нийлүүлэгч, өрсөлдөгч, үйлдвэрчний эвлэл, засгийн газрын бодлого, эдийн засаг, улс төр, нийгэм соёл, технологи, олон улсын гэх мэт
- c. хөдөлмөр хуваарилалт: ажилчин бүр ямар эрх мэдэл, үүрэг хариуцлагатайгаар байгууллагын ямар үйл ажиллагаанд оролцох вэ? гэдгийг нарийн тогтоох

Байгууллага амжилттай ажиллаж байгаа эсэхийг тодорхойлогч үзүүлэлтүүд нь

- удаан оршин тогтнох чадвар
- үр ашиг
- бүтээмж

Менежмент нь үгийн үндсийн хувьд “to manage”-захирах, удирдах, жолоодох гэсэн утгатай англи үгнээс гаралтай бөгөөд хүмүүс ганц нэгээрээ хэрэгжүүлэх боломжгүй зорилгод хүрэхийн тулд хамтран ажиллаж эхэлсэн үеэс менежмент үүссэн гэж үздэг. Менежмент нь үйл ажиллагаа болохын хувьд хүмүүсээр үр ашигтай үйл бүтээлгэх, ажил хэрэг өрнүүлэх урлаг юм. Илүү иж бүрэн шинжтэй тодорхойлолт гэвэл менежмент гэдэг нь байгууллагын зорилгыг тодорхойлж түүнд хүрэх арга замыг **төлөвлөн** ажиллах хүч, санхүү, материалын бүх нөөцийн ашиглалтыг оновчтой **зохион байгуулж**, хүмүүсээ шилж сонгон, тэдгээрийг идэвхижүүлэн манлайлан ажиллах, үйл ажиллагааныхаа явц, үр дүнг үнэлэн **хяналт тавих** нэгдмэл үйл ажиллагаа юм гэжээ.

Бусад хүмүүсийг зохион байгуулах замаар өөрийн хэрээс давсан их ажлыг хийх чадвартай хүнийг менежер гэдэг. Менежер хүний мэдлэг боловсрол, ур чадвар, туршлага, зөн совингоос байгууллагын амжилт, үр дүн шууд шалтгаална. Удирдах үйл ажиллагаа бусад үйл ажиллагаанаас ихээхэн ялгаатай бөгөөд удирдах ажилтан олон төрлийн чиг үүрэгтэй байдгаас хамгийн нийтлэг буюу менежментийн функц, чиг үүрэгт:

Төлөвлөлт: төлөвлөлтийн үндсэн дээр байгууллага ирээдүйн зорилго, зорилт, түүнд хүрэх арга замуудаа тодорхойлдог. Төлөвлөлт гэдэг бол зорилгод хамгийн хэмнэлттэй ямар арга замаар хүрэх вэ? гэдгийг шийдвэрлэх үйл явц юм.

Зохион байгуулалт: энэ нь байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хүн хүч, материал, түүхий эд, мэдээлэл, санхүүгийн зэрэг бүх төрлийн нөөцийг оновчтойгоор нэгтгэн зангидах үйл явц.

Сэдэлжүүлэлт /мотиваци/: байгууллага тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хүмүүсийг тодорхой үйл ажиллагаанд өдөөн түлхэх, нөлөөлөх үйл явц юм.

Хяналт: байгууллагын үйл ажиллагаа зохих дүрэм, журам, стандарт төлөвлөгөөний дагуу явагдаж буй эсэхийг тодорхойлох, буруу алдаатай зүйлийг илрүүлэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хяналт гэнэ.

Сайн менежер байхын тулд түүнд тодорхой ур чадварууд байх ёстой. Тэдгээрийг ерөнхийд нь 3 бүлэгт авч үздэг:

- a. техникийн ур чадвар
- b. харилцааны ур чадвар
- c. шийдвэр гаргах ур чадвар

Дээр олонтаа дурдагдаж байсан зорилго, зорилт ба түүнтэй холбоотой үйл явц болох төлөвлөлтийн тухай дэлгэрүүлэн авч үзье. Төлөвлөлт гэж чухам юу болохыг

дээр авч үзсэн бөгөөд уг төлөвлөлт нь үйл ажиллагааны, тактикийн ба стратегийн гэсэн 3 түвшинд хийгддэг. Харин байгууллагын ерөнхий, үндсэн зорилго бөгөөд ирээдүйд хүрэх эцсийн дүнг харуулагч нь бол байгууллагын эрхэм зорилго болдог байна. Уг эрхэм зорилго тухайн байгууллагын бүх хүмүүсийн гол яриа, итгэл үнэмшил, тэмүүлэл нь байх ёстой байдаг. Эрхэм зорилгоос үүдэн түүнд хүрэх байгууллагын тодорхой хэмжигдэхүйц, цаг хугацаатай, биелэгдэхүйц зорилтууд байх хэрэгтэй.



Хяналтын асуулт

- ▲ Менежментийн функцууд нь хоорондоо хэрхэн нөлөө үзүүлдэг вэ?
- ▲ Менежер хүний гүйцэтгэх үүрэг юунаас шалтгаалах вэ? Яагаад ялгаатай үүрэг гүйцэтгэдэг вэ?
- ▲ Менежмент пүүст яагаад зайлшгүй шаардлагатай вэ?
- ▲ Пүүсүүдийн амжилтанд хүрдэг гол шалтгаануудыг нэрлэ.
- ▲ Менежментийн үйл ажиллагаа нь экономиксийн шийдвэр гаргалтуудтай яаж холбогддог вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 61-62 тал
2. Т. Дорж, Менежментийн ухаан, УБ.2000,
3. Да. Болормаа, Менежментийн үндэс, УБ, 1998
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006

4. Маркетингийн тухай ойлголт

- ▲ Сүлжээний бизнес ба маркетинг
- ▲ Маркетингийн тухай ойлголт
- ▲ Маркетингийн үүсэл, хөгжил, ерөнхий ойлголт
- ▲ Маркетингийн иж бүрдэл, тэдгээрийн уялдаа пүүст хэрхэн нөлөөлөх
- ▲ Маркетингийн удирдлагын гүйцэтгэх үүрэг

Маркетинг гэдэг нь зах зээл судлал гэсэн утгатай бөгөөд 1905 онд АНУ-д анх хэрэглэгдэж байсан байна. Маркетинг нь хувь хүн ба бүлэг хүмүүс бүтээгдэхүүн ба ажил үйлчилгээг бүтээх буюу борлуулах замаар өөр гачигдсан болон хэрэгцээтэй зүйлийг олж авах нийгмийн болон удирдлагын үйл ажиллагаа юм /Ф. Котлер, Ж. Амстронг/. Гэхдээ маркетинг дараах үйл ажиллагаануудыг хамарсан цогц утгатай шинжлэх ухаан. **Эдгээр нь:**

- a. хэрэглэгчийн юу хүсч байгааг судлан илрүүлэх
- b. хүсч байгаа зүйлийг бий болгох, үйлдвэрлэх боломж байгаа эсэхийг судлах
- c. ашгийг хамгийн их байлгаж зардлыг хамгийн бага байлгах
- d. бүтээгдэж бий болсон ажил үйлчилгээг хамгийн бага зардлаар богино хугацаанд чанарыг нь хэвээр хадгалан хэрэглэгчдэд хүргэх
- e. барааг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйлчилгээ үзүүлэх
- f. хэрэглэгчийг ханамжтай байлгах, үнэн зөв реклам явуулах



Маркетингийн удирдлагын дараах үзэл баримтлалууд байдаг. Үүнд:

- a. үйлдвэрлэлийг боловсронгуй болгох: үйлдвэрлэлийн хэмжээ
- b. бүтээгдэхүүнийг боловсронгуй болгох: бүтээгдэхүүний чанар
- c. худалдааны үзэл баримтлал: борлуулалтын хэмжээ
- d. маркетингийн үзэл баримтлал: хэрэглэгч рүү илүү анхаарал хандуулдаг
- e. нийгмийн үзэл баримтлал: хэрэглэгч, пүүс, нийгэм гэсэн 3-ын холбоог авч үздэг

Пүүс шинэ бараа бүтээж зах зээлд нэвтрүүлж амжилт олоход маркетингийн нарийн ур ухаан шаардлагатай. Ерөнхийдөө пүүст шинэ бараа бий болгох 2 арга байдаг. **Үүнд:**

- a. гаднаас олж авах /ямар нэг пүүсийг бүхлээр нь эсвэл өөр үйлдвэрийн барааны патент, лицензийг худалдан авах/
- b. дотоодын хүчин чармайлтаар /өөртөө судалгаа шинжилгээ, боловсруулалтын хэлтэс байгуулах/

Шинэ бараа гэдэгт одоо байгаа барааг өөрчилж сайжруулсны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, эрдэм шинжилгээний байгууллагын бүтээсэн шинэ бүтээл орно. Гэхдээ шинэ бараа бүр амжилт олдоггүй. **Учир нь**

- a. зах зээлийн багтаамжийг хэт үнэлдэг
- b. барааны хэрэгцээг сайн судлаагүй
- c. хэт өндөр үнэтэй гаргах
- d. бараа бүтээхэд гарах зардал нь тооцоолсноос их байх
- e. өрсөлдөгчийн хариу үйлдэл бодож байснаас илүү их байх гэсэн шалтгаанууд байж болох юм.

Шинэ бараа бүтээх нь дараах үндсэн шатуудтай. **Эдгээр нь**

- a. санаа олох, сонголт хийх
- b. сонгосон санааг боловсруулах ба шалгах
- c. маркетингийн стратегийг боловсруулах
- d. үйлдвэрлэл, боловсруулалтын боломжийн судалгаа
- e. барааг бүтээх
- f. барааг турших
- g. өргөн үйлдвэрлэл

Ийнхүү бүтээсэн бараа бүхэн /ер нь бүх бараа гэсэн үг/ өөрийн амьдралын мөчлөгтэй байдаг ба түүнийн шинж ба үргэлжлэх хугацааг урьдчилан хэлэх боломжгүй юм. Барааны амьдралын мөчлөг нь дараах 4 үе шаттай байдаг:

- a. зах зээлд нэвтрэх үе: барааг түгээх, худалдаанд нийлүүлэх мөчөөс эхэлдэг
- b. өрнөлтийн үе
- c. боловсролтын үе
- d. уналтын үе

Маркетингийн иж бүрдлийн салөггүй нэг хэсэг нь идэвхижүүлэлт буюу явцуу утгаараа зар сурталчилгаа байдаг. Түүнчлэн энд борлуулалтын сувгийн тухай яригддаг байна.



Хяналтын асуулт

- ▲ Маркетингийн удирдлага нь пүүст хэрхэн нөлөө үзүүлдэг вэ? Эдгээр нөлөөллөөс гарах үр дүн юу вэ?
- ▲ Маркетингийн зайлшгүй хэрэгцээг хэрхэн үзэж байна?
- ▲ Маркетингийн иж бүрдлийн хоорондын холбоог нэгэн барааны хувьд тайлбарла.



Ном зүй

1. Т. Түвшинзаяа, Маркетингийн удирдлага, УБ, 2002
2. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006

5. Хүчин зүйлсийн зах зээл: хөдөлмөр, капитал, газар

- ▲ Хүчин зүйлсийн зах зээл: Төгс өрсөлдөөнт хүчин зүйлсийн зах зээл
- ▲ Монопсони болон монополия байдал
- ▲ Хүчин зүйлсийн эрэлт ба нийлүүлэлт, уламжлагдсан эрэлт
- ▲ Бүтээгдэхүүн, нийт, дундаж ба ахиуц бүтээгдэхүүн
- ▲ Хүчин зүйлсийн үнэ тогтох нь
- ▲ Хөдөлмөрийн зах зээл, Үйлдвэрчний эвлэлийн үүрэг, оролцоо
- ▲ Капитал болон газрын зах зээл

Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн тухай өмнө нь цухас дурьдсан. 4 хүчин зүйлийг нэрлэж байсан билээ. Хөдөлмөр, Газар, Капитал, Аж ахуй эрхлэх ур чадвар гэсэн 4 нөөц буюу хүчин зүйлийг ашиглан бизнесийн үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр нь тэгэхээр эцсийн хэрэглээнд биш, тэр эцсийн хэрэглээг хангахад зориулагдах бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд чиглэгддэг байна. Энэ утгаараа бэлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлээс өөр төрлийн зах зээл дээр арилжаалагддаг. Үүнийг нийтэд нь хүчин зүйлийн зах зээл гэж нэрлэх боловч хүчин зүйл тус бүрдээ онцлогтой зах зээлийг бүрдүүлнэ. Бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлийн нэгэн адил зарчмууд хүчин зүйлийн зах зээлд үйлчлэх боловч ялгарах хэдэн онцлогтой.

- а. Хүчин зүйлсийн эрэлт нь уламжлагдсан шинжтэй байдаг. Тэрхүү хүчин зүйлийг ашиглаж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ хичнээн их эрэлттэй байна, уг хүчин зүйлийн эрэлт төдийчинээ эрэлт ихтэй байх болно.
- б. Зарим хүчин зүйлийн нийлүүлэлт нь бараг тогтмол байдаг.
- в. Хүчин зүйлсийн үнэ нь түүний орлогоор тодорхойлогдоно. Тухайлбал, хөдөлмөрийн үнэ нь цалин, газрынх рент, капиталынх хүү, үйлдвэрлэл эрхлэх ур чадварынх ашиг байх жишээтэй.

Хүчин зүйлийн зах зээл нь төгс ба төгс бус гэж ангилагддаг. Төгс зах зээл нь бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн нэгэн адил шинжтэй. Олон нийлүүлэгч, хэрэглэгчтэй гэсэн үг.

Харин төгс бус өрсөлдөөнт зах зээлийн хувьд монопсони шинжийг агуулдаг. Монопсони гэдэг нь нэг хэрэглэгч, нэг худалдан авагч гэсэн утгатай. Хөдөлмөрийн хүчин зүйлийн зах зээл дээр илүүтэй тохиолддог монопсони **пүүс нь:**



- a. тухайн төрлийн хөдөлмөрийн дийлэнх хэсгийг ганц том пүүс эзэмшдэг
- b. уг хөдөлмөр эрхлэгчид тодорхой шалтгааны улмаас өөр ажлын байранд шилжих боломжгүй
- c. ганцхан том пүүс ажилчдын цалин хөлсийг хянан тогтоож байдаг.

Үйлдвэрлэл явуулахын тулд хүчин зүйлүүдийг худалдан авахдаа түүнд зарцуулж буй зардал, түүнээс олж буй орлого хоёрыг харьцуулж үзэх нь мэдээж. Экономиксийн хичээлээр бид хүчин зүйлийн бий болгож буй бүтээгдэхүүн, түүнээс олж буй орлого, нэгж хүчин зүйлд зарцуулж буй зардлыг тооцож үзнэ.

Пүүсийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээний нийлбэрийг нийт бүтээгдэхүүн гэдэг ба ихэнхдээ TP гэж тэмдэглэдэг.

Үүнийг хүчин зүйлийнхээ тоонд харьцуулбал нэгж хүчин зүйлд ногдох дундаж бүтээгдэхүүн гарна.

$$AP_L = TP/L, \quad AP_K = TP/K,$$

Энд AP_L - хөдөлмөрийн дундаж бүтээгдэхүүн
 AP_K - капиталын дундаж бүтээгдэхүүн
 TP - нийт бүтээгдэхүүн
 L - хөдөлмөрийн хүчин зүйл
 K - капиталын хүчин зүйл

Энэ хялбархан тооцоо бөгөөд эдгээр дээр үндэслээд хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүний үзүүлэлтийг тооцоолдог. Ахиу бүтээгдэхүүн гэдэг нь хүчин зүйлийг нэгжээр нэмэгдүүлж авахад нийт бүтээгдэхүүний хэмжээ хэрхэн өөрчлөгдөхийг харуулна. Тооцохдоо нийт бүтээгдэхүүний өөрчлөлтийг хүчин зүйлийн өөрчлөлтөд харьцуулдаг.

$$MP_L = \Delta TP / \Delta L, \quad MP_K = \Delta TP / \Delta K$$

MP_L - хөдөлмөрийн ахиу бүтээгдэхүүн
 MP_K - капиталын ахиу бүтээгдэхүүн
 ΔTP - нийт бүтээгдэхүүний өөрчлөлт
 ΔL - хөдөлмөрийн хүчин зүйлийн өөрчлөлт
 ΔK - капиталын хүчин зүйлийн өөрчлөлт

Бид хүчин зүйлийг ашиглан юу бүтээж вэ? гэдгээ тооцдог боллоо. Нэгэнт хийсэн зүйлс тодорхой учраас орлого тооцоход хялбархан. Өмнөх хичээлээр ахиу орлогын тухай үзсэн. Төгс өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлд ахиу орлого нь бүтээгдэхүүнийхээ үнэтэй тэнцүү гэдгийг ч мэддэг болсон байгаа. Харин одоо тэр үзүүлэлтийг ашиглан хүчин зүйлийн орлогыг тооцох гэж байна. Сая үзсэн ахиу бүтээгдэхүүний үзүүлэлтийг ахиу орлогоор үржүүлбэл ахиу бүтээгдэхүүний орлого гарна.

$$MPR_n = MP * MR$$

MPR_n – хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүний орлого
 MP – хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүн
 MR - ахиу орлого

Энэхүү тооцоотой төстэй байдлаар хүчин зүйлийн зардлыг тооцож гаргаад харьцуулалт хийнэ. Нийт зардал (ТС) нь аж ахуйн нэгжээс гаргаж буй зардлын нийлбэр дүн юм. Харин ахиу зардлыг хүчин зүйлүүдийн хувьд тооцвол дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

$$MFC_n = \Delta TC / \Delta n,$$

MFC_n – хүчин зүйлийн ахиу зардал

ΔTC – нийт зардлын өөрчлөлт

Δn – хүчин зүйлийн өөрчлөлт

Аливаа бизнес эрхлэгч маань хүчин зүйлийн ахиу орлого ба ахиу зардалыг харьцуулж хэдийн хэмжээний хүчин зүйл худалдан авахаа шийдвэрлэнэ. Хамгийн зохимжтой түвшин бол хүчин зүйлийн ахиу бүтээгдэхүүний орлого нь ахиу зардалтайгаа тэнцүү байх үе юм.

$$MPR_n = MFC_n$$

Мэдээж бизнэс эрхлэгчид энэ тооцоог хийж ашгаа хамгийн их болгохыг зорьдог. Чөлөөт өрсөлдөөний зах зээл дээр ахиу зардал нь тухайн хүчин зүйлсийн үнээр тодорхойлогддог. Ингэхээр хүчин зүйлийн үнэ хэрхэн тогтохыг ч мэдэх шаардлагатай. Хичээлийн эхэнд хүчин зүйлсийн үнийн талаар дурьдсан.

Хөдөлмөрийн ба капиталын зах зээл дээр эрэлт, нийлүүлэлтийн харьцаагаар үнэ тогтоно. Газрын зах зээлийн хувьд ч адилхан боловч, зарим онцлог байдаг. Хүчин зүйл тус бүрийн хувьд семинарын хичээлээр дэлгэрэнгүй ярилцана.



Хяналтын асуулт

- ▲ Хүчин зүйлсийн үнэ хэрхэн тогтох вэ?
- ▲ Хүчин зүйлсийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, бүтээгдэхүүний зах зээлийнхээс ямар ялгаатай вэ? Тайлбарла
- ▲ Төгс өрсөлдөөнт үеийн хүчин зүйлсийн сонголт нь яаж хийгддэг вэ?
- ▲ Монополь болон монопошийн ялгаа нь юунд орших вэ?
- ▲ Хүчин зүйлсийн зах зээлийн эрэлт нь яагаад уламжлагдсан шинж чанартай байдаг вэ?
- ▲ Газрын нийлүүлэлтийн мэдрэмж нь яагаад тэг байдаг вэ?
- ▲ Хөрөнгийн өнөөгийн өртөг болон ирээдүйн өртөг нь ялгаатай байдгийн учир юу вэ?
- ▲ Үйлдвэрчний Эвлэлийн оролцоо хүчтэй үед хөдөлмөрийн зах зээл яагаад монополь шинж чанартай байдаг вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 66-79 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 277-392 тал
3. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 120-129, 264-265 тал
4. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, “Эдийн засгийн ухаан”, 2000, 65-84 тал
5. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
6. А.Бакей, Р.Оросоо, “Эдийн засгийн ухаан”, 1998, УБ, 108-146 тал
7. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005
8. Газрын хэвлийн тухай, 1988 Монгол улсын хууль, УБ.
9. Газрын тосны тухай Монгол улсын хууль, 1991, УБ.



10. Газрын тухай Монгол улсын хууль, 2002, УБ.
11. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай Монгол улсын хууль, 1991, УБ.
12. Өмч хувьчлалын тухай Монгол улсын хууль, 1991, УБ.
13. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай Монгол улсын хууль, 1998, УБ.
14. Хөдөлмөрийн тухай Монгол улсын хууль, 1999, УБ.

IV бүлэг. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, АСУУДЛУУД

Бүлгийн зорилго: Улс орны хэмжээний эдийн засгийн байдал, өсөлт, хөгжил, эдийн засгийн бодлого, арга хэрэгслүүдийн талаар үндсэн мэдлэгтэй болж, ажилгүйдэл, инфляци, мөнгө зэрэг эдийн засгийн үзэгдлүүдийн мөн чанарыг ойлгон, тайлбарлах чадвар эзэмшин, улс орны хөгжлийн зөв хандлагыг тодорхойлох эрмэлзлэл, хандлагатай болоход оршино.

1. Үндэсний тооцооны систем

- ▲ Үндэсний Баялаг
- ▲ Нийт эдийн засгийг хэмжих нь: Дотоодын нийт бүтээгдэхүүн, бусад
- ▲ Эдийн засгийн өсөлт: нэрлэсэн ба бодит өсөлт
- ▲ Бодит өсөлтийг тодорхойлох
- ▲ Өсөлтийг дэмжих болон өсөлтийн эсрэг үзэл баримтлал
- ▲ Дотоодын нийт бүтээгдэхүүн ба инфляци
- ▲ Аж үйлдвэржилт

Тухайн улс үндэстний орлого зарлагын урсгалыг тодорхойлдог үзүүлэлтүүдийг Үндэсний тооцооны системийн үзүүлэлтүүд гэж нэрлэдэг.

Улс орны хэмжээн дэх үйлдвэрлэлийн бүх нөөцийг ашиглан үйлдвэрлэгдэж буй нийт бүтээгдэхүүн үйлчилгээний нийлбэр дүнг Үндэсний нийт бүтээгдэхүүн гэнэ. Энэ тохиолдолд тухайн үйлдвэрлэлийн нөөцүүд нь хилийн чанадад байршиж байж болно. Тухайн улс орны хил хязгаар дотор буй үйлдвэрлэлийн нөөцүүдийг ашиглан үйлдвэрлэж байгаа нийт бүтээгдэхүүн үйлчилгээний нийлбэрийг Дотоодын нийт бүтээгдэхүүн гэнэ.

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг орлогоор болон зардлаар тооцдог.

Орлогоор

- Цалин (W)
- Зээлийн хүүгийн төлбөр (i)
- Өмчийн орлого (PP)
- Түрээсийн төлбөр (R)
- Бизнесийн шууд бус татвар (Tin)
- Корпорацийн ашиг (P)
- Капиталын элэгдэл (d)

$$\text{ДНБ} = W + i + PP + R + Tin + P + d$$

- Зардлаар
- Хувийн хэрэглээний зардал (C)
- Хөрөнгө оруулалтын зардал (I)
- Засгийн газрын зардал (G)
- Цэвэр экспорт (NX)

$$\text{ДНБ} = C + I + G + NX$$

$$\text{ОРЛОГООР ТООЦСОН ДНБ} = \text{ЗАРДЛААР ТООЦСОН ДНБ}$$



Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь эдийн засгийн өсөлтийг хэмждэг үзүүлэлт болдог. Эдийн засгийн өсөлт нь тухайн жилд үйлдвэрлэгдсэн ДНБ нь өмнөх үеийнхээс хэдэн хувиар давсан эсвэл буурсан байна гэдгийг харуулдаг үзүүлэлт юм. Гэхдээ өсөлтийг бодитой болгохын тулд бодит үзүүлэлтийг авч үздэг. ДНБ нь тухайн оны үнээр илэрхийлэгдэж байвал нэрлэсэн, суурь оны үнээр илэрхийлэгдэж байвал бодит үзүүлэлт болдог. Нэрлэсэн ДНБ-ийг бодит ДНБ-д харьцуулсан харьцааг дефлятор гэдэг. Энэ нь тухайн үеийн эдийн засгийн ерөнхий үнийн түвшинг илэрхийлдэг үзүүлэлт юм. Жишээлбэл, А улсын ДНБ 2005 онд нэрлэсэн дүнгээр 500 тэрбум байсан гэе. 2004 оны үнээр буюу суурь оны үнээр илэрхийлсэн үзүүлэлт нь 420 тэрбум бол энэ үзүүлэлт нь эдийн засгийн өсөлтийн тооцоололд ашиглагдана. Энэ үед 2004 оны ДНБ 400 тэрбум байсан бол 2005 онд эдийн засгийн өсөлт нь 5% байна гэсэн үг. Жил бүрийн үнийн түвшний өөрчлөлт нь инфляци болдог.



Хяналтын асуулт

- ▲ Дотоодын нийт бүтээгдэхүүн, Үндэсний нийт бүтээгдэхүүний ялгаа нь юу вэ?
- ▲ Эдийн засгийн бодит өсөлтийг яагаад нэг хүнд ногдох бодит орлогын өсөлтөөр тодорхойлдог вэ?
- ▲ Эдийн засагчдын зарим хэсэг нь эдийн засгийн түргэн өсөлт хортой гэж яагаад үздэг вэ?
- ▲ Аж үйлдвэржилт нэмэгдэх нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтөд яаж нөлөөлөх вэ?



Дасгал

Өгөгдөл:

Зээлийн хүү 24, нийт хөрөнгө оруулалт 110, цалин 436, корпорацийн ашиг 226, түрээсийн орлого 40, корпорацийн ашгийн татвар 100, цэвэр экспорт 22, засгийн газрын зардал 42, шилжих төлбөр 46, хэрэглээний зардал 520 бол ДНБ-ийг тооц.

Бодолт:

ДНБ-ийг хоёр аргаар тооцох боломжтой ба дээрх бодлогын нөхцөлд орлогоор тооцоход шаардлагатай зарим үзүүлэлт, тухайлбал бизнесийн шууд бус татвар өгөгдөөгүй тул зөвхөн зардлаар тооцно. Зардлаар тооцоход дараах томъёог ашиглана.

$$\text{ДНБ} = C + I + G + NX = 520 + 110 + 42 + 22 = 694$$

Бодлого:

1. Монгол улсын 2005 оны эдийн засгийн дараах үзүүлэлтүүд өгөгджээ.

Үзүүлэлтүүд		Үзүүлэлтүүд	
Экспорт	367	Корпорацын орлогын татвар	88
Ноогдол ашиг	60	Шилжих төлбөр	320
Капиталын элэгдэл	307	Зээлийн хүүгийн төлбөр	201
Цалин	1442	Өмчийн орлого	132
Засгийн газрын зардал	577	Хувийн хэрэглээний зардал	1810
Түрээсийн төлбөр	33	Импорт	338
Бизнесийн шууд бус татвар	255	Корпорацын хуваарилагдаагүй ашиг	55
Цалингийн нэмэгдэл	280	Хүн амын орлогын татвар	372
Дотоодын нийт хөрөнгө оруулалт	437	Гадаад хүчин зүйлсийн цэвэр орлого	0

ДНБ-ийг орлого ба зардлаар тооц.

2. Нийт хувийн хөрөнгө оруулалт 110, зээлийн хүү 34, цалин 436, корпорацийн ашиг 226, шууд бус татвар 44, түрээсийн орлого 40, корпорацийн ашгийн татвар 100, цэвэр экспорт 22, цэвэр хувийн хөрөнгө оруулалт 100, өмчийн орлого 42, улсын үйлдвэрийн газруудад үзүүлэх мөнгөн тусламж 4, шилжих төлбөр 46, хэрэглээний зардал 520 бол ДНБ-ийг тооц.



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 84-98 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 17-48 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, “Эдийн засгийн ухаан”, 2000, 109-118 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А.Бакей, Р.Оросоо, “Эдийн засгийн ухаан”, 1998, УБ, 147-155 тал
6. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006

2. Монгол улсын эдийн засгийн өсөлт, түүтэй холбоотой асуудлууд

- ▲ Монгол улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийн байдал
- ▲ Эдийн засгийн бүтэц, эдийн засгийн хараат байдал
- ▲ "Голланд өвчин"
- ▲ Хүн амын орлогын өөрчлөлт
- ▲ Хүн амын амьжиргааны түвшин, түүнтэй холбоотой асуудлууд



Жишээ 1. Эдийн засгийн өсөлтийн тойм, 2005

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2005 онд 6.2 хувьд хүрсэн бөгөөд үүний 1.6 функтыг ХАА-н салбар, 4.9 функтыг үйлчилгээний салбарын өсөлт тус тус хангасан байна. Харин аж үйлдвэрийн салбар эдийн засгийн өсөлтөд -0.2 хувийн нэмэр оруулсан буюу эдийн засгийн өсөлтийг бууруулсан юм.

Газар тариалангийн салбарт ургацын хэмжээ өмнөх оноос буурч байгаа, нэхмэл, оёмол бүтээгдэхүүнийг АНУ, Европын холбооны зах зээлд нийлүүлж байсан хөнгөлөлтийн нөхцөл байхгүй болсон зэрэг шалтгаанаар эдийн засгийн өсөлт өмнөх оноос саарсан.

2005 онд нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 40 хувиар, хувцасны үйлдвэрлэл 66 орчим хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтийг хойш нь 2.0 орчим хувиар чангаасан. Харин 2005 оны дундуур Монгол улсын бараа бүтээгдэхүүнийг Европын Холбооны хөнгөлөлтийн нөхцөлд хамруулах талаар яриа хэлэлцээрийг идэвхтэй хийсний дүнд энэхүү хөнгөлөлтийн нөхцөлд Монгол улсыг хамруулж чадсанаар нэхмэл, оёмол хувцасны үйлдвэрлэл эргэж сэргэх хандлагатай байгаа.

2005 оны хувьд тээвэр, холбооны салбар, мал аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтөд жинтэй хувь нэмэр оруулжээ. Төмөр замын тээврээр дамжин өнгөрөх ачаа эргэлт харьцангуй нэмэгдэж байгаа, үүрэн телефоны салбарт гуравдагч оператор гарч ирэх гэж байгаа зэрэг нь үүнд нөлөөлсөн байна. Мөн 2004-2005 оны өвөл, хавар харьцангуй таатай байсан нь малын тоо толгой өсөхөд нөлөөлжээ. 2004 онд ганц том алтны үйлдвэрлэл ашиглалтад орж 10.6 хувийн эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байсан бол 2005 оны эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсгийг тээвэр, холбоо, мал аж ахуй зэрэг иргэд, байгууллагын үйл ажиллагаанд үр аюлтай үйлчилгээний салбарын өсөлт бүрдүүлсэн байна. Тухайлбал үүрэн холбооны гуравдагч операторын асуудлыг шийдэж чадсан нь үйлчилгээний үнэ тарифт нөлөөлж, үйлчилгээний үнэ тариф 2005 онд нилээд хэмжээгээр буурч, холбооны салбарын орлого өссөн байна.

Эх үүсвэр: *Үндэсний статистикийн газар,
Монгол Банк, 2005*

Жишээ 2. Голланд өвчин

1960-аад онуудад Голланд орон Хойд тэнгисд нефть ба шатах хий олборлож, тэдгээрийг ихээхэн хэмжээгээр экспортод гаргадаг болсноос хойш улс орны ерөнхий эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд нь сайжирсан боловч аж ахуйн зарим салбар нь уналтанд орж ажилгүй (Голландын ойлголтоор бол ажиллах чадваргүй) хүмүүсийн тоо өсч, иргэдийнхээ дургуйцлийг төрүүлсэн түүхтэй. Энэ үзэгдлийг л эдийн засгийн "голланд өвчин" гэж нэрлэх болсон. Гэхдээ энэ "өвчин" зөвхөн Голланд улсыг нэрвэж хямралд оруулсан хэрэг биш, 1970-аад оноос бараг ихэнх буурай орнуудыг хамарсан. "Голланд" өвчин байгалийн баялгаар арвин боловч буурай хөгжилтэй, ядуу орнуудыг ихэвчлэн нэрвэдэг бөгөөд түүний ерөнхий утга агуулга нь Голландад болсон явдалтай бараг ижил. Ядуу буурай хөгжилтэй орнуудын хувьд бол голланд өвчин хэмээх үзэгдлийг байгалийн баялагийн "гай" буюу эсвэл "хараал хүрсэн" байгалийн баялаг гэж нэрлэдэг. Эдгээр орнууд мөн л байгалийн баялгаа үлэмжхэн хэмжээгээр экспортлож, улс орныхоо ерөнхий хөгжилд нэмэрлэдэг боловч, ард иргэдийнхээ аж амьдралыг дорвитой дээшлүүлж чадаагүй хэвээрээ.

Байгалийн баялаг элбэгтэй орнууд "голланд өвчин" тусмагц төр засаг нь "бэхжиж" хүнд сурталжиж, цөөхөн хүмүүс нь баяждаг боловч ард иргэд нь нийтдээ ядууралд нэрвэгдэх жам төлөвтэй болжээ.

Эх үүсвэр: Ц. Даваадорж, "Голланд өвчинд" нэрвэгдсэн Монголын эдийн засаг, ангижрах арга замууд, илтгэлийн хэсгээс



Хяналтын асуулт

- ▲ Эдийн засгийн бодит өсөлтийг хэрхэн тодорхойлдог вэ?
- ▲ Манай орны хувьд амьжиргааны доод түвшнийг ямар үзүүлэлтийг үндэслэн тодорхойлдог вэ?
- ▲ Эдийн засгийн хараат байдлыг илэрхийлдэг үзүүлэлтүүдийн талаар ярилц.
- ▲ Хөдөө аж ахуйн сектор давамгайлахын сул ба давуу талууд
- ▲ "Голланд өвчний" тухай юу мэдэх вэ?
- ▲ Манай улс яагаад гуравдагч ертөнцийн орнуудын тоонд ордог вэ?
- ▲ Секторын бүтэц эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлж болох вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 144-154 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 3-14, 265-282 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 213-216 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А.Бакей, Р.Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 175-186 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006
7. <http://libertari.mn/>

3. Эдийн засгийн хөгжлийн ялгаа, хэрэглээ ба хадгаламж, хөрөнгийн оруулалт

- ▲ Хувийн орлого: Хэрэглээ, хадгаламж,
- ▲ Нийт эрэлт, нийт нийлүүлэлт
- ▲ Макро эдийн засаг дахь тэнцвэр
- ▲ Хөрөнгө оруулалт, капиталын элэгдэл
- ▲ Зээлийн хүү, хөрөнгө оруулалтын ашгийн норм
- ▲ Монгол улсын хэрэглээ, хадгаламжийн түвшин, түүний эдийн засаг дахь нөлөөлөл
- ▲ Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт
- ▲ Хөрөнгө оруулалтын бодлого

Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг нь хувийн хэрэглээний зардал байдаг. Хувийн хэрэглээний зардал гэдэг нь өрх гэр, хувь хүмүүсийн тухайн эдийн засагт хийж буй нийт худалдан авалтыг хэлнэ. Өрх гэр, хувь хүмүүс нь орлогын нэг хэсгийг өнөөгийн хэрэглээндээ зарцуулдаг бол үлдсэн хэсгийг нь ирээдүйд хэрэглэх зорилгоор хуримтлуулдаг ба төрийн оролцоогүй эдийн засагт энэ хуримтлал нь



нийт хадгаламжийг илэрхийлдэг. Ингэхээр хэрэглээ гэсэн үзүүлэлтийн талаар ярихад үүний цаана хадгаламж гэсэн ойлголтыг заавал авч үздэг. Хэрэглээ болон хадгаламжид дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

- өнөөгийн орлого
- ирээдүйн орлого
- бодит хүүгийн түвшин
- өрх гэрүүдийн эзэмшиж буй баялаг зэрэг

Монгол улсын хувьд өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад хэрэглээний түвшин өндөр, хадгаламжийн түвшин доогуур байдаг. Энэ нь хүмүүсийн орлогын түвшин доогуур, амьжиргааны өртөг өндөр байдагтай холбоотой.

Макро эдийн засгийн өөр нэг гол үзүүлэлт бол пүүсүүдийн зардлыг илэрхийлдэг үзүүлэлт болох хөрөнгө оруулалт юм. Хөрөнгө оруулалт гэдэг нь тухайн жилд нэмэгдэж буй нийт капиталын хэмжээ буюу эдийн засаг дахь нийт капиталын өөрчлөлтийг хэлдэг. Хөрөнгө оруулалтын эрэлт нь түүнээс хүлээгдэж буй ашгийн түвшнээс хамаардаг ба үүнийг хөрөнгө оруулалтын ашгийн норм гэж нэрлэдэг. Хэрвээ эдийн засаг дахь бодит зээлийн хүүгийн түвшнээс хөрөнгө оруулалтын ашгийн норм багагүй байвал тухайн хөрөнгө оруулалт хийгдэх боломжтой. Хөрөнгө оруулалт нь нийт ба цэвэр гэсэн хоёр дүнгээр тооцогддог ба цэвэр хөрөнгө оруулалт нь капиталын өөрчлөлтийн жилийн эцсийн дүн юм. Энэ нь нийт капиталын өөрчлөлтийн тухайн жилд ашиглагдсан хэсэг буюу капиталын элэгдэийг хассан дүн байна. Хөрөнгө оруулалтад дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

- капиталын бүтээмж: Нэгж капиталын үйлдвэрлэлийн хэмжээ.
- бодит хүүгийн түвшин: Мөнгөний үнэ буюу нэрлэсэн хүүгээс инфляцийг хассан ялгавраар тодорхойлогддог.
- хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй үр ашиг
- татвар ба татаас.

Хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн нөхцөл байдал нь доогуур байдаг тул тэр бүр дотоод эх үүсвэрээр хангалттай хөрөнгө оруулалт хийх боломж байдаггүй. Иймээс гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд эдийн засгийн тогтвортой, таатай орчныг бүрдүүлэхийг эрмэлзэж байдаг. Манай улсын хувьд ч эдийн засгийн өсөлтийг урамшуулдаг гол үзүүлэлт нь гадаадын хөрөнгө оруулалт байдаг.

Жишээ 3: Монгол улсын нийт хөрөнгө оруулалт, гадаад хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь 1996 онд 5.7%, 1997 онд 4.0%, 1998 онд 5.0% байсан бол 1999 онд ДНБ-ий 10.0%-д хүрсэн ба энэ нь гадаадын нийт хөрөнгө оруулалтын 63.3%-г, нийт хөрөнгө оруулалтын 36.0%-г эзлэх болсон байна.

2000 оноос манай орны Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчдын чуулганыг салбарын шугамаар зохион байгуулах болсон, мөн Монголын эдийн засгийн байдал тогтворжин макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжран, улс төрийн байдал тогтворжин үүнтэй уялдан хууль, эрхзүй, татварын орчин тогтвортой байж, хөрөнгө оруулалтын үр өгөөж, нөөц, зах зээлийн байдлын судалгаанууд хийгдэх болж, өгөөж өндөртэй өсөж буй салбарт их хэмжээгээр хөрөнгө оруулалт орж ирэх болсноор хөрөнгө оруулалт хурдацтай

өсөх болсон. ДНБ-нд эзлэх нийт хөрөнгө оруулалтын эзлэх хувь 2000-2004 онд 26.5-29.2%-тай байлаа. Эдгээрээс харахад 2000 оноос хойш нийт хөрөнгө оруулалтын хурдацтай өсөлт нь гадаадын хөрөнгө оруулалтын өсөлтөөр тайлбарлагдах бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт дотроо шууд хөрөнгө оруулалт нь 61.2-93.5%-ийг эзэлж байсан байна. Харин 2004 онд хөрөнгө оруулалт нэрлэсэн дүнгээрээ өссөн бөгөөд өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтын үр ашиг болон гадаад зах зээлийн таатай нөхцлөөс эдийн засаг 2004 онд 10.6% болж өссөнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт, ДНБ-ний харьцаа буурчээ.



Хяналтын асуулт

- ▲ Хэрэглээ, хадгаламж, хөрөнгө оруулалтад нөлөөлдөг хүчин зүйлсийг нэрлэ.
- ▲ Эдийн засгийн тэнцвэр тогтох нөхцлийг тайлбарла.
- ▲ Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг яагаад хэрэгжүүлдэг вэ?
- ▲ Манай улсын хувьд аль салбарт хөрөнгө оруулалт хамгийн их хийгддэг вэ? Яагаад?
- ▲ Манай улсын хэрэглээний түвшин яагаад өндөр байдаг вэ? Үүний сөрөг дагавар нь юу вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 84-98 тал
2. Б.Баярдаваа, ДГансүлд, Макрoэкономикс, УБ., 2006, 149-172 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 146-156 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 165-174 тал
6. Макрoэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006



4. Ажилгүйдэл ба инфляци

- ▲ Эдийн засгийн хэлбэлзэл, эдийн засгийн мөчлөг
- ▲ Хэвийн өсөлтийн түвшин
- ▲ Дотоодын нийт бүтээгдэхүүний алдагдал
- ▲ Ажилгүйдэл, түүний хэлбэрүүд, шалтгаан, үр дагавар
- ▲ Инфляци, түүний шалтгаан үр дагаврууд
- ▲ Дефляци, стагфляци
- ▲ Ажилгүйдэл ба инфляцийн харилцан хамаарал


Макро эдийн засгийн хүндрэлтэй асуудлуудын тоонд ажилгүйдэл ба инфляци орно. Тиймээс энэ талаар дэлгэрэнгүй ойлголтой байх нь эдийн засгийн амьдралд оролцогч хүн бүрт зайлшгүй юм. Нэн ялангуяа ажилгүйдлийн талаар цэгцтэй ойлголттой байх нь хуульч болох гэж байгаа хүнд үлэмж ач холбогдолтой. Ажилгүйдэл ба инфляцийн тухай ярихаасаа өмнө эдийн засгийн үйл ажиллагааны цаг хугацаан дахь идэвхжил болон бууралтыг агуулсан эдийн засгийн хэлбэлзлийн талаар авч үзье.

- Өрнөл: Эдийн засаг дахь орлого тогтвортой өсөх хэсэг
- Оргил: Өсөлтөөс уналт залгах үе
- Уналт: Орлого буурах үе
- Хямрал: Уналтаас өсөлт залгах үе

Урт хугацааны өсөлтийн дундаж түвшинг хэвийн өсөлтийн түвшин гэнэ.

Эдийн засгийн хэлбэлзлийн үр дагавар нь ажилгүйдэл болон инфляци гэсэн хоёр үзүүлэлт болдог. Ажилгүйдэл гэдэг нь хүн ажил эрхлэх хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй байгаад ажил олж чадахгүй байх явдал юм. Олон улсын байгууллагуудад хэрэглэгддэг тодорхойлолтоос харахад ажилгүйчүүд гэж ажил эрхлэхгүй байгаа ажил эрхлэх сонирхолтой, ажил идэвхтэй ажил хайж байгаа хүмүүсийг хэлдэг. Ажилгүйдлийг илэрхийлдэг макро эдийн засгийн гол үзүүлэлт нь ажилгүйдлийн түвшин байдаг.

Өсөлтийн түвшин



Зураг 4.1. Эдийн засгийн хэлбэлбэл

$$\text{Ажилгүйчүүдийн түвшин} = \frac{\text{Ажилгүйчүүд}}{\text{Ажиллах хүч}} 100\%$$

Ажилгүйдэл нь дараах хэлбэрүүдтэй байна.

- Шилжилтийн ажилгүйдэл
- Бүтцийн ажилгүйдэл
- Улирлын ажилгүйдэл

Мөчлөгийн ажилгүйдэл: Эдийн засгийн мөчлөгтэй холбоотой үүсдэг ба энэ хэлбэрийн ажилгүйдэл байхгүй үед хөдөлмөрийн зах зээл тэнцвэртэй буюу эдийн засагт бүрэн ажил эрхлэлт хангагдсан байдаг. Энэ үеийн ажилгүйдлийн түвшинг хэвийн ажилгүйдэл гэнэ.

Эдийн засагт ажилгүйдэл бий болсноор үйлдвэрлэгдэх боломжтой бүтээгдэхүүний хэмжээ буурдаг ба энэхүү үйлдвэрлэгдэхгүй байгаа бүтээгдэхүүний хэмжээг ДНБ-ий алдагдал гэнэ. ДНБ-ий алдагдлыг Оукений хуулийн тусламжтайгаар тайлбарлана. Оукений хуулиар мөчлөгийн ажилгүйдэл 1% байхад алдагдал дунджаар 2.5% байдаг гэж үздэг.

Инфляци гэдэг нь үнийн түвшний ерөнхий өсөлтийг хэлнэ. Инфляцийг дараах аргаар тооцдог.

$$\text{Инфляцын түвшин} = \frac{\text{Тухайн оны үнэ}}{\text{Өмнөх оны үнэ}} 100\%$$

Инфляцийн эсрэг үзэгдлийг дефляци гэнэ. Ажилгүйдэл өсөх болон инфляци бий болох үзэгдлийг стагфляци гэнэ.



Дасгал

Өгөгдөл:

Эдийн засаг дахь бодит ажилгүйдлийн түвшин 8% ба бүтцийн ажилгүйдэл нь 2%, шилжилтийн ажилгүйдэл 2%, улирлын ажилгүйдэл 1% ба бодит үйлдвэрлэл 10000 бол потенциал(боломжит) үйлдвэрлэлийн хэмжээг ол.

Бодолт:

Потенциал болон бодит үйлдвэрлэлийн зөрүү нь ДНБ-ий алдагдлаар хэмжигдэнэ. ДНБ-ий алдагдлыг бид мөчлөгийн ажилгүйдлийн түвшнээс хамааруулж тодорхойлж болно. Иймд эхлээд мөчлөгийн ажилгүйдлийг тодорхойлъё. Эдийн засаг дахь нийт ажилгүйдэл буюу бодит ажилгүйдэл нь бүтцийн, улирлын, шилжилтийн, мөчлөгийн ажилгүйдлийн нийлбэр байх ёстой тул мөчлөгийн ажилгүйдэл нь байна. Мөчлөгийн ажилгүйдэл 1% байхад ДНБ-ий алдагдал 2.5% байдаг тул энэ үед 7.5% байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэгдэх боломжтой нийт үйлдвэрлэлийн 7.5% нь үйлдвэрлэгдэж чадахгүй байгаа ба нийт үйлдвэрлэгдэх боломжит бүтээгдэхүүний 92.5% нь 10000 байна гэсэн үг. Эндээс:

$$\text{боломжит ДНБ} = \frac{10000 * 100}{92,5} 10811$$



Хяналтын асуулт

- ▲ Эдийн засгийн мөчлөгийн хямралын үе нь нийт нийлүүлэлтийн муруйн аль хэрчмээр илэрхийлэгдэх вэ?
- ▲ Дефляци гэж юу вэ? Жишээ гаргаж тайлбарла.
- ▲ Ажилгүйдэл, инфляцийн эерэг ба сөрөг нөлөөлөл нь юу вэ?
- ▲ Инфляцийн үед үүсэх үр дагаврууд юу байж болох вэ?
- ▲ Эдийн засгийн мөчлөгийг ажилгүйдэл, инфляцитай холбон тайлбарла.



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 99-113 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 49-86 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 156-171 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 186-208 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006

5. Монгол орны ажилгүйдэл ба инфляци, эдийн засгийн шилжилт

- ▲ Монголын эдийн засгийн тогтвортой байдал
- ▲ Шилжилтийн эдийн засаг, Монголын эдийн засгийн онцлог
- ▲ Хөдөлмөрийн зах зээлийн байдал, ажилгүйдлийн шалтгаан, үр дагаврууд
- ▲ Инфляци, манай орны инфляцийн онцлог, бодит байдал

Эдийн засгийн аль нэг тогтолдооноос өөр тогтолцоо руу шилжилт хийж буй улс орнууд нь шилжилтийн эдийн засагтай орнууд гэгддэг. Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу 1990-ээд оноос шилжиж эхэлсэн. Дараах хүснэгтэд Монголын эдийн засгийн гол макро үзүүлэлтүүд өгөгдсөн байна.


Хүснэгт 4.1: Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2003	2004	2005	2006
Суурин хүн ам оны эцэст, мян.хүн	2504	2533.1	2564.4	2594.8
Эдийн засгийн идэвхитэй хүн, мян.хүн	959.8	986.1	1001.2	1042.8
үүнээс: Ажиллагчид	926.5	950.5	968.8	1009.9
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, мян.хүн	33.3	35.6	32.9	32.9
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2000 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг	814.1	902.1	964.3	942.9
Үүнээс:				
- Уул уурхай, олборлох аж үйлдвэр	335.2	447	492.4	501.8
- Боловсруулах аж үйлдвэр	370.3	341.6	253.5	319.8

- Цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамж	108.6	113.5	118.4	121.4
ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг	1479.7	1945.6	2524.3	3172.4*
ДНБ, 2000 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг	1134.5	1256.8	1346.1	1459.0*
Хөрөнгө оруулалт, оны үнээр тэрбум төг	543.6	639.2	797.1	858.2*
Гадаад худалдаа, сая ам.доллар				
Экспорт	615.9	869.7	1064.9	1542.8
Импорт	801	1021.1	1184.3	1485.6
Гадаад худалдааны тэнцэл, сая ам.доллар	-185.1	-151.4	-119.4	57.2
Улсын нэгдсэн төсөв, оны үнээр, тэрбум төг				
Орлого	553.9	713.1	837.9	1360.4
Зарлага	615.8	752.5	764.6	1237
Төсвийн нийт тэнцэл, тэрбум төгрөг	-61.9	-39.4	73.3	123.4
Нийт орлогын ДНБ-д эзлэх хувь	37.4	36.7	33.2	42.9*
Нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь	41.6	38.7	30.3	39.0*
Төсвийн нийт тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-4.2	-2	2.9	3.9*
Татварын ачаалал	28.4	30	27.4	35.6
Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт, хувиар	4.7	11	9.5	6
Валютын жилийн дундаж ханш, 1 ам.доллар= төг	1146.5	1185.2	1205.3	1179.6

Эх үүсвэр: Статистикийн эмхэтгэл, 2006 он

Макро эдийн засгийн үйл ажиллагаанд нөлөөлдөг нэг гол хэлбэрийн зах зээл нь хөдөлмөрийн зах зээл байдаг. Бид микро эдийн засгийн хичээл дээр хөдөлмөрийн хөдөлмөрийн зах зээлийн талаарх ойлголтыг авч үздэг ба энэ тохиолдолд хөдөлмөрийн тоо хэмжээг ажлын цагаар авч үздэг. Харин макро эдийн засагт нийт эдийн засаг дахь ажил эрхлэлтийн тоо нь хөдөлмөрийн тоо хэмжээг илэрхийлдэг. Хөдөлмөрийн эрэлт нь эдийн засаг дахь нийт ажлын байрны тоо, хөдөлмөрийн нийлүүлэлт нь ажил эрхлэх сонирхолтой нийт хүмүүс байна. Зах зээлийн тэнцвэр нь дараах хэлбэрээр илэрхийлэгдэнэ.



Зураг 4.2: Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр

Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр нь W^* цалингийн түвшинд бий болж байна. Харин цалингийн түвшин тэнцвэрт түвшнээс өндөр бол ажил эрхлэх сонирхолтой хүмүүсийн тоо ажлын байрны тооноос давах тул ажиллах сонирхолтой хүмүүст ажлын байр олдохгүй болно. Энэ үеийн хөдөлмөрийн эрэлтээс давсан нийлүүлэлтийг сайн дурын бус ажилгүйдэл гэж нэрлэнэ. Эсрэгээр цалингийн түвшин тэнцвэрт түвшнээс доогуур байвал ажиллах сонирхолтой хүмүүсийн тоо ажлын байрны тооноос давснаар сайн дурын ажилгүйдэл бий болно.



Хяналтын асуулт

- ▲ Инфляцийн өөрчлөлт, инфляцийн талаарх бодлогын тухай тайлбарла
- ▲ Ажилгүйдлийн хэлбэрүүд дээр жишээ авч тайлбарла.
- ▲ Шилжилтийн эдийн засагтай бусад орныг нэрлэж, онцлогийнх нь талаар ярилц.
- ▲ Манай улсын хувьд шилжилтийн эдийн засгийн үед ямар бодлого, үйл ажиллагаа явуулж ирсэн бэ? Үр дүнгийн талаар тайлбарла
- ▲ Монгол орны ажилгүйдэл, инфляцийн байдалд дүгнэлт өгч, ярилц.
- ▲ Хөдөлмөрийн нөөцийн онцлог манай улсын хувьд яаж илэрч байна?
- ▲ Ажилгүйдэл болон инфляци нь урвуу хамааралтай гэж тодорхойлогддог.
- ▲ Гэтэл 1970-аад оны эдийн засгийн хямралын үед улс орнуудын хувьд ажилгүйдэл, инфляци зэрэг өссөн. Үүнийг тайлбарлана уу?
- ▲ Манай улсад нефтийн үнэ бага хэмжээгээр өссөн ч бараг бүх төрлийн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ өсдөгийн шалтгааныг тайлбарлана уу?
- ▲ Эдийн засгийн онолын хувьд ийм байх үндэслэл бий юу?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 99-113 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 49-92 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 156-189, 213-216 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006
5. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 186-208 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006

6. Сангийн бодлого, татвар

- ▲ Эдийн засгийн тогтворжуулах бодлого, сангийн бодлого
- ▲ Төсвийн орлого, татвар,
- ▲ Татварын систем, татварын бодлого, Лафферын муруй
- ▲ Төсвийн зардал,
- ▲ Төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлэх. Мөнгөний эмисс
- ▲ Төсвийн алдагдлыг багасгах

Сангийн бодлого гэдэг нь инфляцийг хянах, ажилгүйдлийн хэмжээг өөрчлөхийн тулд татвар болон засгийн газрын зардлыг зохицуулах замаар эдийн засгийг тогтворжуулахыг хэлнэ. Энэ өөрчлөлт нь автоматаар бий болдоггүй ба бодлого боловсруулагчдын тусгайлсан бие даасан үйл ажиллагаа байдаг.

Сангийн хумих бодлого: Инфляцийг бууруулахын тулд дараах 3 төрлийн бодлогыг сонгож хэрэгжүүлэхийг сангийн хумих бодлого гэнэ.

- засгийн газрын зардлыг бууруулах
- татварыг өсгөх
- уг хоёр бодлогыг хослуулах

Сангийн тэлэх бодлого: Ажилгүйдлийг бууруулахын тулд эдийн засгийн өсөлтийг урамшуулан дээрхийн эсрэгээр бодлого хэрэгжүүлдэг ба эдгээр бодлогууд нь сангийн тэлэх бодлого болдог.

- засгийн газрын зардлыг өсгөх
- татварыг бууруулах
- уг хоёр бодлогыг хослуулах

Сангийн тэлэх бодлого нь ихэвчлэн төсвийн алдагдлын шалтгаан болдог ба төсвийн алдагдал үүссэн тохиолдолд санхүүжүүлэх шаардлага гардаг. Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд өөрийн мэдэлд хуримтуулан хуваарилж, зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын тэнцдийг Монгол Улсын төсөв гэнэ. Улсын төсөв нь орлогын болон зарлагын гэсэн 2 хэсгээс бүрддэг. Төсвийн алдагдал гэдэг нь төсвийн зардал нь төсвийн орлогоосоо давсан үед бий болдог. Харин сангийн хумих бодлого явуулахад төсвийн илүүдэл бий болдог. Иймд илүүдлийг бууруулах шаардлага гардаг.

Төсвийн алдагдлыг дараах аргуудаар санхүүжүүлдэг.

1. Дотоод гадаадын зээллэгээр: Хэрвээ засгийн газар мөнгөн хөрөнгийн зах зээлд зээлдэгчээр орж бизнесийн нэгж болон гадаадын засгийн газруудад бонд худалдан алдагдлаа санхүүжүүлж болно. Бондын эрэлтийн өсөлт нь тэнцвэрт хүүг өсгөх ба энэ нь хөрөнгө оруулалтыг бууруулснаар нийт эрэлтийг зүүн гар тийш нь шилжүүлж алдагдал санхүүжиж болно. Гэтэл энэ нь бодит орлогыг эргээд бууруулах тул үр дүнгүй арга байж болно. Мөн шууд зээллэг авах боломжтой ба энэ нь даамжирсан тохиолдолд өрийн дарамтыг бий болгоно.
2. Шинэ мөнгө гаргах замаар төсвийн алдагдлыг санхүүжүүлбэл шахан гаргах үзэгдлээс зайлсхийх боломжтой болно. Иймээс энэ нь онолын хувьд илүү үр дүнтэй арга байдаг. Гэвч энэ нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг хийсвэрээр нэмэгдүүлэх тул инфляцийг хөөрөгдөж болзошгүй.

Төсвийн алдагдлыг бууруулах арга зам: Хэрвээ эдийн засагт алдагдал байнга үүсдэг бол энэ нь өрийн дарамтыг бий болгох тул үүнээс зайлсхийхийн тулд алдагдлыг бууруулах арга хэмжээг авдаг.

1. Төсвийн зардлыг бууруулах: Төсвийн орлогоо хэвээр нь байлгаад төсвийн зардлыг бууруулсан тохиолдолд алдагдал буурдаг. Гэвч зарддаа бууруулахын тулд засгийн газар төсвийн байгууллагын ажилчдыг цомхотгох, албан хаагчдын хөдөлмөрийн хангамжийг бууруулах, эсвэл нийгмийн хамгааллын болон засгийн газрын шилжих төлбөрийг бууруулах, боловсрол эрүүл мэндийн салбарын санжүүжилтыг багасгах зэрэг арга хэмжээ авдаг нь нэг бол урт хугацааны эдийн засгийн үр өгөөжийг бууруулах эсвэл нийгмийн эсэргүүцлийг нэмэгдүүлэх зэрэг үр дагавартай байдаг.
2. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх: Төсвийн орлогыг нэмэгдүүлнэ гэдэг нь татварын орлогыг нэмэгдүүлнэ гэсэн үг. Татварын орлогыг татварыг хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар, татварын суурийг өргөтгөх замаар нэмэгдүүлж болдог. Татвар нь сангийн бодлогыг хэрэгжүүлэх гол хэрэгсэл болдог бөгөөд эдийн засагт дараах хэлбэрийн татварын тогтолцоо үйлчилдэг.

Өсөн нэмэгдэх буюу прогрессив: Орлого өсөхийн хэрээр татварын хувь хэмжээ өсөхийг хэлнэ. Жишээ нь, 1 сая төгрөгөөс дотогш орлоготой хүн 10%-ийн татвар төлдөг бол түүнээс дээш орлоготой хүн 15%-ийн татвар төлнө гэх мэт.



Буурах буюу ререссив: Орлогын хэмжээ өсөх тусам татварын хувь хэмжээ буурахыг хэлнэ. Жишээ нь, 1 сая төгрөгөөс дотогш орлоготой хүн 20%-ийн татвар төлдөг бол түүнээс дээш орлоготой хүн 10%-ийн татвар төлнө гэх мэт

Пропорциональ буюу тэгшитгэсэн: Орлогын түвшин бүрт ижил хувийн татвар оноохыг хэлнэ.

Төсвийн алдагдлыг бууруулахын тулд татварын түвшинг нэмэгдүүлдэг. Гэвч энэ нь мөн л хязгаартай байдаг. Учир нь татварын түвшний өсөлт нь эдийн засгийн үйл ажиллагаанд дарамт болсноор татвараас орох орлого буурдаг. Энэ хамаарлыг Лафферийн муруй харуулдаг.



Хяналтын асуулт

- ▲ Сангийн бодлогын эцсийн зорилго нь юу вэ?
- ▲ Татварын суурийг өргөтгөх, татварын түвшинг нэмэх 2 аргыг харьцуулан ярилцана уу?
- ▲ Сонгодог эдийн засагчид яагаад эдийн засаг дахь төрийн оролцоог үгүйсгэдэг вэ?
- ▲ Засгийн газар, төсвийнхөө алдагдлыг мөнгөний эмиссийн аргаар санхүүжүүлэх нь үр муутай гэж яагаад үздэг вэ?
- ▲ Манай орны эдийн засгийн өсөлтөд үзүүлэх, татварын эерэг ба сөрөг нөлөөллүүд юу байх вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 124-133 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 201-228 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 171-18 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006
5. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 215-227 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006

7. Татвар, түүний нийгэм эдийн засаг дахь нөлөөлөл

- ▲ Татварын тогтолцоонуудын үр ашигтай байдал,
- ▲ Татварын, эдийн засгийн болон нийгмийн үр дагаврууд
- ▲ Үйлдвэрлэгч, хэрэглэгч, нийгэмд үзүүлэх татварын нөлөөлөл
- ▲ Монгол улс дахь татварын шинэчлэл

Татвар бол төрийн эдийн засгийн үүргээс уламжлан гарсан хураамж юм. Төр эдийн засгийн үүргээ гүйцэтгэхийн тулд орлоготой байх ёстой бөгөөд энэ орлогынхоо ихэнхийг татвараар бүрдүүлдэг. Татварыг ногдуулж буй хэлбэрээс нь хамруулж прогрессийн буюу өсөн нэмэгдэх хэлбэрийн, порпорционал буюу хэм тэнцүүлэх хэлбэрийн, регрессийн буюу буурах хэлбэрийн татвар гэж ангилдаг.

Хэрвээ орлогын хэмжээ нь өсөж байхад татварын хувь нь дагаад өсөж байвал өсөн нэмэгдэх хэлбэрийн татвар, харин орлого нь өсөж байхад татварын хувь нь буурч байвал буурах хэлбэрийн татвар болно. Харин орлогын хэмжээнээс хамаарахгүй

тогтоосон татвар нь хэм тэнцүү хэлбэртэй. Үүнээс гадна шууд ба шууд бус татвар гэж ангилдаг. Хүмүүсийн орлогод ногдуулж буй татвар нь шууд хэлбэрийнх байх бөгөөд бараа үйлчилгээгээр дамжуулан авч буй татвар нь шууд бус хэлбэрийнх юм.

Татварын тогтолцоог үнэлэхдээ тэгш байдал, үр ашиг гэсэн 2 шалгуур хэрэглэдэг. Тэгш байдлын хувьд хэд хэдэн тайлбар бий. 2 өрхийн жилийн орлого адилхан 3 сая төгрөг байлаа гэж үзье. Тэгвэл татварын хууль ёсоор ижил хэмжээний татвар төлнө. Үүнийг хэвтээ тэгш байдал гэж нэрлэдэг. Гэтэл 1 өрх нь 6 хүнтэй, нөгөө нь 3 хүнтэй бол ижил татвар төлөх нь шударга байдал мөн үү? Ингэхээр харилцан адилгүй нөхцөлд байгаа хүмүүс харилцан адилгүй татвар төлөх нээ. Үүнийг босоо тэгш байдал гэж нэрийддэг.

Татварын үр ашгийн асуудал чухал юм. Татвар ногдуулснаар ямар нөлөөлөл гарах вэ? Үүнийг дараах зургаас тодорхой харж болно.


Зураг 4.3 татварын нөлөө болон хүснэгтээс харахад татвар ногдуулснаар хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн хожоо багасаж, нийгмийн нийт хожоо буурдаг байна. Татвар ногдуулснаар татварын ачаалал хэрэглэгч ба үйлдвэрлэгчдэд адилхан хуваагдаж очдог. Төрийн зүгээс татвар ногдуулахдаа хэрэглэгчдэд, эсвэл, үйлдвэрлэгчдэд гэсэн хаягтайгаар хуульчилдаг ч хоёуланд нь адилхан хэмжээгээр дарамт болдог гэдгийг эндээс харж болно.

Монгол улс татварын шинэчлэлд анхаарч 2006 онд татварын багц хуулиудыг шинэчлэн гаргасан юм. Татварын шинэчлэлийн гол агуулга нь татварын хувийг бууруулах замаар татварын ачааллыг багасгах, татварын суурийг өргөтгөж, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн. Хуулиудыг ашиглан нэмэлт жишээ тооцоонуудыг хийе. Оюутнууд орлогын татварынхаа хэмжээг тооцох бодит жишээ олон бий.

Татвар төлөх нь үнэн гэсэн үгийг бас эргэцүүлж бодох ёстой. Татварын мөн чанар, агуулгыг энэ хичээлээр тодорхой болгоно.

Зураг 4.3. Татварын нөлөө

Хүснэгт 4.2





Хяналтын асуулт

- ▲ Татварын орлогыг хэрхэн тооцдог вэ?
- ▲ Татварыг зорилгуудыг нэрлэ.
- ▲ Пропорциональ татварын үед яагаад үр ашиг хамгийн багаар алдагдах боломжтой вэ?
- ▲ Манай орны хувьд прогрессив татвар нь хамгийн сайн тогтолцоо мөн үү? Яагаад?
- ▲ Татварын ачаалал нь хэрэглэгч, нийлүүлэгчийн хэнд нь илүү оногдвол эдийн засгийн тогтвортой байдалд бага сөрөг нөлөөллийг үүсгэх вэ?
- ▲ Өсөн нэмэгдэх татварын тогтолцоотой үед өндөр зардалтай байдаг нь ямар хүчин зүйлстэй холбоотой байж болох вэ?
- ▲ Татвараас орох орлогын дийлэнх хувийг хэн хүртэх ёстой вэ? Бодит байдалд хэрхэн нийцдэг вэ?



Ном зүй

1. Б.Сувд Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 126-129 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Микроэкономикс, УБ., 2005, 65-83 тал
3. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 204-212 тал
4. Н.Грегори Мэнкью, Экономиксын үндсүүд, микроэкономикс, тэргүүн дэвтэр, Адмон, 2007, 163-176 тал
5. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 178-181 тал
6. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
7. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 217-219 тал
8. Микроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2005
9. Монгол улсын хууль, Татварын ерөнхий хууль, УБ., 1992,
10. Монгол улсын хууль, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай, УБ., 2002,
11. Монгол улсын хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай, УБ., 2006
12. Монгол улсын хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, УБ., 2006
13. Монгол улсын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, УБ., 2006
14. Монгол улсын хууль, Монгол улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль, УБ., 1992
15. Монгол улсын хууль, Онцгой албан татварын тухай, УБ., 1992
16. Монгол улсын хууль, Бууны албан татварын тухай, УБ., 1993
17. Монгол улсын хууль, Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль, 1995

8. Эдийн засаг дахь орлогын дахин хуваарилалт, ядуурал, ядуурлыг бууруулах аргууд

- ▲ Нийгмийн сайн сайхан байдал
- ▲ Орлогын дахин хуваарилалт
- ▲ Орлого хуваарилалтын тэгш байдал, Жини коэффициент, Лоренцийн муруй
- ▲ Ядуурал, түүний хэлбэрүүд
- ▲ Орлогын ядуурал
- ▲ Чадавхийн ядуурал
- ▲ Ядуурлын түвшин
- ▲ Ядуурлын гүнзгийрэлт
- ▲ Ядуурах эмзэг байдал
- ▲ Ядууралтай тэмцэх аргууд

1970-аад оны гол асуудал ядуурал ба тэгш байдлын асуудал болж эхэлсэн. Хэдийгээр 1980-1990-ээд онуудад шинэ сонгодог эдийн засгийн онол ба өсөлтийн шинэ онолын хүрээнд өсөлтийг дахин чухалчлан үзэх болсон гэлээ ч дээрх асуудал анхаарлын төвд байсаар байгаа.

Эдийн засагчид ихэнхдээ орлого хуваарилалтын үндсэн 2 хэмжүүрийг ялган авч үздэг: орлогын хувийн буюу хэмжээст хуваарилалт ба орлогын функциональ буюу хуваарилагч хүчин зүйлийн хувийн хуваарилалт гэнэ.

Хэмжээст хуваарилалт:

Энэ нь хувь хүмүүс болон өрхийн олж авч буй нийт орлоготой холбоотой. Орлого олж авч буй замыг нь хайхардаггүй. Ямар ч эх үүсвэрээс хамаагүй хүн бүр хэр хэмжээний орлого олж байгааг нь онцолдог. Түүнчлэн орлогын байршлын /хотын хөдөөний/ болон мэргэжлийн эх үүсвэр /хаа, аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээ/-ийг авч үзэхгүй.

Орлогын тэгш бус байдлын хэмжүүрийг доод /бага орлоготой/ 40%-н эзэмжиж буй орлогын хувийг дээд /их орлоготой/ 20%-ийн эзэмшиж буй орлогын хувьд харьцуулж тооцодог.

Лоренцийн муруй: Жинийн коэффициент ба тэгш буй байдлын ерөнхий /нийтлэг/ хэмжүүрийг италийн статистикч Жини 1912 онд тооцож гаргасан. Өндөр орлогын тэгш бус байдалтай орнуудад Жини коэффициент 0,5-0,7 байдаг бол нөгөө орнуудад нь 0,20-0,35 байна.

Функциональ хуваарилалт:

Энэ хуваариалтаар үйлдвэрлэлийн хүчин зүйл /газар, хөдөлмөр ба капитал/ тус бүрийн авч байгаа үндэсний орлогын хувийг тайлбарлахыг хичээдэг. Хөдөлмөрийн бүхэлдээ олж авч байгаа орлогын хувийг рент, зээлийн хүү ба ашиг хэлбэрээр хуваарилагдаж буй нийт орлогыг хувьтай харьцуулдаг юм. Хэдийгээр хувь хүмүүс энэ бүх эх үүсвэрээс орлого олж авч байж болох ч үүнийг функциональ хандлагаар хайхарч үздэггүй.

Туйлын ядуурал: цар хүрээ ба хэмжээ

Туйлын ядуурлын хэмжээ гэдэг нь суурь хэрэгцээгээ хангах хүрэлцэх нөөцгүй байгаа хүмүүсийн тоо гэж үздэг. Тэд бодит орлогыг тодорхойлсон хамгийн бага хэмжээнээс доогуур амьдарч байгаа хүмүүсийн тоогоор тоологддог. 1985 оны үнээр хэмжихэд 275\$-оос бага орлогтой өрхийг нэн ядуу, 370 \$-оос бага бол ядуу гэж байсан /1990 онд/.



Ядуурлын зөрүү гэсэн ойлголт бий. Энэ нь ядуурлын шугамаас доош амьдарч байгаа хүн бүрийг уг шугмын дээр гаргахад шаардагдах орлогын нийт хэмжээг хэлж байгаа юм. Хөдөөгийн хүмүүс, эмэгтэйчүүд, хүүхдүүд их ядуу байна. Мөн үндэсний цөөнх хүмүүс ч ихээхэн ядуу байгаа.

Ядуурал амьжиргааны түвшин: 1995-аас 1998 оны хооронд манай улсын төвлөрсөн газрын ядуурал бага зэрэг нэмэгдсэн /Улаанбаатарт харин бага зэрэг буурсан/. Аймгын төвүүдийг оруулаад манай улсын төвлөрсөн газрын хүн амын 39.4 хувь нь ядуу байгаа бол хөдөөд энэ үзүүлэлт 32.6 байна. Орлогын тэгш бус байдлыг хэмждэг Жийн коэффициент 1995 онд 0.31, 1998 онд 0.35, 2002 онд 0.44 болж өсчээ. Энэ нь манай улсын орлогын хуваарилалт улам бүр тэгш бус болсоор байна гэсэн үг.



Хяналтын асуулт

- ▲ Орлогын дахин хуваарилалтыг яагаад хийх шаардлагатай байдаг вэ?
- ▲ Ядуурлын хэлбэрүүд, тэдгээрийн ялгаа
- ▲ Аль хэлбэрийн ядуурал нь хамгийн их ужгирсан шинж чанартай байж болох вэ? Яагаад?
- ▲ Манай орны эдийн засгийн өсөлт болон ядуурлын хоорондын хамаарлыг тодорхойлно уу?
- ▲ Манай орны хувьд 1970-аад оны Лоренцийн муруй нь одоогийнхоос ямар ялгаатай байсан бэ?
- ▲ Орлогын дахин хуваарилалт хийгээгүй үеийн нийгмийн үр ашиг нь дахин хуваарилалттай үеийнхээс яагаад доогуур байж болох вэ?
- ▲ Манай орны хувьд ядуурлыг бууруулах аргуудын аль нь хамгийн үр дүнтэй байх боломжтой вэ? Яагаад?



Ном зүй

1. С.Даваасүрэн, Хөгжлийн Экономикс, УБ 2000 64-82 тал
2. Ядуурлын судалгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн баг, Хүний хөгжил, УБ, 2006, 116-130 тал
3. Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл УБ, 2000, 2003, 2006

9. Мөнгө, Мөнгөний бодлого

- ▲ Мөнгө, мөнгөний үүрэг,
- ▲ Мөнгөний эрэлт: арилжааны ба ашиг хонжооны
- ▲ Мөнгөний бодлого, мөнгөний бодлогын төрлүүд
- ▲ Мөнгөний агрегатууд, мөнгөний нийлүүлэлт
- ▲ Мөнгөний эрэлт ба нийлүүлэлтийн тэнцвэр
- ▲ Зээлийн хүү, тэнцвэрт зээлийн хүү
- ▲ Мөнгөний бодлогын арга хэрэгслүүд, шууд ба шууд бус арга хэрэгсэл

Мөнгө бол эдийн засгийн үйл ажиллагааг хэмжих чухал нэгж юм. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, хийсэн зүйлээ хэмжихдээ мөнгөн үнэлгээг ашигладаг. Экономикст мөнгийг тодорхойлохдоо дараах 3 үүргийг нэгэн зэрэг гүйцэтгэж чадах бүх зүйлийг хамруулдаг. Үүнд:

- өртгийн хэмжүүр
- гүйлгээний хэрэгсэл
- хуримтлалын хэрэгсэл

Эрт үеэс одоог хүртэл мөнгөний үүргийг янз бүрийн зүйл гүйцэтгэж иржээ. Нэгтгээд үзвэл эд бараа, мал амьтад, дараа нь цаасан ба зоосон бэлэн мөнгө, орчин үед бэлэн бус мөнгө ашиглагддаг байсан, байна.

Мөнгөний эрэлт гэдэг бол маш энгийнээр тодорхойлбол, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч талуудад хэрэгцээтэй байгаа нийт мөнгөний дүн гэж болно. Арилжаа, солилцооны эрэлт, ашиг хонжооны эрэлт гэж хувааж үздэг. Хэрэглэгч, үйлдвэрлэгч зэрэг оролцогчдын хэрэгцээт зүйлсээ олж авахад шаардлагатай мөнгөний дүн нь арилжааны эрэлт болно. Харин талууд хуримтлал хийх, хадгалах сонирголоос ашиг хонжооны эрэлт үүсдэг. Энэ хоёр төрлийн эрэлтийн нийлбэрээр мөнгөний нийт эрэлт тодорхойлогддог.

Мөнгөний нийлүүлэлт нь тухайн улсын хэмжээнд байгаа бүх мөнгөний дүн юм. М0, М1, М2, М3, М4 зэрэг мөнгөний агрегатуудыг тооцож байдаг. Манай улсын хувьд эхний 3-ийг л тооцдог. М0 гэдэг нь гар дээр байгаа бэлэн мөнгө юм. Өөрөөр хэлбэл, банкнаас гадуур байгаа мөнгө гэсэн үг. М1 бол бэлэн мөнгөн дээр харилцах дансанд буй мөнгө, хугацаагүй хадгаламжийг нэмсэнтэй тэнцүү. М2-ийг М1 дээр хугацаатай хадгаламж, бүх төрлийн валютын хадгаламжуудыг нэмж тооцно.

Аль ч улсын хувьд гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний тоог тодорхойлох нь чухал байдаг. Дараах томъёогоор тооцдог.

$$M \cdot V = P \cdot Y$$

энд **M** - нийт мөнгөний хэмжээ

V - мөнгөний эргэлтийн хурд

P - үнийн түвшин

Y - бодит дотоодын нийт бүтээгдэхүүн

Үүнийг мөнгөний тооны онолын тэгшитгэл гэдэг. Мөнгөний нийлүүлэлт нь харьцангуй тогтвортой байдаг тул богино хугацаанд нийлүүлэлтийн график нь босоо тэнхлэгтэй бараг паралель байна.

Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр мөнгөний зах зээлийн тэнцвэр тогтдог. Энэ тэнцвэрээр зах зээлийн тэнцвэрт хүү тогтох ба эдийн засаг дахь нийт тэнцвэрт мөнгөний хэмжээ илэрхийлэгдэнэ.



Засгийн газраас энэ тэнцвэрийг хангахуйц мөнгөний нийлүүлэлт хийх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, инфляцийг тогтдоржуулах, бүрэн ажил эрхлэлтийг хангах зорилгоор мөнгөний бодлого хэрэгжүүлдэг. Хатуу ба зөөлөн мөнгөний бодлого гэж ангилдаг. Мөнгөний нийлүүлэлтийг хумих бодлого нь хатуу, харин эсрэгээр, мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх бол зөөлөн бодлого гэж үздэг.

Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх шууд ба шууд бус гэсэн 2 арга хэрэгслийг ашигладаг. Шууд арга хэрэгсэлд: банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх, банканд олгох зээлийн хэмжээг тогтоох зэрэг орно. Харин шууд бус арга хэрэгсэл бол: арилжааны банкны заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тогтоох, зээлийн хүүг тогтоох, нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах зэрэг болно.



Хяналтын асуулт

- ▲ Мөнгөний бодлогын шууд, шууд бус арга хэрэгслүүдийг нэрлэнэ үү?
- ▲ Мөнгөний бодлогын эцсийн болон завсрын зорилгууд нь юу вэ?
- ▲ Нэрлэсэн болон бодит хүүгийн ялгаа нь юу вэ? Аль нь эдийн засгийн үйл хөдлөлд илүү нөлөөлдөг вэ?
- ▲ Стагфляцийн үед зөөлөн мөнгөний бодлого, хатуу мөнгөний бодлого 2-ын алийг нь хэрэгжүүлэх хэрэгтэй вэ? Яагаад?
- ▲ Монгол улсын өнөөгийн эдийн засгийн нөхцөлд мөнгөний бодлогын аль арга хэрэгсэл нь илүү үр дүнтэй байх боломжтой вэ?
- ▲ Хэрвээ ЗГ бондын үнээ бууруулсан бол мөнгөний ямар бодлогыг хэрэгжүүлсэн бэ?
- ▲ Макро эдийн засгийн тогтворгүй байдал үүснэ гэсэн хүлээлтээс арилжааны банкуудын Төв банкн дахь нөөц өссөн бол зээлийн хүү яаж өөрчлөгдөх вэ?
- ▲ Монголын эдийн засаг дахь хүүгийн түвшин өндөр байгаа нь юутай холбоотой вэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 113-124 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 229-250 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 118-146 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 245-257 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006

10. Мөнгө, санхүүгийн зах зээл

- ▲ Мөнгөний үүсэл, хөгжил
- ▲ Банк, банкны тогтолцоо
- ▲ Санхүүгийн хөрөнгүүд, үнэт цаас, түүний хэлбэрүүд
- ▲ Санхүүгийн хөрөнгийн зах зээл, түүний төрлүүд, тэдгээрийн ялгаа онцлог

Мөнгө маш эртнээс үүсэлтэй. Мөнгөний үүслийн талаар оюутнууд өөрсдийн олсон материал дээр үндэслэн тайлбар хийнэ.

Дэлхийн мөнгөний хөгжлийн түүхээс үзэхэд мөнгөний үүргийг хэсэг бүлэг бараа, түүхий эд гүйцэтгэж байснаа урт хугацааны явцад янз бүрийн хэрэгсэлд тасралтгүйгээр шилжих сонголт явагдсаар эцэст нь аливаа нэг тодорхой бараа биш, тэдгээрийг түгээмэл төлөөлж чадах, хийсвэр нэрлэсэн үнэлгээ бүхий мөнгөн тэмдэгт бий болжээ. Мөнгөний үүсэл, хөгжил нь арилжааны хэлбэрийн өөрчлөлт хөгжилтэй салшгүй холбоотой

Дараах 5 хэлбэрээр хөгжиж иржээ:

- Зохион байгуулалттай бус, энгийн бараа, таваарын солилцоо.
- Нутаг дэвсгэр, өрх, оршин суугчдын дунд буюу хязгаарлагдмал орон зайд зохион байгуулалттай явагдах арилжаа.
- Мөнгө орлосон онцгой таваар оролцсон арилжаа.
- Мөнгөний үүрэг гүйцэтгэгч стандартын бараа оролцсон арилжаа.
- Хууль ёсны мөнгөн тэмдэгтээр хийгдэх арилжаа.

Арилжааны төрөл улам боловсронгуй болж цэвэр мөнгөний стандартад шилжих тал руу дөхөх тусам арилжааны зардал хямдарч, хугацаа богиносж байдаг зүй тогтолтой.

Мөнгөн гүйлгээг зохицуулахад гол үүрэг гүйцэтгэдэг байгууллага бол банк юм. Банкны хамгийн энгийн үүрэг нь санхүүгийн зуучлал байдаг. Энэ үүргийн дагуу дараах 2 үйл ажиллагааг явуулдаг:

- Бэлэн мөнгө хадгалуулах сонирхолтой хүмүүсийн мөнгийг авч хадгаламжийн данс хөтлөх
- Хувь хүмүүс болон пүүсүүдэд мөнгө зээлдүүлэх

Дэлхийн ихэнхи улс орнууд банкны 2 шатат тогтолцоотой байдаг. Төв банк, арилжааны банкаас бүрдэнэ. Монгол улс 1991 оноос 2 шатат тогтолцоонд шилжсэн. Төв банк бол улсын мөнгөний бодлогыг явуулдаг ба Засгийн Газраас хараат бус байна. Харин арилжааны банкууд нь зээлийн хүү, хадгаламжийн хүү хоёрын зөрүүгээр ашиг олдог бизнесийн байгууллага байдаг. Арилжааны банкны тайлан тэнцлийг дараах хэлбэрээр гаргадаг.

Хүснэгт 4.1. Арилжааны банкны баланс

Хөрөнгө (Assets)	Эх үүсвэр (Liabilities and net worth)
Нөөц	Иргэдийн хадгаламж
Зээл	Хугацаатай хадгаламж
Үнэт цаас	Бусад хадгаламж
Өмч хөрөнгө	Өөрийн хөрөнгө
Бусад хөрөнгө	



Арилжааны банкуудын зах зээлийн эзлэх хувийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 4.2. Арилжааны банкны зах зээлд эзлэх хувь (2005 оны байдлаар)

	Банк	Нийт хөрөнгө	Хадгаламж	Зээл
1	ХХБ	26.60%	26.90%	22.10%
2	Голомт банк	16.20%	16.90%	14.90%
3	Хадгаламж банк	10.30%	12.10%	
4	ХААН банк	10.10%	11.60%	10.60%
5	Анод банк	7.71%	7.39%	11.50%
6	Бүгд	29.90%	25.11	40.90%

Эх үүсвэр: Монгол банкны тайлан, 2005

Санхүүгийн зах зээлд мөнгөнөөс гадна хувьцаа, бонд зэрэг үнэт цаасны арилжаа хамрагддаг төдийгүй даатгал ч гэсэн санхүүгийн зах зээлийн нэгэн хэсэг болдог юм.



Хяналтын асуулт

- ▲ Мөнгөний үүргүүдийн талаар ярилц.
- ▲ Банкны нэг шатлалт болон хоёр шатлалт тогтолцооны ялгаа, онцлогийг харьцуул.
- ▲ Манай оронд мөнгө үүсэж, хөгжсөн түүхийн талаар ярилцана уу?
- ▲ Засгийн газрын бонд, компанийн хувьцаа гэсэн үнэт цааснууд нь мөнгө мөн үү? Яагаад?
- ▲ Хөнгөлөлтийн картууд мөнгөнд орох уу?
- ▲ Монгол улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийн талаар ярилцана уу?
- ▲ Банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоодын хариуцлага, эрх үүргийн арилжааны банкныхаас ялгагдах байдал



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 113-124 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 229-250 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 118-131 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 228-247 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006
7. Монгол банкны жил бүрийн тайлан

V бүлэг: ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА

Бүлгийн зорилго: Улс орнуудын хооронд явагддаг гадаад худалдаа, эдийн засгийн бусад үйл ажиллагааны экономиксийн үндсэн мэдлэгийг эзэмшин, гадаад худалдаа, эдийн засгийн гадаад харилцааны ашиг, алдагдлыг тодорхойлох чадвар эзэмшин, улс орныхоо эдийн засгийн өсөлтөд үзүүлдэг нөлөө, үүнтэй холбоотой үүсэх асуудлуудыг ашигтайгаар хэрхэн, яаж шийдвэрлэх ёстой талаар сонирхох эрмэлзлэлтэй болоход чиглэнэ.

1. Гадаад худалдаа, гадаад худалдааны асуудлууд

- ▲ Гадаад худалдаа хийх шаардлага
- ▲ Гадаад худалдааны нөхцөлүүд
- ▲ Гадаад худалдааны талаарх онолын үзэл баримтлалууд
- ▲ Гадаад худалдааны үр ашиг
- ▲ Гадаад худалдааны бодлогууд

Улс орнууд дараах шаардлагаар гадаад худалдаанд оролцдог.

- Нөөцийн хуваарилалт үр ашигтай хийгдэнэ.
- Технологи болон нөөцийн боломж нэмэгдэнэ
- Бүтээгдэхүүний ялгаварлал
- Хямд өртгөөр бүтээгдэхүүн худалдан авснаар хэрэглээ нэмэгддэг
- Экспорт хийснээр худалдааны үр ашиг өснө

Гадаад худалдаанд тавигддаг өөр нэг гол асуудал бол худалдаа ямар үед харилцан ашигтай байх боломжтой вэ гэдгийг тодорхойлох юм. Үүнийг олон улсын худалдааны онолуудад авч үздэг. Энд бид туйлын давуу талын онол, харьцангуй давуу талын онолын талаар тайлбар хийх болно.

Тойлын давуу талын онол. Жишээ нь: Англи Португалийн цэмбэ ба дарсны үйлдвэрлэл. Хүснэгтэд хоёр улсын ижил зардлаар үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ өгөгдсөн.

Хүснэгт 5.1. Туйлын давуу талын онол

	Цэмбэ	Дарс
Англи	30	15
Португали	20	30

Англи улс Португали улсын 20 нэгж цэмбэ үйлдвэрлэх зардлаар 30 нэгж цэмбэ үйлдвэрлэж байгаа тул цэмбэний үйлдвэрлэлээр туйлын давуу талтай байна. Харин дарсны үйлдвэрлэлээр эсрэгээрээ Португали улс туйлын давуу талтай байна. Иймд Англи цэмбээ, Португали дарсаа дагнаж үйлдвэрлэх ба өөрсдийн хэрэгцээнээс илүү гарсныг харилцан арилгахдаа тус бүрийн дотоодын зах зээлийн үнээс бага үнээр худалдан авч, илүү үнээр худалдах боломжтой болох тул хоёулаа гадаад худалдаанаас эдийн засгийн ашиг олно гэж үздэг онолыг туйлын давуу талын онол гэнэ. Хоёр улсын харилцан туйлын давуу талгүй байж болно. Энэ тохиолдол нь худалдааны харьцангуй давуу талын онолоор тайлбарлагдана. **Жишээ нь:**



Хүснэгт 5.2. Харьцангуй давуу талын онол

	Цэмбэ	Дарс
Англи	15	15
Португали	20	30

Дээрх хүснэгтээс харахад Португали улс хоёр бүтээгдэхүүнээр зэрэг туйлын давуу талтай байгаа тул харилуан худалдаа хийх боломжгүй юм. Харин аль бүтээгдэхүүний үнийг нөгөөгийн зарддаар илэрхийлбэл Англи улс 1 нэгж цэмбэ үйлдвэрлэх зардлаар 1 нэгж дарс үйлдвэрлэж байгаа бол Португали 2/3 нэгж цэмбэ үйлдвэрлэх зардлаар 1 нэгж дарсыг, Англи улс 1 нэгж дарс үйлдвэрлэх зардлаар 1 нэгж цэмбэ үйлдвэрлэж байгаа бол Португали 1.5 нэгж дарс үйлдвэрлэх зардлаар 1 нэгж цэмбэ үйлдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл харьцуулсан зарддаар нь илэрхийлбэл Англи улсад цэмбэ хямд, Португалид дарс хямд байна. Энэ давуу талыг харьцангуй давуу тал гэдэг ба ул сууд харилцан харьцангуй давуу талтай үед дагнасан үйлдвэрлэл явуулж харилцан худалдаа хийж ашиг олдог.

Олон улсын худалдааны өөр нэг асуудал бол худалдааны бодлого байдаг. Улс орнууд эдийн засгийн бие даасан байдлаа тогтвортой байлгах, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хамгаалах гэх мэт зорилгоор худалдааг хязгаарладаг. Олон улсын худалдааны хязгаарлалт нь дараах төрлүүдтэй байдаг.

1. Тарифийн: Ихэвчлэн импортын татварууд ордог. Импортын бүтээгдэхүүн нь үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөгч тул өрсөлдөөнөөс хамгаалахын тулд түүнийг хязгаарлан татвар оноохыг хэлнэ. Зарим төрлийн түүхий эд болон ховор хомс нөөцүүдийн экспортыг мөн татвар оноон хязгаарлаж болдог.
2. Тарифийн бус: Татварын бус хязгаарлалтууд орно. - Импортын квот: Тоо хэмжээний хязгаарлалт



Хяналтын асуулт

- ▲ Улс орнууд яагаад гадаад худалдаа хийдэг вэ?
- ▲ Чөлөөт худалдааны бодлогын сул ба давуу талууд юу вэ?
- ▲ Манай орны хувьд гадаад худалдааны алдагдлыг бууруулахын тулд валютын ханшийг яаж өөрчлөх шаардлагатай вэ?
- ▲ Импортын квот тогтоох, татвар оноох 2 аргын аль нь илүү алдагдалтай байдаг вэ?
- ▲ Манай улсын хувьд туйлын болон харьцангуй давуу тал нь юу байж болох вэ?
- ▲ Түүхий эд экспортолж, бэлэн бүтээгдэхүүн импортолдог улс гадаад худалдааны баланс нь харьцангуй хараат шинж чанартай болдог. Үүний гол шалтгаан нь юу байж болох вэ?
- ▲ Туйлын болон харьцангуй давуу талын онолоор гадаад худалдаа хийсэн орнууд нь бүгд ашигтай байх боломжтой байдаг. Гэтэл бодит байдалд орнуудын хувьд энэ нөхцөл зөрчигддөгийн гол шалтгаан нь юу вэ?



Дасгал

Бодлого:

1. Хятад, Монгол улсын 2 бараа үйлдвэрлэх нэгж бүтээгдэхүүний зардлын хэмжээ өгөгджээ. Аль улс нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр харьцангуй болон туйлын давуу талтай вэ? Хоёр барааны дэлхийн үнүүдийг ол.

	Хятад	Монгол
Мах	5000	2500
Ногоо	1250	1000

2. Хятад, Монгол улсын 2 барааны үйлдвэрлэлийн хэмжээ өгөгджээ. Аль улс нь бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр харьцангуй болон туйлын давуу талтай вэ? Хоёр барааны дэлхийн үнүүдийг ол.

	Хятад	Монгол
Мах	5000	2500
Ногоо	1250	1000



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 113-144 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 251-264 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 96-102 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 257-268 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006

2. Валютын ханш, валютын ханшны бодлого

- ▲ Валютын ханшны системүүд
- ▲ Валютын ханшны бодлого
- ▲ Валютын ханшны өөрчлөлт улс орны эдийн засагт нөлөөлөх нь

Тухайн улс орны мөнгөн тэмдэгтийн өөр улсын мөнгөн тэмдэгттэй харьцах үнийг валютын ханш гэнэ. Валютын ханш нь дараах хоёр хэлбэртэй байна.

- Нэрлэсэн
- Бодит

Нэрлэсэн ханш:

Тухайн улсын мөнгөн тэмдэгт нь өөр улсын хэдэн нэгж валюттай тэнцэж байгааг харуулсан үзүүлэлт.

$$1\$ = 1165\text{Т}, \quad 1\$ = 10.3\text{Т}$$

Бодит ханш:

Хоёр улсын бүтээгдэхүүн худалдан авах үнүүдийн харьцаагаар илэрхийлэгддэг үзүүлэлт.



$$EER = e \cdot \frac{P_D}{P_F}$$

EER - валютын бодит ханш, e -валютын нэрлэсэн ханш
 P_D - тухайн улсын дотоодын үнэ
 P_F - шилжилт бараа үйлчилгээний гадаадын үнэ

Улс орнуудын эдийн асагт дараах хоёр валютын ханшны тогтолцоо үйлчилдэг.

1. Тогтмол ханшны тогтолцоо. Тухайн улс мөнгөн тэмдэгтийнхээ бусад орнуудынхтай харьцах ханшаа тогтмол түвшинд барихын тулд валютын зах зээлд интервенци хийдэг. Интервенци гэдэг нь валютын ханшийг өөрчлөх зорилгоор гадаад валютыг худалдах болон худалдан авах үйл ажиллагааг хэлнэ.
2. Хөвөгч ханшны тогтолцоо. Валютын ханш нь зах зээлийн үйл ажиллагаагаар зохицуулагддаг системийг хэлнэ.
 - Цэвэр хөвөгч
 - Бохир хөвөгч



Хяналтын асуулт

- ▲ Тогтмол ханшны системийн давуу тал нь юу вэ?
- ▲ Валютын ханшны бодлогууд нь макро эдийн засгийн тогтворжилтод яаж нөлөөлдөг вэ?
- ▲ Эдийн засагчид яагаад тогтмол ханшны системээс хөвөгч ханшны системийг илүүд үзсэн бэ?
- ▲ Европийн улс орнууд нэгдсэн валюттай болсон нь эдийн засгийн хувьд ямар үр дүнг авчирсан бэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 138-139 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 251-264 тал
3. Р. Амаржаргал, Ж. Батхуяг, Д. Батжаргал, "Эдийн засгийн ухаан", 2000, 102-108 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. А. Бакей, Р. Оросоо, "Эдийн засгийн ухаан", 1998, УБ, 268-284 тал
6. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006

3. Монгол улсын гадаад худалдаа, гадаад худалдааны бодлого, стратеги

- ▲ Монгол улсын гадаа худалдааны өнөөгийн байдал, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны баланс
- ▲ Монгол улсын гадаад худалдааны бодлого

Тухайн улс орнуудын гадаад орнуудтай хийж буй арилжаа солилцооны бүх хэлцлийг тусгасан үзүүлэлтийг төлбөрийн баланс гэж нэрлэдэг. Валют оруулж ирж буй бүх хэлцлийг төлбөрийн тэнцлийн кредитэд, харин валют гадагшлуулж буй хэлцлийг төлбөрийн тэнцлийн дебет талд тусгадаг. Улс орны гадагшаа хийж байгаа экспорт нь гадаадын зах зээл дэх тухайн улс орны валютын эрэлтийг бий болгосноор валютын ханшийг чангаруулдаг. Энэ нь валют оруулж ирж буй хэлцэл

юм. Тухайн улсын хувьд экспорт буурах нь дотоодын мөнгөний нийлүүлэлтийг өсгөж ханшийг бууруулдаг. Энэ нь валютыг гадагшлуулж буй хэлцэл юм. Дээрх хоёр төрлийн гүйлгээний зөрүү нь гадаад худалдааны баланс болно. Экспортын хэмжээ нь импортоос их бол гадаад худалдааны баланс илүүдэлтэй гардаг бол эсрэг тохиолдолд алдагдалтай гардаг. Мөн төлбөрийн тэнцлийн урсгал тооцоолны үлдэгдлийг илэрхийлдэг. Төлбөрийн баланс нь урсгал болон капитал тооцоо гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Урсгал тооцоонд бүтээгдэхүүн үйлчилгээний хэлцлүүд тусгагддаг бол капитал тооцоонд хөрөнгийн хэлцлүүд тусгагддаг. Урсгал тооцооны үлдэгдэл болон капитал тооцооны үлдэгдлийн зөрүү нь төлбөрийн тэнцлийн үлдэгдэл болдог. Валют оруулж ирж буй хэлцэйн нийлбэр нь валют гадагшлуулж буй хэлцлээс бага бол төлбөрийн тэнцэл алдагдалтай гардаг.

Жишээ 3: Валютын ханш, 2005

Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш сүүлийн таван жилд (2000-2004) дунджаар 2.4 хувиар суларч байсан бол 2005 онд нэг хүрэхгүй хувиар суларсан. 2005 оны эхэнд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш чангарах байдал гарсан нь манай улсын гадаад худалдааны нөхцөл харьцангуй сайн, гадаадын шууд хөрөнгө оруулалт өсч байгаа, хувийн гуйвуулга өсч байгаа зэрэг хүчин зүйлээс шалтгаалж байлаа. Оны эцэст ам.долларын ханш 1221 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.0 орчим хувиар чангарсан байна. Дундаж ханш 1205 орчим байна.

Эх үүсвэр: *Үндэсний статистикийн газар, Монгол Банк, 2005.*



Хяналтын асуулт

- ▲ Импортоор орж ирдэг архи, тамхи, автомашин гэсэн бүтээгдэхүүнүүдэд яагаад бусад бүтээгдэхүүнээс илүү татвар оногддог вэ?
- ▲ Төлбөрийн тэнцлийн алдагдлыг нөхөхийн тулд валютын ханшийг яаж өөрчлөх вэ?
- ▲ Худалдааны чөлөөт бүсүүд бий болсноор эдийн засагт ямар үр ашиг болон сул талыг бий болгодог вэ?
- ▲ Манай орны гадаад худалдааны баланс 1990-ээс 2000 оны хооронд 1995 онд л илүүдэлтэй гарсан байдаг. Үүний гол шалтгаан нь юу байсан бэ?



Ном зүй

1. Б.Сувд, Б.Алтанцэцэг, Экономикс, УБ., 2000, 138-139 тал
2. Б.Баярдаваа, Д.Гансүлд, Макроэкономикс, УБ., 2006, 251-264 тал
3. С. Даваасүрэн, Хөгжлийн экономикс, УБ, 2002, 110-117 тал
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006
5. Макроэкономиксийн бодлого, дасгал, тест, УБ., 2006



VI бүлэг: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН АСУУДЛУУД

Бүлгийн зорилго: Эдийн засгийн өсөлт, хөгжилтэй холбоотой орчин үеийн эдийн засгийн асуудлуудын талаар мэдлэгтэй болох, эдгээр үзүүлэлтүүд нь манай улсын хувьд ямар түвшинтэй байдгийг тодорхойлох чадвар эзэмшин, дэлхийн эдийн засагт гарч буй шинэчлэлт, өөрчлөлт, Монгол улсын байр суурийг тодорхойлох эрмэлзлэл төлөвшинө.

1. Глобалчлал, байгаль экологийн асуудлууд, тогтвортой хөгжлийн асуудлууд

- ▲ Глобалчлал, түүнтэй холбоотой асуудлууд
- ▲ Глобалчлалын талаарх эдийн засагчдийн үзэл баримтлал
- ▲ Үндэстэн дамнасан корпорацийн тухай ойлголт
- ▲ Экологийн тэнцвэрт байдал

Улс орнуудын хөгжил дэвшил, эдийн засгийн хүрээ, бүтэц, хэрэгжиж буй бодлогууд нь бусад улс орнуудын эдийн засаг хөгжил дэвшлээс ихээхэн хамааралтай болсон өнөөгийн нийгэмд глобалчлалын тухай ойлголт чухал ач холбогдолтой болоод байна. Глобалчлал гэсэн ойлголтыг янз бүрээр тодорхойлдог ба энд дараах хоёр тодорхойлолтыг орууллаа.

Худалдаа, хөрөнгө оруулалт болон капиталын урсгалд тавигдах хязгаарлалтуудыг чөлөөлснөөр, мөн түүнчлэн технологийн хурдацтай өөрчлөлтийн нөлөөллөөр бий болох дэлхийн улс орнуудын эдийн засгийн нийлэмсэх үйл явц юм. (ОУХБ-Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 1999:1) Глобалчлал гэдэг нь эдийн засгийн төдийгүй, улс төрийн, технологийн мөн соёлын учир холбогдолтой ойлголт. Глобалчлал нь зөвхөн санхүүгийн зах зээл дээр бус өрх гэрийн үнэ цэнэ, эрэгтэй эмэгтэйн хоорондох тэгш эрхийн байдал зэрэг бидний амьдралын хамгийн энгийн, хувийн шинж чанартай талуудад ч нөлөөлсөөр байна. (Giddens 1999:1)

Глобалчлагдаж байгаагийн нэг гол хэлбэр, тэр дундаа эдийн засгийн хамгийн их хэмжээний нөөцийн шилжилтийг бий болгож байгаа үйл явц бол Үндэстэн дамнасан корпорациуд юм. Үндэстэн дамнасан корпораци гэдэг нь улс орны ялгаатай байдалд тохируулан олон улс орныг хамарсан бизнесийн үйл ажиллагаа явуулагч -байгууллагыг хэлж болох юм. Нөгөө талаас хоёр буюу түүнээс дээш орнуудад аж үйлдвэр, газар тариалан, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад хяналтын хөрөнгийг эзэмшдэг аж ахуй нэгжийг үндэстэн дамнасан корпораци гэнэ.

Үндэстэн дамнасан корпорациуд нь эдийн засагт дараах үр ашгийг бий болгодог.

- Хөгжиж буй орнуудад гадаадын капитал ихээр орж ирэх нөхцлийг бүрдүүлдэг.
- Үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаандаа хэрэглэдэг шинэ техник технологи нь Хөгжиж Буй Орнуудын аж үйлдвэржилтийн секторыг улам боловсронгуй болгож, дэлхийн стандартад тохирсон бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нөлөөлнө.
- Үйл ажиллагаа явуулж буй улс орны ард иргэдийг ажлаар хангах болно. Энэ нь хэсэг бүлэг хүмүүсийг байнгын орлоготой болгох нөхцлийг хангаж өгдөг.

- Өөрийн үйл ажиллагаагаараа бусад оронд бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэхээс гадна тухайн улс орны ард иргэдийн хэрэгцээг давхар хангана.
- Мөн шинэ техник технологийг нэвтрүүлснээр тэр техник дээр ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэдэг.

Харин дараах сөрөг нөлөөг үзүүлдэг.

- Үндэстэн дамнасан корпораци нь хэдийгээр өөрийн салбараа нээж, шинээр техник технологийг нэвтрүүлдэгч энэ нь хөгжингүй орны нөхцөлд тохирсон байдаг. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр хэмнэсэн технологи хэрэглэдэг учраас хөгжиж буй орнууд дахь илүүдэл ажиллах хүчийг багасгаж чадахгүй юм. Энэ нь ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн үндсэн арга хэрэгсэл болох ажлын байраар хангах асуудалтай зөрчилдөж байдаг.
- Үндэстэн дамнасан корпорациуд нь маркетинг, менежментийн тал дээр тухайн улсын үндэсний үйлдвэрлэгчдийг бодвол илүү туршлага суусан, хэрэглэгчдийг татахдаа илүү байдаг.
- Хэрвээ тухайн улсад үйл ажиллагаа нь ямар нэг зүйлээс болж ашиггүй байдлыг авчирвал шууд л үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа зогсооно. Энэ нь улс орнуудад макро болон микро түвшинд эрсдэлийг бий болгодог.
- Ашиг жил ээс жилд өссөөр байх бол овч ажил чдынхаа цал инг тэр хэмжээгээр өсгөх сонирхолтой байдаггүй.

Хөгжлийн өөр нэг гол асуудал бол тогтвортой хөгжлийн талаарх ойлголт юм. Тогтвортой хөгжил гэдэг нь шийдвэр гаргах явцад эдийн засаг, нийгэм, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг цогцоор нь тусгаж, ирээдүй хойч үеийнхний хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлалгүйгээр өнөөдрийнхөө хэрэгцээг хангах явдлыг тогтвортой хөгжил гэж тайлбарладаг.

Манай улсын хувьд зах зээлийн эдийн засагт шилжсэн эхэн үетэй харьцуулахад эдийн засгийн нөхцөл байдал тогтворжсон, үр ашиг нь нэмэгдсэн үүнийг дагаад нийгмийн салбарын асуудлууд ч тодорхой хүрээнд шийдэгдэж байгаа хэдий ч байгаль экологийн асуудлууд орхигдох хандлагатай байгаа нь тогтвортой хөгжлийг бий болгох орчинг бүрдүүлж чадахгүй байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн хувьд хамгийн өндөр үр ашигтай салбар нь байгалийн нөөцөд тулгуурласан салбар болсон нь байгалийн тэнцвэрт байдлыг алдагдуулах гол түлхэц болж байна.



Хяналтын асуулт

- ▲ Үндэстэн дамнасан корпораци нь үйл ажиллагаа явуулж буй улс орны эдийн засагт ямар, ямар сөрөг үр дагаврыг бий болгодог вэ?
- ▲ Манай улсад глобалчлал ямар сул ба давуу талуудыг бий болгох вэ? аль нь илүү давамгайлна гэж бодож байна?
- ▲ Ашигт малтмал олборлолтын компаниудын улс орны эдийн засагт үзүүлж буй эерэг ба сөрөг нөлөөлөл нь юу вэ?
- ▲ Сүүлийн үед эрчим хүчний салбарт нар болон салхины энергийг ашиглах талаар их хэмжээний судалгаа, шинэ технологиуд гарч ирж байна Үүний гол шалтгаан нь юу вэ?



Ном зүй

1. С.Даваасүрэн, Хөгжлийн экономикс, УБ., 2002, 136-150 тал
2. <http://tsahimulaach.tsahimurtuu.mn/> (Дашзэвэгийн Цэрэнбатын нийтлэл)
3. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006
4. Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, УБ, 2000, 2003, 2006

2. Монгол улсын хүний хөгжил, түүнтэй холбоотой асуудлууд

- ▲ Монгол орны хүний хөгжлийн үзүүлэлтүүдийн түвшин, хүний хөгжлийн индекс
- ▲ Боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжил, эдийн засаг дахь үр өгөөж
- ▲ Манай орны хүн амын бичиг үсэгт тайлагдсан байдал, боловсролын түвшин, албан ба албан бус сургалтын хэлбэр, онцлогууд

Хүний чадвар чадавхийг хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг төдийгүй хөгжлийг урамшуулагч гол түлхүүр болдог. Эдийн засгийн үзүүлэлтүүдийн өөрчлөлт нь ихэвчлэн богино хугацааны шинж чанартай хувьсамтгай байдаг бол хүний хөгжлийн үзүүлэлтүүд нь урт хугацааны хөгжлийн шалтгаан болдог.

Монгол улсын хувьд хүний хөгжлийн үзүүлэлтүүд нь буурай хөгжилтэй улс орнуудтай харьцуулахад өндөр байдаг хэдий ч өөрчлөлт нь байнга эерэг гардаггүй нь асуудал болж байна. Хүн амын өсөлт 1979-1989 оны хооронд жилд дунджаар 2.5% байсан бол 1990-2000 оны дундаж өсөлт 1.4% болтлоо буурсан байна. Хүн амын өсөлтийн түвшний энэхүү бууралт нь шилжилтийн эдийн засгийн зарим хүндрэл, тэр тусмаа орлогын доогуур байдал, амьжиргааны түвшний бууралт зэргээс хамаарахаас гадна ардчилал чөлөөт байдал, хүний эрхийн асуудал чөлөөтэй болсон зэрэгтэй ч мөн холбоотой.

Хүний хөгжлийн өөр нэг гол асуудал бол шилжих хөдөлгөөн юм. Улс орнуудын хөгжлийн ханддагаас харахад буурай хөгжилтэй орнуудаас өндөр хөгжилтэй орнууд руу, хөдөөнөөс хот суурин руу шилжсэн шилжилт зонхилж байдаг. Манай улсын хувьд ч сүүлийн 15 жилд энэ ханддага ажиглагдаж байна. Өнөөгийн байдлаар нийт хүн амын 32.3% нь Улаанбаатар хотод амьдарч байна. (Монгол Улс зах зээлд, 2007) Энэхүү шилжих хөдөлгөөн нь 2000 оноос хойш эрс ихэссэн ба шалтгаан нь байгалийн гамшгаас болж хөдөөд амьжиргааны нөхцөл эрс муудсантай холбоотой. Хүний хөгжлийн хоёр том гол үзүүлэлт бол эрүүл мэнд болон боловсролын үзүүлэлтүүд байдаг. Эрүүл мэндийн гол үзүүлэлт нь нас баралтын түвшин, дундаж наслалт, эх нялхсын эндэгдэл зэрэг үзүүлэлт байдаг. Манай улсын хувьд сүүлийн 15 жилийн байдлаар 1000 хүнд ногдох нас баралтын түвшин 6.5 болтлоо буурсан ба дундаж наслалт 64 байна. Мөн 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 20.7 байгаа нь буурай хөгжилтэй орнуудынхтай харьцуулахад маш бага тоо юм. Энэ нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, боловсон хүчин бэлтгэх үйл явцтай холбоотой. Гэвч зарим төрлийн халдварт өвчний гаралт ихэссэн нь эрүүл мэндийн салбарын гол асуудал болж байна. Боловсролын үзүүлэлтүүдийг авч үзвэл бичиг үсэгт тайлагдсан байдал 1990 оны байдлаар 96%, сургуульд хамрагдалтын түвшин 98% байсан бол зах зээлд шилжсэн жилүүдэд сургууль завсардалтын асуудалтай холбоотойгоор энэ үзүүлэлт бага зэрэг буурсан байна.



Хяналтын асуулт

- ▲ Хөгжлийн эдийн засаг юуг судалдаг вэ?
- ▲ Боловсрол болон эрүүл мэнд нь эдийн засгийн үзүүлэлтүүдэд яаж нөлөөлдөг вэ?
- ▲ Яагаад боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын секторуудад төрийн санхүүжилт зайлшгүй шаардагддаг вэ?
- ▲ Эрүүл мэндийн даатгалын үр өгөөжтэй ба сул тал юунд орших вэ?
- ▲ Монгол улсын хувьд хүний хөгжлийг тодорхойлдог боловсролын үзүүлэлтүүд нь өндөр байдаг боловч эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл нь бага гэдэг. Үүний гол шалтгаан нь юу вэ?
- ▲ Эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог зайлшгүй хүчин зүйл нь эдийн засгийн өсөлт мөн боловч хүрэлцээтэй нөхцөл болдоггүй. Үүнийг тайлбарлана уу.
- ▲ 1990-ээд оны эхэн үед дунд боловсролын салбарт сургууль завсардалт ихэссэн нь өнөөгийн эдийн засгийн байдалд хэрхэн нөлөөлж байна вэ?



Ном зүй

1. С. Даваасүрэн, Хөгжлийн экономика, УБ., 2002, 17-19 тал
2. Ядуурлын судалгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн баг, Хүний хөгжил, УБ, 2006,
3. Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, УБ, 2000, 2003, 2006
4. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005 2006

www.legalinfo.mn - Mongolian Legal Unified Information System - Microsoft Internet Explorer

File Edit View Favorites Tools Help

Address http://www.legalinfo.mn/pages/1/page1.php

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

Өнөөдөр 2007-10-01

ҮНДСЭН НҮҮР САЙТЫН ТУХАЙ МЭДЛЭГИЙН САН ХҮҮЛИЙН ОРЧУУЛАА БАЙГУУЛАГА ЛИНК about us НОМ

Шинэ мэдээ
Эрх зүйн акт
Асуулт, харуулт
Тусламж
Хэлэлцүүлэг
Хайлт хийх

Хайлт хийх
Хайх үг:
Эрх зүйн актаас
Хайх

Хэлэлцүүлэг
Манай сайтын тухай санал
Эрх зүйн мэдээлэл монголын
2007.9 сар 02
Манай сайтын тухай санал
Хэлэлцүүлэг тухай хуулийн
талар, тэмдэг болох
2007.5 сар 09

Санал асуулга

ЭРХ ЗҮЙН АКТ 12-түсгэй дугаар ажиллаж байна.

МУХ Монгол Улсын хууль (374)
Монгол Улсын Үндсэн хууль...

УИХ Улсын Их Хурлын тогтоол (800)
Улсын Их Хурлаас баталсан тогтоол, баримт бичиг

ОУТ Монгол Улсын олон улсын гэрээ (83)
Улсын Их Хурлаас соёрмон баталсан гэрээ, конвенц

ЕЗ Ерөнхийлөгчийн зарлиг (116)
Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж, хориг

УХЦШ Улсын хуулийн цэцгийн шийдвэр (119)
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцгийн дүнлолт, шийдвэр

УДШ Улсын дээд шүүхийн тогтоол (132)
Улсын дээд шүүхийн тогтоол, шийдвэр

ЗЭГ Засгийн газрын тогтоол (2298)
Монгол Улсын Засгийн газрын газраас гаргасан тогтоол, захирамж

СТ Сайдын тушаал (797)

АДТ Засгийн газрын агентлагийн даргын тушаал (214)
Засгийн Газрын Агентлагийн даргын гаргасан тушаал, захирамж

УХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр (130)

ИТШ Аймэг, нийслэлийн ИТХ-ын шийдвэр (3)

ЗДЗ Аймэг, нийслэлийн Засаг даргын захирамж (18)

Шинэ мэдээ Нэмэгдсэн болон хянгандсан эрх зүйн акт

http://www.legalinfo.mn/pages/2/page5.php?menuid=5

www.judgeinfo.mn

www.judgeinfo.mn - Judicial information system - Microsoft Internet Explorer

File Edit View Favorites Tools Help

Address http://www.judgeinfo.mn/pages/1/page1.php

ШҮҮХИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Нэр хууцаас | Асуулт харуулт | Сайтын тухай | Холбоо барих | Лавч |

Хайлт хийх
Хайх үг:
Төрөл: Шүүхийн мэдээллийн сангаас
Хайх

ШҮҮХ, ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО
Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа шүүхийн системийн талаарх мэдээлэл.

МАЯГТ БҮРДҮҮЛЭХҮҮД
Шүүхийн системд ажиллаж байгаа маягт, формуд болон бусад бичгийг эндээс хан болонхтой.

Энэхүү сайт нь туршигтын хугацаандаа нэвч байгаа болно.

- УИХ-ийн дарга, хэргийн мөхөөчч чөлөөтэй тогтоол (5)
- Ерөнхий шүүхийн захирамж (43)
- Танхимчуудад гаргасан тойм зөвлөмж (29)
- Шүүхийн ерөнхий шийдвэрийн тогтоол (12)

ШИНЭ МЭДЭЭ
2007-09-25
Мэдээ
1. 2007 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр 21-н өдөр 10-н сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Унгар улсын Будапешт хотноо Ардчилсан цогцолтой дүнхч олон улсын төвөөс зохион байгуулсан "...
Дэлгэрнэ

2007-09-13
Мэдээ
Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдан Бүгд Найрамдах Банкныг айлтгын Сүн дундын шүүхэд, П.Тууяг Говь-Алтай айлтгын Сүн дундын шүүхэд, Я.Тууяг Дундговь айлтгын Сүн дундын шүүхэд, ...
Дэлгэрнэ

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
Манай системийн тухай
Н.Т.Н.М.М.
2007.8 сар 04
Шүүхийн байгууллагын тухай
Ш.Х.
2006.9 сар 28

ХЭРГИЙН БҮРТЭЛ
Хяналтын шатны шүүх
Хяналтын шатны шүүхийн хэргийн бүртгэл
Данж заалдан шатны шүүх
Данж заалдан шатны шүүхийн хэргийн бүртгэл
Аюул шатны шүүх
Аюул шатны шүүхийн хэргийн бүртгэл

ХЯЛЦЛАГА
Ц.ЗОРИГ: ШҮҮХЭЭС ШАЛГАЛЖ ШҮҮХ
УЛААНБААТАР ШҮҮХИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

Done

